



Хууль зүйн
үндэсний хүрээлэн

**МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ БА
ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН НИЙЦЭЛ**
(Зарим төрлийн гэмт хэргийн ойлголт, үндсэн
шинж, эрүүгийн хариуцлага)

2022

СУДАЛГААНЫ ТАЙЛА

Хянасан:

Х. Эрдэм-Ундрах	Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал, Хууль зүйн ухааны доктор
-----------------	---

Удирдсан:

С.Сүхбаатар	Эрдэмтэн нарийн бичгийн дарга, Хууль зүйн ухааны доктор
-------------	--

Б. Энх-Амгалан	Эрдэм шинжилгээний ахлах ажилтан
----------------	----------------------------------

Судалгааг гүйцэтгэсэн:

Д. Дэмидханд	Эрдэм шинжилгээний ажилтан
--------------	----------------------------

Х. Мөнгөнчимэг	Эрдэм шинжилгээний ажилтан
----------------	----------------------------

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АНУ- Америкийн Нэгдсэн Улс

БНХАУ- Бүгд Найрамдах Хятад Ард Улс

ДХИС- Дотоод хэргийн их сургууль

НҮБ- Нэгдсэн Үндэсний Байгууллага

ОУ- Олон улс

ХЗДХЯ- Хууль зүй, дотоод хэргийн яам

ХЗҮХ- Хууль зүйн үндэсний хүрээлэн

ХСИХ- Хууль сахиулахын их сургууль

ЦЕГ- Цагдаагийн ерөнхий газар

ЭХ- Эрүүгийн хууль

АГУУЛГА

ХУРААНГУЙ	7
УДИРТГАЛ	9
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ХҮЧЭЭР АЛГА БОЛГОХООС БҮХ ХҮНИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ ОЛОН УЛСЫН КОНВЕНЦ	16
А. Хүнийг хүчээр алга болгох гэмт хэргийн ойлголт, үндсэн шинж	16
Б. Монгол Улсын Эрүүгийн хуулийн нийцэл	17
1. Тухайн хүний хүсэл зоригийн эсрэг эрх чөлөөг нь хассан байх шинж (баривчлах, саатуулах, хулгайлах, эсхүл бусад хэлбэрээр)	17
2. Энэ нь төрийн төлөөлөгч, түүний зөвшөөрөлтэйгөөр, үйл ажиллагаа явуулж буй хүмүүстэй холбоотой байх, наад зах нь тэдгээр нь шууд бусаар хүлээн зөвшөөрснөөр үйлдэгдсэн байх шинж.....	18
3. Эрх чөлөөг нь хассаныг хүлээн зөвшөөрөхөөс татгалзаж, алга болсон хүний хувь заяа, байгаа газрыг нь нуун дарагдуулсан байх шинж.....	20
4. Хуулийн хамгаалалтаас гадуур байлгах шинж	21
5. Хохирол, хор уршиг учирсан байх шинж.....	21
6. Конвенцийн дагуу хүлээсэн үүрэг	21
В. Дүгнэлт	22
ХОЁРДУГААР БҮЛЭГ. АГААРЫН ХӨЛГИЙН БҮХЭЭГТ ҮЙЛДСЭН ГЭМТ ХЭРЭГ БОЛОН ТОДОРХОЙ БУСАД ҮЙЛДЛИЙН ТУХАЙ КОНВЕНЦ	23
А. Агаарын хөлгийн бүхээгт үйлдсэн гэмт хэрэг болон тодорхой бусад үйлдлийн ойлголт, үндсэн шинж.....	23
Б. Монгол Улсын Эрүүгийн хуулийн нийцэл	24
В. Дүгнэлт	25
ГУРАВДУГААР БҮЛЭГ. АГААРЫН ХӨЛГИЙГ ХУУЛЬ БУСААР БУЛААН АВАХ ҮЙЛДЛИЙГ ХОРИГЛОХ ТУХАЙ КОНВЕНЦ	26
А. Агаарын хөлгийг хууль бусаар булаан авах гэмт хэргийн ойлголт, үндсэн шинж.....	26
Б. Монгол Улсын Эрүүгийн хуулийн нийцэл	26
1. Агаарын хөлгийг булаан авах буюу хяналтаа тогтоох үйлдэл	26
2. Хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх, эсхүл бусад хэлбэрээр айлган сүрдүүлсэн байх шинж.....	27
3. Хүч хэрэглэх, заналхийлэх үйлдлийн хууль бус байдал.....	28
4. Нислэг үйлдэж буй агаарын хөлгийн бүхээгт үйлдэгдсэн байх шинж.....	28
5. Гэмт хэргийн субъект	29
6. Конвенцийн дагуу хүлээх үүрэг	30
В. Дүгнэлт	31

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ИРГЭНИЙ НИСЭХИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЭСРЭГ ХУУЛЬ БУС ҮЙЛДЛИЙГ ХОРИГЛОХ ТУХАЙ МОНРЕАЛИЙН КОНВЕНЦ 31

А. Иргэний нисэхийн аюулгүй байдлын эсрэг хууль бус үйлдлүүдийн ойлголт, үндсэн шинж.....	32
1. Конвенцийн хамрах хүрээ.....	33
Б. Монгол Улсын Эрүүгийн хуулийн нийцэл	33
1. Нислэг үйлдэж буй агаарын хөлгийн бүхээгт яваа хүний эсрэг хүчирхийлсэн бөгөөд энэ нь тухайн агаарын хөлгийн аюулгүй байдалд аюул учруулах гэмт хэрэг	33
2. Нислэг хийх боломжгүй болгох буюу нислэгийн үед аюул учруулахуйц байдлаар, ашиглалтад байгаа агаарын хөлгийг устгасан, эсхүл түүнд гэмтэл учруулах гэмт хэрэг	39
3. Ашиглалтад байгаа агаарын хөлгийг устгах, эсхүл нислэг үйлдэх боломжгүй болохуйц гэмтэл учруулах, эсхүл нислэгийн үед агаарын хөлгийн аюулгүй байдалд аюул учруулахуйц гэмтээх төхөөрөмж, бодисыг ямар нэг аргаар ашиглалтад байгаа агаарын хөлөгт байрлуулах буюу байрлуулахад чиглэсэн үйл ажиллагаа явуулах гэмт хэрэг.....	41
5. Худал гэдгийг нь мэдсээр байж мэдээлэл өгснөөр нислэг үйлдэж буй агаарын хөлгийн аюулгүй байдалд аюул учруулах гэмт хэрэг.....	43
6. Гэмт хэргийн субъект	43
7. Санаатай болон хууль бусаар гэмт хэрэг үйлдэх нь	44
8. Конвенцийн дагуу хүлээх үүрэг	44
В. Дүгнэлт	45

ТАВДУГААР БҮЛЭГ. ИРГЭНИЙ НИСЭХИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЭСРЭГ ХУУЛЬ БУС ҮЙЛДЛИЙГ ХОРИГЛОХ ТУХАЙ МОНРЕАЛЬ ХОТНОО 1971 ОНЫ 9 ДҮГЭЭР САРЫН 23-НЫ ӨДӨР ҮЙЛДСЭН КОНВЕНЦИЙН ОУ-ЫН ИРГЭНИЙ НИСЭХЭД ҮЙЛЧИЛДЭГ НИСЭХ БУУДАЛ ДАХЬ ХҮЧИРХИЙЛСЭН ХУУЛЬ БУС ҮЙЛДЛИЙГ ХОРИГЛОХ ТУХАЙ НЭМЭЛТ ПРОТОКОЛ..... 47

А. Гэмт хэргийн ойлголт, үндсэн шинж.....	47
Б. Монгол Улсын Эрүүгийн хуулийн нийцэл	48
В. Дүгнэлт	49

ЗУРГАДУГААР БҮЛЭГ. МАНСУУРУУЛАХ ЭМИЙН ТУХАЙ НЭГДСЭН КОНВЕНЦ 50

А. Гэмт хэргийн ойлголт, үндсэн шинж.....	50
Б. Монгол Улсын Эрүүгийн хуулийн нийцэл	51
В. Дүгнэлт	52

ДОЛДУГААР БҮЛЭГ. СЭТГЭЦЭД НӨЛӨӨЛӨХ БОДИСЫН ТУХАЙ КОНВЕНЦ53

А. Гэмт хэргийн ойлголт, үндсэн шинж.....	53
Б. Монгол Улсын Эрүүгийн хуулийн нийцэл	54
В. Дүгнэлт	55

НАЙМДУГААР БҮЛЭГ. МАНСУУРУУЛАХ ЭМ, СЭТГЭЦЭД НӨЛӨӨЛӨХ БОДИСЫН ХУУЛЬ БУС ЭРГЭЛТИЙН ЭСРЭГ НҮБ-ЫН КОНВЕНЦ	56
А. Гэмт хэргийн ойлголт, үндсэн шинж	56
Б. Монгол Улсын Эрүүгийн хуулийн нийцэл	58
1. Конвенцийн 3 дугаар зүйлийн 1.a) хэсэгт заасан гэмт үйлдлүүд	58
2. Конвенцийн 3 дугаар зүйлийн 1.b) хэсэгт заасан гэмт үйлдлүүд	59
3. Конвенцийн холбогдох бусад зүйлд заасан гэмт хэргүүд.....	60
4. Хамтран оролцогчдод хүлээлгэх хариуцлага	61
5. Гэмт хэргийн хүндрүүлэх нөхцөл.....	61
В. Дүгнэлт	63
Ерөнхий дүгнэлт	64
Санал, зөвлөмж	68
Ном зүй	72
Хавсралт	1

ХУРААНГУЙ

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дугаар тогтоолын хавсралтаар баталсан Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.4.7-д “Эрүүгийн хууль тогтоомжийн эрх зүйн шинэчлэлийг гүнзгийрүүлж, гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тогтолцоо, бодлого, арга барилыг боловсронгуй болгоно.” гэж тусгасан. Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, түүний хүрээний зөвлөмжид Эрүүгийн хуулийн зарим зохицуулалтыг бүрэн нийцүүлэх шаардлага бий.

Дээр дурдсан судалгааны хэрэгцээг харгалзан, Хууль зүйн үндэсний хүрээлэн 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөндөө “Монгол Улсын олон улсын гэрээнд заасан шинэ төрлийн гэмт хэрэг ба Эрүүгийн хууль” сэдвийн хүрээнд судалгаа хийхээр тусгасан. Үүний хүрээнд “Монгол Улсын олон улсын гэрээ ба Эрүүгийн хуулийн нийцэл: Зарим төрлийн гэмт хэргийн ойлголт, үндсэн шинж, эрүүгийн хариуцлага” сэдвээр судалгаа хийлээ.

Энэхүү судалгаагаар, Монгол Улсын олон улсын гэрээнд заасан зарим төрлийн гэмт хэргийн ойлголт, үндсэн шинж, эрүүгийн хариуцлагатай холбоотой хэм хэмжээг Эрүүгийн хуульд тусгасан байдлыг судалж, нийцлийг дүгнэн, зөрчлийг тодруулж, Эрүүгийн хуулийн холбогдох зохицуулалтыг боловсронгуй болгоход чиглэсэн санал, зөвлөмж дэвшүүлэв.

Судалгаанд, Хүчээр алга болгохоос бүх хүнийг хамгаалах тухай олон улсын конвенц, Агаарын хөлгийн бүхээгт үйлдсэн гэмт хэрэг болон тодорхой бусад үйлдлийн тухай Токиогийн конвенц, Агаарын хөлгийг хууль бусаар булаан авах үйлдлийг хориглох тухай Гаагийн конвенц, Иргэний нисэхийн аюулгүй байдлын эсрэг хууль бус үйлдлийг хориглох тухай Монреалийн конвенц болон түүний нэмэлт протокол, Мансууруулах эмийн тухай нэгдсэн конвенц, Сэтгэцэд нөлөөлөх бодисын тухай конвенц, Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг НҮБ-ын конвенцийн холбогдох хэм хэмжээг Эрүүгийн хуульд тусгасан байдлыг харьцуулж, нийцлийг дүгнэсэн.

Ингэхдээ, энэхүү судалгааны хүрээнд боловсруулсан шалгуур үзүүлэлт буюу Монгол Улсын олон улсын гэрээнд заасан гэмт хэргийг Эрүүгийн хуульд тусгасан (тусгасан: бүрэн, бүрэн бус, зөрчилтэй, өргөжүүлсэн, эсвэл огт тусгаагүй гэх мэт) байдал; Монгол Улсын олон улсын гэрээнд заасан гэмт хэргийн ойлголт, үндсэн шинж, эрүүгийн хариуцлагатай холбоотой хэм хэмжээнд Эрүүгийн хуулийг нийцүүлсэн эсэх; Эрүүгийн хуулийн холбогдох заалт хэл зүйн болон найруулгын шаардлага (нэр томьёо, үг хэллэг) -ын хувьд Монгол Улсын олон улсын гэрээтэй уялдсан эсэх гэсэн шалгуур үзүүлэлтүүдийг ашиглав.

Судалгааны тайлан Удиртгал, 8 бүлэг, Ерөнхий дүгнэлт, Санал, Зөвлөмж, Ном зүй, Хавсралт хэсгээс бүрдэнэ. Удиртгалын эхэн хэсэгт, Монгол Улсын Үндсэн хуулийн зарчим, үзэл баримтлалын дагуу Монгол Улсын олон улсын гэрээнд Эрүүгийн хуулийг нийцүүлэх эрх зүйн үндэслэл болон практик хэрэгцээ, шаардлагыг товч илэрхийлэв. Судалгааны зорилго, зорилт, шалгуур үзүүлэлт, судалгааны арга зүй, хамрах хүрээ болон судалгаагаар хүрсэн үр дүн, ач холбогдлыг танилцуулахаас гадна сэдвийн судлагдсан байдлыг дэлгэрэнгүй тусгалаа.

Тайлангийн 8 бүлэг нь судалгаанд хамрагдсан нэр бүхий Монгол Улсын олон улсын гэрээний нэрээр нэрлэгдсэн бөгөөд тухайн олон улсын гэрээнд заасан гэмт хэргийн ойлголт, үндсэн шинжийг бүлгийн эхэн хэсэгт танилцуулж, үүнийг Эрүүгийн хуульд хэрхэн тусгасан байдлыг “Эрүүгийн хуулийн нийцэл” хэсэгт шинжлэн судлав. Бүлэг тус бүрийн төгсгөлд хэсгийн дүгнэлт бичсэн. Эдгээр дүгнэлтээс нийтлэг талыг түүвэрлэн Ерөнхий дүгнэлтэд оруулав. Нийцлийг дүгнэж, зөрчлийг тодруулсны үндсэн дээр Эрүүгийн хуулийн холбогдох зохицуулалтыг боловсронгуй болгох чиглэлээр санал дэвшүүлж, тайлангийн Санал, зөвлөмж хэсэгт багцалсан.

Судалгаанд хамрагдсан Монгол Улсын олон улсын гэрээгээр зохицуулсан, хүчээр алга болгохоос бүх хүнийг хамгаалах; иргэний нисэхийн аюулгүй байдлыг хангах; мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх чиглэлийн эсрэг гэмт хэргийн төрлүүдийг Эрүүгийн хуульд ерөнхийдөө тусгасан байгаа ч нийцлийн хувьд хангалтгүй тал нийтлэг байв. Монгол Улсын олон улсын гэрээнд заасан гэмт хэргийн тодорхойлолт, шинж, эрүүгийн хариуцлагатай холбоотой хэм хэмжээнд Эрүүгийн хуулийг нийцүүлсэн байдал харилцан адилгүй байгааг бүлэг тус бүрээс нарийвчлэн үзэх боломжтой.

Судалгаанд хамрагдсан 8 гэрээний, судлахаар сонгосон хүрээнд холбогдох 46 хэм хэмжээг Эрүүгийн хуульд тусгасан байдалд дүн шинжилгээ хийсний үндсэн дээр нийцлийг тоон үзүүлэлтээр болон хувьчлан тооцож, тайлангийн Ерөнхий дүгнэлт хэсэгт дурдав. Ийнхүү Монгол Улсын олон улсын гэрээ ба Эрүүгийн хуулийн нийцэл хангалтгүй байгааг тоон үзүүлэлтүүдээр мөн илэрхийлсэн. Гэхдээ Монгол Улсын олон улсын гэрээнд заасан гэмт хэргийн төрлүүдийг ЭХ-д тусгахдаа гэмт хэрэгт хамтран оролцох, хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх, шийтгэхээс бусад арга хэмжээ авах, урамшууллын аргыг эрх зүйд ашигласан зохицуулалтыг хуульчилсан зэрэг сайн талыг судалгааны тайланд дурдсан болно.

Хууль тогтоомжийн тухай хуулийн хүрээнд батлагдсан аргачлалын дагуу, хууль тогтоомжийн төсөл нь Үндсэн хуульд нийцэж буй эсэхийг нягтлахаас гадна Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хууль тогтоомжтой нийцэж буйг судалдаг. Гэтэл судалгаанд хамрагдсан Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хэм хэмжээ ба Эрүүгийн хуулийн нийцэл хангалттай бус байна. Энэ нь Хууль тогтоомжийн тухай хууль батлагдаж хэрэгжихээс өмнө 2015 оны Эрүүгийн хууль батлагдсантай холбоотой байх магадлалтай. Гэвч, Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд Хүчээр алга болгохоос бүх хүнийг хамгаалах тухай олон улсын конвенцийн нийцлийг хангах нөхцөлийг бүрдүүлээгүй байгааг мөн тус судалгаанд онцолсон. ЭХ-ийн холбогдох зохицуулалт хэл зүйн болон найруулгын шаардлага (нэр томьёо, үг хэллэг) - ын хувьд олон улсын гэрээтэй уялдсан байдал харилцан адилгүй гэж дүгнэгдсэн. Энэ нь олон улсын гэрээний орчуулгын чанараас хамаарч байгааг дурдав. Эдгээрээс улбаалан дотоодын хууль тогтоомжийг олон улсын гэрээнд нийцүүлэхтэй холбоотой нийтлэг арга зүйн асуудлыг цаашид тууштай шийдвэрлэх тухайд Ерөнхий зөвлөмж бичлээ.

Энэхүү судалгаанд, Монгол Улсын эрх зүйн хүрээнд “шинэ төрлийн” гэж тооцогдох гэмт хэрэг, тухайлбал хүнийг хүчээр алга болгох гэмт хэрэг; өнөөгийн байдлаар Монгол Улсад бүртгэгдээгүй ч олон улсын хэмжээнд онц ноцтой аюул учруулдаг гэмт хэргүүд болох иргэний нисэхийн харилцаа, агаарын хөлөг, олон улсын нисэх буудлын аюулгүй байдалтай холбоотой гэмт хэрэг; хүрээгээ тэлж улам өсөн

нэмэгдэж буй мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодис, тэдгээрийн хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэргүүдтэй тэмцэх хүрээний олон улсын гэрээнүүдийг тус тус сонгон судалж, гэмт хэргийн тодорхойлолт, үндсэн шинж, эрүүгийн хариуцлагатай холбоотой хэм хэмжээг түүвэрлэн, Монгол Улсын Эрүүгийн хуульд тусгасан байдлыг тодруулж, нийцлийг дүгнэн, цаашид тус хуулийг боловсронгуй болгох чиглэлээр санал, зөвлөмж дэвшүүлснээрээ суурь ач холбогдол оршино. Ингэснээр Эрүүгийн хууль ба Монгол Улсын олон улсын гэрээний нийцлийг сайжруулж, олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ эрх зүйн хүрээнд биелүүлэх үйл хэрэгт дэмжлэг үзүүлнэ хэмээн найдаж байна.

УДИРТГАЛ

Үндэсний эрх зүй ба ОУ-ын эрх зүйн харилцан хамаарал, хоорондын хүчний асуудал анхаарал татсан хэвээр байна. Гадаад харилцаа, хамтын ажиллагааг бэхжүүлэх, хүний эрх, эрх чөлөөг хангах, гэмт хэрэгтэй тэмцэх, хүрээлэн буй орчныг хамгаалах, хүн ам зүйн асуудлыг шийдвэрлэх, шинжлэх ухаан, технологийг хөгжүүлж, дэвшлийн үр дүнг зохистой ашиглах, олон туйлт шинэ дэг журамд шилжих зэрэг дэлхий нийтийг хамарсан харилцаа нь ОУ-ын эрх зүй ба үндэсний эрх зүйн холбоо хамаарлыг улам бүр гүнзгийрүүлсэн.

1992 онд шинэ Үндсэн хууль батлагдсанаар Монгол Улсад дотоодын эрх зүй ба ОУ-ын эрх зүйн харилцан хамаарал, эрэмбийн хувьд шинэ зохицуулалт бий болов. Монголын ард түмний эрхэм зорилго, үзэл баримтлалаа эрх зүйн хөгжлийн үнэт зүйлтэй холбож, Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улс ОУ-ын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг баримталж энхийг эрхэмлэсэн гадаад бодлого явуулна.” гэж томъёолсон.

“Монгол Улс Үндсэн хуульдаа харшилсан ОУ-ын гэрээ, бусад баримт бичгийг дагаж мөрдөхгүй.”¹ гэдгээ илэрхийлэхийн зэрэгцээ “Монгол Улс ОУ-ын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ.”², “Монгол Улсын ОУ-ын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ.”³, “Монгол Улсын хууль, ОУ-ын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсэн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах эрхтэй”⁴ хэмээн Үндсэн хуульдаа баталгаажуулсан. Эдгээр нь ОУ-ын гэрээнд нэгдэн орохдоо хариуцлагатай хандах, нэгэнтээ нэгдсэн тохиолдолд үүргээ заавал биелүүлэх ёстой учир нухацтай судалсны үндсэн дээр шийдвэр гаргах тухай гүн утгыг агуулж байна. Мөн ОУ-ын эрх зүйн хэм хэмжээг үндэсний эрх зүйд хэрэглэхтэй холбоотой гол үзэл баримтлал болдог.⁵

Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэж заасан. Төр энэ чиг үүргээ хэрэгжүүлэхдээ ОУ-ын гэрээ болон ОУ-ын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг дотоодын эрх

¹ Монгол Улсын Үндсэн хууль, 10.4 дүгээр зүйл.

² Мөн зүйлийн 2 дахь хэсэг.

³ Мөн зүйлийн 3 дахь хэсэг.

⁴ Монгол Улсын Үндсэн хууль, 16.14 дэх хэсэг.

⁵ Б.Энх-Амгалан, ОУ-ын гэрээнд нэгдэн ороход судалгаатай хандах асуудал, *Хууль дээдлэх ёс*, №3, 2010 он https://nli.gov.mn/pdf/olon_ulsin_gereend_negden_oroh.pdf [Сүүлд үзсэн: 2022.06.22].

зүйн тогтолцооны нэг хэсэг болгох арга хэлбэрийг өргөн ашигладаг. Манай улс 2022 оны 6 дугаар сарын 1-ний байдлаар 304 ОУ-ын олон талт гэрээнд нэгдэн орсноос хүний эрхийн холбогдолтой 40 гаруй гэрээ, хэлэлцээр, тэдгээрийн нэмэлт протоколд гарын үсэг зурж, соёрхон баталсан байна. Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж буй 800 гаруй хуулийн ихэнх хуульд “Монгол Улсын ОУ-ын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол ОУ-ын гэрээний заалтыг дагаж мөрдөнө” гэсэн хэм хэмжээ бий.

2008 онд ХЗҮХ-ийн хийсэн “Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрийн хяналт, шинжилгээ, үнэлгээний тайлан”-д хуулийн төсөл боловсруулахдаа ОУ-ын гэрээг харгалздаг хэдий ч үндэсний хууль тогтоомжийг тухайн ОУ-ын гэрээнд нийцүүлэх ажил дутагдалтай хэрэгжилт хангалтгүй⁶ гэж үнэлсэн байдаг. Харин 2016 онд ХЗҮХ-ийн хийсэн “Эрх зүйн шинэтгэлийн бодлогын баримт бичиг боловсруулахад дэмжлэг үзүүлэх нь” сэдэвт судалгааны тайланд, 2008 -2012 оны хооронд, Монгол Улсын хоёр болон олон талт ОУ-ын гэрээ ба бусад хууль тогтоомжийн нийцэл ба нийцүүлэхтэй холбоотой сэдвээр судалгаа шинжилгээ хийж, тогтоогдсон үр дүн, зөрчлийг арилгах арга замын талаарх санал, зөвлөмжийг холбогдох байгууллагуудад хүргүүлж, нөлөөллийн үйл ажиллагаа явуулсны дүнд тодорхой дүн гарсан; Гэсэн ч хууль тогтоомжийг ОУ-ын гэрээнд нийцүүлэх асуудалд ул суурьтай нэгдсэн байдлаар хандаж, нийцлийг судалж тогтоох асуудал тууштай, үндэсний хэмжээний зорилт болж цогц байдлаар шийдвэрлэгдэж чадаагүй үлдсэн; Шинээр баталж буй хууль тогтоомжийг Монгол Улсын ОУ-ын гэрээнд нийцүүлэх байдал хангалттай хэрэгжиж байна гэж үзэв; Цаашдаа Хууль тогтоомжийн тухай хууль ба түүний хүрээнд батлагдах аргачлалууд, түүнчлэн ОУ-ын гэрээний тухай хууль шинэчлэн батлагдаж хэрэгжсэнээр ОУ-ын эрх зүй ба үндэсний эрх зүйн уялдаа холбоо, нийцлийн асуудал улам сайжирна гэж төсөөлж байна⁷ хэмээн дүгнэжээ.

Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу хууль тогтоомжийн төсөл боловсруулах ажлын арга зүй сайжирч, тодорхой аргачлалуудын дагуу судалгаа хийх болсны дүнд тухайн хууль тогтоомж үзэл баримтлалын хувьд Монгол Улсын ОУ-ын гэрээнд нийцэх эсэх, хэрхэн уялдах, хэл зүй, найруулгын хувьд шаардлага хангасан эсэх зэрэг шалгуурын дагуу хууль тогтоомжийг ОУ-ын гэрээнд нийцүүлэх ажиллагаа урьдчилан хийгддэг болсон.

ОУ-ын гэрээг шүүхэд хэрэглэх асуудал ОУ-ын гэрээ ба бусад хууль тогтоомжийн нийцлийг хөнддөг. Улсын Дээд шүүхийн 2008 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн 09 дугаартай, “Монгол Улсын ОУ-ын гэрээ болон ОУ-ын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг шүүхийн практикт хэрэглэх тухай” тогтоолд “Монгол Улсын ЭХ-ийн 3 дугаар зүйлийн 3.1-д “Үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцох, түүнд оногдуулах ял, эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээг зөвхөн энэ хуулиар тодорхойлно” гэж заасан тул ЭХ-д тусгайлан заасан тохиолдолд л эрүүгийн гэмт хэргийн шинжийг тодорхойлсон ОУ-ын эрх зүйн хэм хэмжээг шүүхүүд хэрэглэж болно; Эрүүгийн гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжийг тусгасан хэм хэмжээ бүхий ОУ-ын гэрээнд үндэсний хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулснаар гэрээний хэрэгжилт хангагдах талаар заасан байдаг тул ЭХ-д заагдаагүй гэмт хэргийн бүрэлдэхүүнийг тодорхойлсон Монгол Улсын ОУ-ын гэрээний заалтыг шүүхүүд хэрэглэхгүй.” гэжээ.

⁶ ХЗҮХ, *Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрийн хяналт, шинжилгээ, үнэлгээний тайлан*, Уб, 2008, 410 дахь тал.

⁷ ХЗҮХ, *Эрх зүйн шинэтгэлийн бодлогын баримт бичиг боловсруулахад дэмжлэг үзүүлэх нь, судалгааны Хавсралт тайлан 1*, Уб, 2016, 319 дэх тал.

Дээр дурдсан тогтоолд тухайн үед үйлчилж байсан 2002 оны ЭХ-ийн хэм хэмжээ тусгагдсан хэдий ч ЭХ-д заасан гэмт хэргийн шинжийг тусгасан хэм хэмжээ бүхий ОУ-ын гэрээг шүүхэд хэрэглэх гол зарчмыг тодорхойлсон нь ач холбогдолтой. Өнөө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй 2015 оны ЭХ-ийн 1.2 дугаар зүйлийн 4-т “Энэ хуулийн нэр томъёо, ухагдахууныг тайлбарлахад Монгол Улсын хууль, Монгол Улсын хуулиар соёрхон баталсан, нэгдэн орсон ОУ-ын гэрээнд заасан тодорхойлолт, хэм хэмжээг баримтална.” гэж заасан. Иймд Монгол Улсын ОУ-ын гэрээнд ЭХ тогтоомжийг нийцүүлэх асуудал чухал бөгөөд шүүхэд ОУ-ын гэрээг хэрэглэх, улмаар ОУ-ын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх үндэс болж байна.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дугаар тогтоолын хавсралтаар баталсан Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр⁸-ийн 4.4.7-д “ЭХ тогтоомжийн эрх зүйн шинэчлэлийг гүнзгийрүүлж, гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тогтолцоо, бодлого, арга барилыг боловсронгуй болгоно.” гэж тусгасан. Түүнчлэн Монгол Улсын нэгдэн орсон ОУ-ын гэрээ конвенц, зөвлөмжид ЭХ-ийн зарим зохицуулалтыг бүрэн нийцүүлэх шаардлага тулгараад байна.⁹

Энэхүү хэрэгцээ, шаардлагыг харгалзан ХЗҮХ 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөндөө “Монгол Улсын ОУ-ын гэрээнд заасан шинэ төрлийн гэмт хэрэг ба ЭХ” сэдвийн хүрээнд судалгаа хийхээр тусгасан. Үүний хүрээнд “Монгол Улсын ОУ-ын гэрээ ба ЭХ-ийн нийцэл: Зарим төрлийн гэмт хэргийн ойлголт, үндсэн шинж, эрүүгийн хариуцлага” сэдвээр судалгаа хийв.

Судалгааны зорилго. Монгол Улсын ОУ-ын гэрээнд заасан зарим төрлийн гэмт хэргийн ойлголт, шинж, эрүүгийн хариуцлагатай холбоотой хэм хэмжээг ЭХ-д тусгасан байдлыг судалж, нийцлийг дүгнэн, зөрчлийг тодруулж, ЭХ-ийн холбогдох зохицуулалтыг боловсронгуй болгоход чиглэсэн санал, зөвлөмж дэвшүүлэхэд энэхүү судалгааны зорилго оршино.

Судалгааны зорилт. Энэхүү судалгаа дараах зорилттой. Үүнд:

1. Монгол Улсын ОУ-ын гэрээ (Хүчээр алга болгохоос бүх хүнийг хамгаалах тухай ОУ-ын конвенц, Агаарын хөлгийн бүхээгт үйлдсэн гэмт хэрэг болон тодорхой бусад үйлдлийн тухай Токиогийн конвенц, Агаарын хөлгийг хууль бусаар булаан авах үйлдлийг хориглох тухай Гаагийн конвенц, Иргэний нисэхийн аюулгүй байдлын эсрэг хууль бус үйлдлийг хориглох тухай Монреалийн конвенц болон тус конвенцийн нэмэлт протокол, Мансууруулах эмийн тухай нэгдсэн конвенц, Сэтгэцэд нөлөөлөх бодисын тухай конвенц, Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг НҮБ-ын конвенц)-нд заасан гэмт хэргийн ойлголт, үндсэн шинж, эрүүгийн хариуцлагатай холбоотой хэм хэмжээг Монгол Улсын ЭХ-д тусгасан байдлыг харьцуулж судлах;

2. Дор дурдсан шалгуур үзүүлэлтийн дагуу ОУ-ын гэрээ ба ЭХ-ийн нийцлийг тодорхойлох:

⁸ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=211219&showType=1> [Сүүлд үзсэн: 2022.06.08].

⁹ Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал, Уб, 2022, 1 дэх тал <http://forum.parliament.mn/projects/11281> [Сүүлд үзсэн: 2022.05.10].

- Монгол Улсын ОУ-ын гэрээнд заасан гэмт хэргийг ЭХ-д тусгасан (тусгасан: бүрэн, бүрэн бус, зөрчилтэй, өргөжүүлсэн, эсвэл огт тусгаагүй гэх мэт) байдал;

- Монгол Улсын ОУ-ын гэрээнд заасан гэмт хэргийн ойлголт, үндсэн шинж, эрүүгийн хариуцлагатай холбоотой хэм хэмжээнд ЭХ-ийг нийцүүлсэн эсэх;

- ЭХ-ийн холбогдох заалт хэл зүйн болон найруулгын шаардлага (нэр томьёо, үг хэллэг) -ын хувьд Монгол Улсын ОУ-ын гэрээтэй уялдсан эсэх.

3. ЭХ-ийн холбогдох зохицуулалтыг Монгол Улсын ОУ-ын гэрээнд нийцүүлэхэд чиглэсэн санал, зөвлөмж боловсруулах.

Судалгааны арга зүй. Монгол Улсын ОУ-ын гэрээний хэм хэмжээ ба ЭХ-ийн зохицуулалтыг судалж харьцуулахад баримт бичгийн судалгааны арга, харьцуулалтын арга, хууль зүйн техник, хууль тайлбарлах зэрэг судалгааны арга; Нийцлийг судлахад харьцуулалтын арга, задлан шинжлэх ба нэгтгэн дүгнэх аргыг ашиглаж, зөрүүтэй байдал үүсвэл Монгол Улсын 2002 оны ЭХ-ийн зохицуулалтыг түүхчлэн судлах зэрэг арга; тодорхой дүгнэлтэд хүрч, дотоодын хууль тогтоомжийг ОУ-ын гэрээний хэм хэмжээнд нийцүүлэхэд чиглэсэн санал, зөвлөмж дэвшүүлэхийн тулд индукц, дедукцийн нэгдэл зэрэг логик арга зүйг энэхүү судалгаанд ашиглав.

Судалгааны хамрах хүрээ. Судалгааг ОУ-ын эрх зүйн болон Үндсэн хууль, эрүүгийн эрх зүйн онол, арга зүй, туршлагад тулгуурлан холбогдох ОУ-ын эрх зүйн хэм хэмжээ, эх сурвалж болон Монгол Улсын ЭХ-ийн зохицуулалтын хүрээнд явуулав. Сонгон судалсан ОУ-ын гэрээнд заасан гэмт хэргийн ойлголт, үндсэн шинж, эрүүгийн хариуцлагатай холбоотой хэм хэмжээг түүвэрлэж, ЭХ-д хэрхэн тусгасан байдлыг харьцуулж судалсан. Монгол Улсын ОУ-ын гэрээ ба ЭХ-д тусгасан тухайн гэмт хэргийн төрөлд холбоотой судалгааны эх сурвалжууд, тэдгээрийг тайлбарлах, харьцуулж дүгнэхэд холбогдох арга зүй болон туршлагад тулгуурлан, ЭХ-ийг ОУ-ын гэрээнд нийцүүлэхэд чиглэсэн санал, зөвлөмж боловсруулах зорилгоор өмнө судлагдсан үр дүнг мөн тусгалаа. Харин ОУ-ын гэрээнд заасан бусад асуудал, тухайлбал хохирол нөхөн төлөх, мөрдөн шалгах ажиллагаа явуулах, хэргийн харьяалал тогтоох, гэмт этгээдийг шилжүүлэх болон ОУ-ын хамтын ажиллагааны хүрээ зэрэг асуудлыг энэхүү судалгаанд хамруулаагүй болно.

Судалгааны ажлын хүрсэн үр дүн. Монгол Улсын ОУ-ын гэрээнд заасан зарим төрлийн гэмт хэргийн ойлголт, үндсэн шинж, эрүүгийн хариуцлагатай холбоотой хэм хэмжээг ЭХ-д тусгасан байдлыг судалж, нийцлийг дүгнэн, зөрчлийг тодруулж, ЭХ-ийн холбогдох зохицуулалтыг боловсронгуй болгоход чиглэсэн санал, зөвлөмж дэвшүүлэв.

Судалгааны ач холбогдол. Энэхүү судалгаанд, Монгол Улсын хувьд “шинэ төрлийн” гэж тооцогдох гэмт хэрэг, тухайлбал хүнийг хүчээр алга болгох гэмт хэрэг; өнөөгийн байдлаар Монгол Улсад бүртгэгдээгүй ч ОУ-ын хэмжээнд онц ноцтой аюул учруулдаг гэмт хэргүүд болох иргэний нисэхийн харилцаа, агаарын хөлөг, ОУ-ын нисэх буудлын аюулгүй байдалтай холбоотой гэмт хэрэг; хүрээгээ тэлж улам өсөн нэмэгдэж буй мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодис, тэдгээрийн хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэргүүдтэй тэмцэх хүрээний ОУ-ын гэрээнүүдийг тус тус сонгон судалж, гэмт хэргийн тодорхойлолт, үндсэн шинж, эрүүгийн хариуцлагатай холбоотой хэм

хэмжээг түүвэрлэн, Монгол Улсын ЭХ-д тусгасан байдлыг тодруулж, нийцлийг дүгнэн, цаашид боловсронгуй болгох чиглэлээр санал, зөвлөмж дэвшүүлснээрээ суурь ач холбогдол оршино. Улмаар Монгол Улс ОУ-ын гэрээгээр хүлээсэн үүргээ эрх зүйн хүрээнд зөрчилгүй биелүүлэхэд дэмжлэг үзүүлнэ хэмээн найдаж байна.

Судлагдсан байдал

2009 онд ХЗҮХ-ийн хийсэн “Шүүх эрх мэдлийн хүрээний хууль тогтоомж ба ОУ-ын гэрээний зөрчилдөөний талаар судалж, шүүх эрх мэдлийн хүрээнд ОУ-ын эрх зүйн хэм хэмжээг хэрэглэх арга замыг тодорхойлох нь”¹⁰ сэдэвт судалгаагаар Монгол Улсын ОУ-ын гэрээ ба бусад хууль тогтоомжийн нийцлийг дүгнэжээ. Тус судалгааны “ЭХ, Эрүүгийн байцаан шийтгэх хууль ба Монгол Улсын ОУ-ын гэрээний зөрчилдөөн”¹¹ хэмээх дэд хэсгийн судалгааны хүрээнд, холбогдох Монгол Улсын ОУ-ын гэрээ (30 гэрээ)-ний зарим хэм хэмжээг ЭХ болон эрүүгийн процессын хуулийн зохицуулалттай харьцуулан судалсан. Судалгаанд хамрагдсан 30 гэрээний харьцуулан судлагдсан 308 хэм хэмжээний 209 буюу 67.8% нь үндэсний хууль тогтоомжид бүрэн тусгагдсан; 29 буюу 9.4% нь бүрэн бус тусгагдсан; 41 буюу 13.3% нь огт тусгагдаагүй байна; Энэ нь Монгол Улсын Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан “ОУ-ын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлэх” үүргээ зохих ёсоор биелүүлэхгүй байгааг илэрхийлсэн үзүүлэлт юм¹² хэмээн дүгнэжээ. Ийм учраас дээрх үүргээ бүрэн хэрэгжүүлэх зорилгын дор Монгол Улсын ЭХ, эрүүгийн процессын хуульд бүрэн тусгагдаагүй, эсвэл огт тусгагдаагүй байгаа ОУ-ын гэрээний хэм хэмжээг үндэсний хууль тогтоомжид хэрхэн, ямар байдлаар тусгаж, нийцүүлэх талаар тайлбарлаж, ЭХ, ЭБШХ-д өөрчлөлт оруулах талаар санал боловсруулсан.¹³ Гэхдээ энэхүү судалгаанд 2002 онд хүчин төгөлдөр үйлчилж байсан ЭХ тогтоомжийн үеийн нөхцөл байдал хамрагдсан.

Тус судалгаанд, Агаарын хөлгийн бүхээгт үйлдсэн гэмт хэрэг болон тодорхой бусад үйлдлийн тухай Токиогийн конвенц¹⁴, Иргэний нисэхийн аюулгүй байдлын эсрэг хууль бус үйлдлийг хориглох тухай Монреалийн конвенц¹⁵, Монреалийн конвенцийн нэмэлт протокол¹⁶, Сэтгэцэд нөлөөлөх бодисын тухай конвенц¹⁷, Мансууруулах эмийн тухай нэгдсэн конвенц¹⁸, Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг НҮБ-ын конвенц¹⁹-ийн хэм хэмжээг 2002 оны ЭХ-д тусгасан байдлыг харьцуулж судалсан байна. Харин Хүчээр алга болгохоос бүх хүнийг хамгаалах тухай ОУ-ын конвенц болон Агаарын хөлгийг хууль бусаар булаан авах үйлдлийг хориглох тухай Гаагийн конвенц тухайн судалгаанд хамрагдаагүй.

С.Гантулга, Б.Энхболд нарын “Эрүүгийн эрх зүй- тусгай анги” сэдэвт бүтээл нь 2015 оны ЭХ-ийн агуулга, үзэл баримтлалд нийцүүлэн бичигдсэн анхны сурах бичиг

¹⁰ ХЗҮХ, *Судалгааны тайлангийн эмхэтгэл (2003-2009 он)*, I боть, УБ, 2012, 700-799 дэх талаас дэлгэрүүлж үзнэ үү.

¹¹ Мөн тэнд, 700-799 дэх талаас дэлгэрүүлж үзнэ үү. 707-777, 796, 799 дэх талаас ерөнхийд нь, мөн холбогдох ОУ-ын гэрээний дэлгэрүүлж үзнэ үү.

¹² ХЗҮХ, *Судалгааны тайлангийн эмхэтгэл (2003-2009 он)*, I боть, УБ, 2012, 796 дахь тал.

¹³ ХЗҮХ, *Судалгааны тайлангийн эмхэтгэл (2003-2009 он)*, I боть, УБ, 2012, 796 дахь тал.

¹⁴ Мөн тэнд, 718 дахь тал.

¹⁵ Мөн тэнд, 715 дахь тал.

¹⁶ Мөн тэнд, 716-717 дахь тал.

¹⁷ Мөн тэнд, 737-740 дэх тал.

¹⁸ Мөн тэнд, 741 дэх тал.

¹⁹ Мөн тэнд, 742-744 дэх тал.

юм. ЭХ-ийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн төрлүүдийг бүрэлдэхүүнээр нь задалж тайлбарласнаараа дотоодын эрх зүйн хэм хэмжээг онолын түвшинд судлахад хөтөч болох бөгөөд ОУ-ын гэрээний нийцлийг харьцуулж судлахад дөхөм үзүүлнэ.

Монгол Улс Хүчээр алга болгохоос бүх хүнийг хамгаалах тухай ОУ-ын конвенцийг 2014 оны 10 дугаар сарын 09-ний өдөр соёрхон баталсан бөгөөд 2016 онд хүргүүлсэн анхны тайлан нь тухайн ОУ-ын гэрээний хэрэгжилтийн байдлыг илтгэсэн мэдээлэл болно. Тус тайланг хүлээн авч НҮБ-ын Хүчээр алга болгохоос бүх хүнийг хамгаалах асуудал хариуцсан хорооноос өгсөн зөвлөмж нь конвенцийн хэрэгжилтийн байдлыг дүгнэж, сайжруулах хүрээнд чиглэл өгсөн эх сурвалж юм. ЭХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээний тайлан²⁰, ЭХ-ийн зарим зүйл, заалтын хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан²¹-д хүнийг хүчээр алга болгох гэмт хэргийн төрлийг заасан ОУ-ын гэрээнд ЭХ-ийг нийцүүлэх үүднээс судалсан үр дүнг тусгасан байна.

Судалгаанд авч үзсэн, иргэний нисэхийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэгтэй холбоотой ОУ-ын гэрээ ба үндэсний хууль тогтоомжийн хэрэгжилтийг судалж, судалгааны үр дүнгээ нийтийн хүртээл болгосон ажил цөөн хийгджээ. Доктор Д.Зүмбэрэлхамын “Терроризмтой тэмцэх тухай ОУ-ын конвенцууд, тэдгээрт нийцүүлэн үндэсний хууль тогтоомжийг боловсронгуй болгох нь”²² сэдэвт илтгэлд иргэний нисэхийн аюулгүй байдалтай холбоотой ОУ-ын гэрээнүүдэд заасан гэмт хэргийн төрлийг онцолж, ЭХ-д ОУ-ын гэрээний хэм хэмжээг тусгах, ОУ-ын гэрээний үүргээ биелүүлэх асуудлыг дэвшүүлсэн байна. Иргэний нисэхийн аюулгүй байдалтай холбоотой ОУ-ын гэрээнд заасан гэмт хэргийн ойлголт, үндсэн шинж, хүлээлгэх эрүүгийн хариуцлага зэрэг асуудлыг судалж эрдмийн зэрэг хамгаалсан судалгааны ажил²³, эрдэм шинжилгээний өгүүлэл²⁴, илтгэл²⁵, тухайн ОУ-ын гэрээний хэрэгжилтийг хариуцсан хороо болон ажлын хэсгийн тайлан²⁶, тайлбар²⁷ гэх мэтчилэн гадаад эх сурвалж цөөнгүй байна. Тухайлбал, ОУ-ын гэрээний хэрэгжилтийг хариуцсан хороо болон ажлын хэсгийн тайлан, тайлбарууд нь гэмт хэргийн тодорхойлолт, шинж, эрүүгийн хариуцлага зэрэг асуудлыг онол, арга зүйн хувьд тайлбарласан байдгаараа судалгаа шинжилгээний ажилд ач холбогдолтой эх сурвалж болно. Гэхдээ эдгээр нь Монгол Улсын ЭХ-ийн зохицуулалт ОУ-ын гэрээнд нийцсэн эсэх асуудлыг хөндөөгүй болно.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодис, тэдгээрийн хууль бус эргэлттэй холбоотой ОУ-ын гэрээ ба дотоодын хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар

²⁰ <http://forum.parliament.mn/projects/11281> судалгаа, лавлагаа, тооцоо бусад мэдээлэл хэсэг, 8, 16 дахь тал, [Сүүлд үзсэн: 2022.05.25].

²¹ Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээний тайлан, УБ, 2022, 9-10, 12, 14, 17, 27-27, 32 дахь тал. ЭХ дахь уг гэмт хэргийн талаарх зохицуулалтыг зөвлөмжид нийцүүлэх талаар тусгасан байна.

²² “Олон улсын терроризм ба Монгол Улс” *онол практикийн бага хурлын эмхэтгэл*, УБ, 2004.

²³ Jung, Sung Yool, *A Legal Analysis of Aviation Security under the International Legal Regime*, (A thesis submitted to McGill University in partial fulfillment of the requirements of the degree of Master of Laws (LL.M), 2005.

²⁴ Thomas, C. S., and M. J. Kirby. “The Convention for the Suppression of Unlawful Acts against the Safety of Civil Aviation.” *The International and Comparative Law Quarterly*, vol. 22, no. 1, 1973.

²⁵ Vijay Kumar Singh, *Trends in Safety and Security Regulations of Civil Aviation* (Paper Presented at the Seventh International Conference on “Legal Regime of Sea, Antarctica, Air and Space” organized by Indian Society of International Law, New Delhi from 15-17 January 2010).

²⁶ A/HRC/16/48/Add.3, Report of the Working Group on Enforced or Involuntary Disappearances, 2010.

²⁷ A/HRC/7/2, para. 26 General comment on the definition of enforced disappearance.

судалсан ажлын үр дүн нэлээд байна. Энэ нь ийм төрлийн гэмт хэрэг манай улсад сүүлийн үед нэлээд гарч, гадаад улсад ч манай улсын иргэд ийм төрлийн гэмт хэрэгт холбогдох нь ихэссэнтэй холбоотой байх талтай.

ХЗҮХ-ийн гүйцэтгэсэн “Мансууруулах эмийн ба сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлттэй тэмцэх талаарх ОУ-ын стандарт” сэдэвт бодлогын судалгаа (2015)²⁸, “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтийн нөхцөл байдлын дүн шинжилгээ” сэдэвт судалгаа(2017)²⁹ -нд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодис, тэдгээрийн хууль бус эргэлттэй холбоотой ОУ-ын болон дотоодын эрх зүйн зохицуулалт, хэрэгжилт, гэмт хэргийн нөхцөл байдал, нөлөөлж буй шалтгаан, цаашид энэ төрлийн гэмт хэргүүдтэй тэмцэх арга замын талаар судалж тодорхойлжээ.

ДХИС-аас хэвлүүлсэн “Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэхэд тулгамдаж буй асуудал” сэдэвт ОУ-ын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэлд мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтийн талаарх ОУ-ын болон Монгол Улсын эрх зүйн орчин, практик асуудлыг тусгасан илтгэлүүд байна. Тухайлбал, Монгол Улсын гавьяат хуульч, хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор, цагдаагийн хурандаа С.Жанцангийн “Хар тамхины гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагааг боловсронгуй болгох асуудал”, ЦЕГ-ын эрүүгийн цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа С.Ганбатын “Хар тамхи, мансууруулах бодисын хууль бус эргэлттэй тэмцэх асуудал”, Отгонтэнгэр их сургуулийн Эрүүгийн эрх зүйн тэнхимийн багш Ц.Дарьжавын “Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодис хууль бусаар эргэлтэд оруулах гэмт хэргийн өнөөгийн байдал, эрх зүйн зохицуулалтын асуудал”, Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, шинжлэх ухааны доктор, профессор, дэслэгч генерал Ш.Арвайн “Улсын хилийн аюулгүй байдал ба хар тамхи” сэдэвт илтгэлүүд багтсан байна.

ХЗДХЯ, ЦЕГ, ХСИХ-аас хамтарч эрхлэн гаргасан “Хар тамхины гэмт явдал: шалтгаан, нөхцөл, урьдчилан сэргийлэх арга зам” сэдэвт эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл”-д хар тамхи, мансууруулах бодистой холбоотой гэмт хэргийн нөхцөл байдал, эрх зүйн орчин, хууль, нэр томъёоны хэрэглээ, хэрэг шалган шийдвэрлэх практикт үүсэж буй асуудал, ялын бодлого, ОУ-ын гэрээгээр хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж буй талаар хөндсөн илтгэлүүд багтжээ. Энэхүү эмхэтгэлд нийт 26 эрдэм шинжилгээний өгүүлэл нийтлэгдсэн нь онол, практикийг холбож судалсан үр дүн юм. Түүний дотор Хууль зүйн ухааны доктор, профессор, цагдаагийн хурандаа Б.Болдбаатарын “Хар тамхи, мансууруулах бодисын хууль бус эргэлттэй тэмцэж буй хууль тогтоомжийн хэрэгжилт, тулгамдаж буй асуудал”, хууль зүйн доктор, профессор, цагдаагийн хурандаа Ч. Нямсүрэн нарын “Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэргийн ялын бодлого” сэдэвт илтгэлүүдэд ОУ-ын болон дотоодын эрх зүйн зохицуулалт, практик асуудлыг товч хөнджээ.

Судлаач Э. Ариунзаяагийн “Хар тамхи, мансууруулах бодисын ОУ-ын эрх зүйн зохицуулалт: Монгол, БНХАУ, ОХУ-ын ЭХ-д тусгасан байдал”³⁰ сэдэвт илтгэлд ОУ-ын эрх зүйн зохицуулалтыг тоймлохоос гадна Монгол Улс ба хөрш орнуудын ЭХ дахь мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн хууль бус эргэлттэй холбоотой

²⁸ ХЗҮХ, Судалгааны тайлангийн эмхэтгэл (2014-2015) IV боть, УБ, 2017, 354-402 дахь тал.

²⁹ ХЗҮХ, Судалгааны тайлангийн эмхэтгэл (2016-2017) V боть, УБ, 2018, 345-354 дэх тал.

³⁰ Олон улсын эрх зүй: Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын хамтын ажиллагаа, эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл, УБ, 2015.

зохицуулалтыг хооронд нь харьцуулсан байна. Үүнд ЭХ-ийн зохицуулалтыг ОУ-ын гэрээний хэм хэмжээнд нийцсэн эсэхийг хамруулаагүй болно.

Дээр дурдсан эх сурвалжаас гадна Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр, Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр зэрэг бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн хяналт, шинжилгээ, үнэлгээний тайлан боловсруулах ажлын хэрэгцээнд зориулсан судалгааны ажил, хүний эрхийн холбогдолтой ОУ-ын гэрээний хэрэгжилтийн тайлан, Хүний эрхийн нөхцөл байдлын илтгэлүүд нь мөн албан ёсны мэдээлэл, лавлагааг багтаасан эх сурвалж юм.

Ийнхүү судлагдсан байдлын хүрээнд дүгнэлт хийж үзвэл, энэхүү судалгаанд сонгогдсон Монгол Улсын ОУ-ын гэрээнд заасан гэмт хэргийн ойлголт, үндсэн шинж, эрүүгийн хариуцлагатай холбоотой хэм хэмжээг 2015 оны ЭХ-д тусгасан байдлыг судалж, нийцлийг дүгнэх шаардлагатай.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ХҮЧЭЭР АЛГА БОЛГОХООС БҮХ ХҮНИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ ОЛОН УЛСЫН КОНВЕНЦ³¹

Энэхүү конвенц 2007 оны 02 дугаар сарын 06-ны өдөр батлагдаж, 2010 оны 12 дугаар сарын 23-ны өдөр хүчин төгөлдөр болсон. Монгол Улс 2014 оны 10 дугаар сарын 09-ний өдөр соёрхон баталсан.

А. Хүнийг хүчээр алга болгох гэмт хэргийн ойлголт, үндсэн шинж

Уг конвенцийн зорилгод зааснаар “хүчээр алга болгох” гэдэг нь алга болсон аливаа хүний эрх чөлөөг хассан явдлыг хүлээн зөвшөөрөхөөс татгалзсан буюу түүний хувь заяаны талаарх мэдээлэл, эсхүл оршин суугаа газрыг нуусны улмаас тухайн хүнийг хуулийн хамгаалалт эдэлж чадахааргүй байдалд хүргэхүйцээр төрийн төлөөлөгчид буюу төрөөс эрх олгогдсон, дэмжлэг буюу зөвшөөрөл авсан этгээдүүд, эсхүл бүлэг этгээдийн тухайн хүнийг баривчлах, саатуулах, хулгайлах, эсхүл бусад хэлбэрээр эрх чөлөөг нь хасахыг хэлнэ.³²

Дээрх тодорхойлолтод заасан гэмт хэргийн зайлшгүй байх ёстой үндсэн шинжүүдийг авч үзвэл:

- (1) Тухайн хүний хүсэл зоригийн эсрэг эрх чөлөөг нь хассан байх (тухайн хүнийг баривчлах, саатуулах, хулгайлах, эсхүл бусад хэлбэрээр)
- (2) Энэ нь төрийн төлөөлөгч, түүний зөвшөөрөлтэйгөөр, үйл ажиллагаа явуулж буй хүмүүстэй холбоотой байх, дор хаяж тэдгээр нь шууд бусаар хүлээн зөвшөөрснөөр
- (3) Эрх чөлөөг нь хассан явдлыг хүлээн зөвшөөрөхөөс татгалзаж, алга болсон хүний хувь заяа, байгаа газрыг нь нуун дарагдуулсан зэрэг шинж багтаж байна.³³

³¹ Төрийн мэдээлэл, Дугаар 11 /1113/, МУ-ын ОУ-ын гэрээ, УБ, 2020, 680 дахь тал.

³² Хүчээр алга болгохоос бүх хүнийг хамгаалах тухай ОУ-ын конвенцийн 2 дугаар зүйл.

³³ Inter alia, WGEID, Best Practices on Enforced Disappearances in Domestic Criminal Legislation, supra note 5, para. 21, болон Parliamentary assembly, Council of Europe, AS/Jur 2011, 45, 4 November 2011, ajdoc45 2011,

Б. Монгол Улсын Эрүүгийн хуулийн нийцэл

Конвенцийн 4 дүгээр зүйлд заасанчлан оролцогч улс бүр, хүнийг хүчээр алга болгох үйлдлийг гэмт хэрэг гэж үзэн ЭХ-д тусгах талаар шаардлагатай бүхий л арга хэмжээг авах ёстой. Иймээс хүнийг хүчээр алга болгох гэмт хэргийн дээр дурдсан үндсэн шинжүүдийг ЭХ-д хэрхэн тусгасан талаар нарийвчилж үзье.

1. Тухайн хүний хүсэл зоригийн эсрэг эрх чөлөөг нь хассан байх шинж (баривчлах, саатуулах, хулгайлах, эсхүл бусад хэлбэрээр)

Монгол Улс 2018 онд тус конвенцийн хороонд хэрэгжилтийн эхний тайлан илгээсэн бөгөөд тус тайланд дурдсанаар³⁴, хүнийг хүчээр алга болгох гэмт хэргийн шинжийг 2015 оны ЭХ-ийн 13.4 дүгээр зүйлд заасан хүнийг хүчээр алга болгох гэмт хэрэг болон 13.9 дүгээр зүйлд заасан хууль бусаар баривчлах, саатуулах гэмт хэргийн төрөл хангаж байна гэж үзсэн. Гэвч эдгээр заалтад тусгасан гэмт хэргүүд нь уг конвенцид заасан гэмт хэргийн бүрэлдэхүүнийг бүхэлд нь агуулаагүй байгааг дурдаж, конвенцийн тодорхойлолтод агуулгыг бүрнээ нийцүүлэх талаар НҮБ-ын Хүнийг хүчээр алга болгохоос хамгаалах хорооноос өгсөн зөвлөмж³⁵ -д дурджээ. Үүнийг үндэслэн, ЭХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд, хүнийг хүчээр алга болгох гэмт хэргийг тодорхойлохдоо уг конвенцийн 2 дугаар зүйлд заасан хэм хэмжээнд нийцүүлэхэд анхаарсан байна.

Хуулийн төслийн 29.12 дугаар зүйлд, хүнийг хүчээр алга болгох гэмт хэргийг хэрхэн тодорхойлсныг шинжилж үзвэл:

“Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгай чиг үүрэгтэй байгууллагын удирдах болон гүйцэтгэх албан тушаалтан, прокурор, шүүгч хүнийг хууль бусаар саатуулсан, баривчилсан, хорьсон, хууль бусаар нууж эрх чөлөөг нь хязгаарласан, эсхүл хорьсон, эрх чөлөөг нь хязгаарласан талаарх мэдээллийг нууж, мэдээлэл өгөхөөс татгалзаж эрх чөлөөг нь хязгаарласны улмаас бусдын хууль ёсны эрх, ашиг сонирхолд нь хохирол, хор уршиг учруулсан нь энэ хуулийн тусгай ангид заасан бусад гэмт хэргийн шинжгүй бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.” гэжээ.

Хүнийг хүчээр алга болгохоос хамгаалах хорооноос Монгол Улсад өгсөн зөвлөмжид, ЭХ-ийн 13 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт тусгасан “хүнийг хууль бусаар хорьсон үйлдэл” нь зөвхөн “хууль бусаар хорих” гэсэн утгыг илэрхийлдэг тул эрх чөлөөг нь хасах бүх төрлийг хамруулаагүй, хүчээр алга болгох гэмт хэрэг нь хуулийн дагуу эрх чөлөөг хассанаар эхэлж, улмаар уг гэмт хэргийн бусад бүрэлдэхүүнийг агуулах болсноор хууль бус болж хувирах боломжтой³⁶ гэжээ. Өөрөөр хэлбэл,

Committee on Legal Affairs and Human Rights, The International Convention for the Protection of all Persons from Enforced Disappearances, Report Rapporteur: Mr Christos Pourgourides, Cyprus, Group of the European People's Party, p.13 <http://assembly.coe.int/committeedocs/2011/ajdoc45.pdf> , [Сүүлд үзсэн: 2022.04.08],-аас үзнэ үү.

³⁴ Report submitted by Mongolia under article 29 (1) of the Convention, due in 2017 : International Convention for the Protection of All Persons from Enforced Disappearance, Article 2, <https://digitallibrary.un.org/record/3795922?ln=en>, [Сүүлд үзсэн:2022.06.08].

³⁵ Concluding observations on the report submitted by Mongolia under article 29 (1) of the Convention : Committee on Enforced Disappearances, UN. Committee on Enforced Disappearances (20th sess. : 2021 : virtual), <https://digitallibrary.un.org/record/3949022?ln=en> ,p.3 [Сүүлд үзсэн:2022.04.08].

³⁶ Concluding observations on the report submitted by Mongolia under article 29 (1) of the Convention : Committee on Enforced Disappearances, UN. Committee on Enforced Disappearances (20th sess. : 2021 : virtual), <https://digitallibrary.un.org/record/3949022?ln=en> ,p.3 [Сүүлд үзсэн:2022.04.08].

хохирогчийг хүчээр алга болохоос хамгаалахын тулд эрх чөлөөг нь хасах ямар ч хэлбэрээс үл хамааран эрх чөлөөг нь хассан үйлдэл бүр дээр үр дүнтэй хэрэгжих ёстой бөгөөд зөвхөн хууль бусаар эрх чөлөөгөө хасуулсан тохиолдлуудаар хязгаарлагдахгүй³⁷ юм.

Харин ЭХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд “хууль бусаар” гэж зааглан эрх хасах үйлдлүүдийг хязгаарлаж өгснөөр “хуулийн дагуу эхэлсэн” болон уг конвенцид “өөр бусад хэлбэрээр” хэмээн нэмж заасан эрх хассан үйлдлүүдийг хамруулаагүй байна. Өөрөөр хэлбэл саатуулсан, баривчилсан, хорьсон, эрх чөлөөг нь хязгаарласан үйлдлүүд нь хуулийн дагуу эхлэх боломжтой, мөн конвенцид гэмт хэргийн шинжийг заахдаа эрх хассан үйлдлийг заавал хууль бус байх гэсэн шаардлага тавиагүй байх тул “хууль бусаар” гэж тодотгохоос илүүтэй “хуулийн хамгаалалт эдэлж чадахааргүй байдалд хүргэхүйцээр” гэх мэтчилэн конвенцид заасан шинжүүдийг бүрэн хамруулах боломжтой гэж үзэж байна. Түүнчлэн уг хуулийн төсөлд “хууль бусаар нууж, эрх чөлөөг нь хязгаарласан” хэмээн томъёолсон нь, хүнийг хүчээр алга болгох гэмт хэргийн үндсэн бүрэлдэхүүн болох “бусад хэлбэрээр эрх чөлөөг нь хасах” шинжээс хазайсан буюу хууль бусаар нууснаас өөр бусад хэлбэрийг орхигдуулж байгааг дурдах нь зүйтэй.

2. Энэ нь төрийн төлөөлөгч, түүний зөвшөөрөлтэйгөөр, үйл ажиллагаа явуулж буй хүмүүстэй холбоотой байх, наад зах нь тэдгээр нь шууд бусаар хүлээн зөвшөөрснөөр үйлдэгдсэн байх шинж

а) Гэмт хэргийн субъект

Хүчээр болон албадан алга болгосон асуудлыг шийдвэрлэх ажлын хэсэг (The Working Group on Enforced or Involuntary Disappearances) “хүчээр алга болгосон” гэдэг тодорхойлолтод өгсөн ерөнхий тайлбартаа “Гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хувьд (...) тухайн үйлдлийг төрийн байгууллага, эсхүл Засгийн газрын шууд болон шууд бус зөвшөөрлөөр буюу хүлээн зөвшөөрснөөр, эсхүл түүний дэмжлэгтэйгээр үйл ажиллагаа явуулж буй хувь хүмүүс, зохион байгуулалттай бүлэг (жишээ нь, хагас цэрэгжүүлсэн бүлгүүд) үйлдсэн бол хүчээр алга болгосон гэмт хэрэгт тооцохоор”³⁸ тусгасан.

Үүнд төрийг төлөөлөгч албан тушаалтнаас гадна бусад тушаал, заавар аваагүй ч, төрийн нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулж байгаа болон түүний шууд ба шууд бус дэмжлэгтэйгээр гэмт хэрэг үйлдсэн хувь хүмүүсийн үйлдлийг дотоодын ЭХ-д тогтоомжид тусгаагүй бол энэ тодорхойлолтыг дутуу байна гэж Ажлын хэсэг үзээд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай³⁹ гэжээ. Харин хуулийн төсөлд, Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгай чиг үүрэг бүхий байгууллага⁴⁰-ын удирдах болон гүйцэтгэх албан тушаалтан, прокурор, шүүгч энэ төрлийн гэмт хэргийг үйлдсэн байх хэмээн заажээ. Тэгвэл эдгээрээс бусдаар төрийн шууд болон шууд бус дэмжлэг авсан этгээдүүд конвенцид заасан хүрээнээс гадна үлдэхэд хүрч байна.

³⁷ A/HRC/7/2, para. 26 (para. 7 of the general comment on the definition of enforced disappearance).

³⁸ A/HRC/7/2, para. 26 (para. 1 of the general comment on the definition of enforced disappearance)

³⁹ A/HRC/7/2/Add.2, para. 30.

⁴⁰ Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлд зааснаар дараах байгууллагууд хамаарна. Үүнд: Байгаль орчныг хамгаалах алба; Гаалийн алба; Дипломат алба; Гамшгаас хамгаалах алба; Мэргэжлийн хяналтын алба; Зэвсэгт хүчин, бусад цэрэг; Татварын алба; Тусгай алба, гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх алба; иргэн, хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн алба, цагдаагийн алба зэрэг болно.

б. Төрийн болон төрийн бус субъект

2002 оны ЭХ-ийн 109 дүгээр зүйлд заасан “Хүнийг хууль бусаар хорих” гэсэн гэмт хэргийг 2015 оны ЭХ-ийн 13.4 дүгээр зүйлд “Хүнийг хүчээр алга болгох” гэмт хэрэг болгон хуульчлахдаа үндсэн гэмт хэргийн санкцад бага зэргийн өөрчлөлт оруулснаас өөрөөр гэмт хэргийн агуулгын буюу бүрэлдэхүүний хувьд өөрчлөлгүйгээр нэршлийг л өөрчилж хуульчилсан. Гэвч ЭХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн заалтаас үзвэл хүнийг хүчээр алга болгох гэмт хэргийг “хүнийг хууль бусаар хорих гэмт хэргээс тусад нь ялгаж зохицуулсан”⁴¹ гэсэн ч энэхүү гэмт хэргийн агуулгыг хэвээр үлдээн, нэршлийг нь л буцааж 2002 оны ЭХ-тай адил болгож өөрчлөн 13.17 дугаар зүйлд шилжүүлэн хуульчилсан байна.

Конвенцийн 3 дугаар зүйлд заасанчлан төрийн зөвшөөрөл, дэмжлэг, зөвшөөрөлгүйгээр үйл ажиллагаа явуулж буй хүн, бүлэг хүмүүсийн үйлдсэн хүчээр алга болгосонтой адил үйлдлийг мөрдөж, буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэх зохих арга хэмжээ авах ёстой. Мөн хүнийг хүчээр алга болгохтой холбоотой төрийн онцгой үүрэг нь “харьцуулж болохуйц” төрийн бус этгээдийн үйлдлийг үндэсний хууль тогтоомжийн дагуу тусад нь авч үзэхийг шаарддаг бөгөөд зөвхөн “хүчээр алга болгох” гэсэн өргөтгөсөн тодорхойлолтоор нэгтгэх шаардлагагүй юм.⁴²

Харин Хорооны зөвлөмж болон МУ-ын хариу тайлбар зэргээс үзэхэд талууд ЭХ-ийн 13.4 дэх заалт буюу “хүнийг хууль бусаар хорьсон” үйлдлийг хэдий зарим шинж дутуу байна гэж үзэж байсан ч 13.9 дүгээр зүйлд заасан эрх бүхий этгээд хүний эрх чөлөөнд халдсан, баривчилсан, саатуулсан үйлдлийг хамтад нь хүнийг хүчээр алга болгох гэмт хэргийн объектив шинжүүдийг хангаж байна буюу хүнийг хүчээр алга болгох гэмт хэрэг гэж үзэж байсан. Иймээс хүнийг хүчээр алга болгох гэмт хэрэгт урьд нь тооцогдож байсан хууль бусаар хорих үйлдэл буюу 13.4 дүгээр заалтыг агуулга буюу гэмт хэргийн бүрэлдэхүүнийг нь өөрчлөлгүйгээр зөвхөн нэрийг нь 2002 оны ЭХ-ийн заалттай адил болгон өөрчилсөн 13.17 дугаар зүйл нь хэрхэн тусдаа гэмт хэрэг болж байгаа нь ялгагдахгүй байна.

Өөрөөр хэлбэл хуулийн төслийн 13.17, 13.9 болон 29.12 дугаар зүйлд заасан гэмт хэргийн төрлүүдийн хооронд давхцал бий болж байна. Жишээ нь 13.9 дүгээр зүйлд заасан “...хүний эрх чөлөөнд халдсан” үйлдлийг эрх бүхий албан тушаалтан үйлдсэн байх ёстой тул цагдаа үйлдсэн байх боломжтой. Мөн төслийн 29.12 дугаар зүйлд заасан үндэсний аюулгүй байдлыг хангах тусгай чиг үүрэгтэй байгууллагад Үндэсний аюулгүй байдлын тухай хуульд заасанчлан цагдаагийн алба хамаарах тул түүний удирдах болон гүйцэтгэх албан тушаалтанд цагдаа мөн орох ба гэмт хэргүүдийн объектив шинжид хууль бусаар баривчилсан, саатуулсан үйлдлүүд тус тус нэгэн адил хамаарч байна. Тиймээс, жишээ нь цагдаа хууль бусаар саатуулсан бол 13.9 дүгээр зүйлийн дагуу эрх бүхий албан тушаалтан хуульд заасан үндэслэл, журмыг зөрчиж саатуулсан үйлдэлд хамаарах уу, эсхүл 29.12 дугаар зүйлийн дагуу үндэсний аюулгүй байдлыг хангах тусгай чиг үүрэгтэй байгууллагын гүйцэтгэх албан тушаалтан

⁴¹ Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн танилцуулга, Уб, 2022, 10 дахь тал <http://forum.parliament.mn/projects/11281> [Сүүлд үзсэн: 2022.05.10].

⁴² International commission of Jurists, No More “Missing Persons”: The Criminalization of Enforced Disappearance in South Asia, August 2017, p.14, <https://www.icj.org/wpcontent/uploads/2017/08/South-Asia-Enforced-Disappearance-Publications-Reports-Thematic-Reports-2017-ENG.pdf>, [Сүүлд үзсэн: 2022.06.10].

хууль бусаар саатуулсан үйлдэлд хамаарч байна уу гэдэг тодорхой болоогүй гэж үзэж байна.

Монгол Улс хэдий эдгээр гэмт хэргүүдийг тусдаа заалтаар зохицуулахаар төсөлд тусгасан байх боловч хоорондын ялгааг сайн гаргаж чадаагүй нь шүүхийн практикт, ялангуяа гэмт хэргийн зүйлчлэлийн хувьд асуудал үүсгэж болзошгүй юм. Иймээс ЭХ-ийн төслийн 13.9, 13.17 болон 29.12 дугаар зүйлүүдийн заагийг субъектийн хувьд гаргах боломжтой гэж үзлээ.

3. Эрх чөлөөг нь хассаныг хүлээн зөвшөөрөхөөс татгалзаж, алга болсон хүний хувь заяа, байгаа газрыг нь нуун дарагдуулсан байх шинж

Энэ төрлийн гэмт хэргийн бас нэгэн чухал шинж нь хүний хувь заяаны талаарх мэдээлэл, эсхүл оршин байгаа газрын талаарх мэдээллийг нуун дарагдуулсан байх юм. Уг шинжийг ЭХ-ийн нэмэлт өөрчлөлтийн төсөлд зөвхөн "... хорьсон, эрх чөлөөг нь хязгаарласан талаарх мэдээллийг нууж..." гэж тусгасан байна. Ингэснээр хорьсон, эрх чөлөөг нь хязгаарласан талаарх мэдээлэл нь тухайн хүний хувь заяаны талаарх мэдээллүүд, тухайлбал хүний амь нас, эрүүл мэндийн байдал зэрэг мэдээллийг багтааж байгаа эсэх нь эргэлзээтэй юм. Хэдийгээр эрх чөлөөг нь хассаныг хүлээн зөвшөөрөхөөс татгалзах; хувь заяа, оршин суугаа газрын талаар мэдээлэл өгөхөөс татгалзах/нуух зэргийг өөр үгээр илэрхийлэх боломжтой ч эдгээр нь Тунхаглал, ОУ-ын конвенц, Ромын дүрэмд тусгагдсан бүх тохиолдлыг хамарсан гэж нэмж тайлбарласан тохиолдолд боломжтой.⁴³ Иймээс дээр дурдсан шаардлагыг хангасан эсэхийг нягтлах шаардлагатай.

Оршин суугаа газар

Конвенцийн англи хэл дээр "whereabouts" буюу тухайн этгээдийн байгаа газрыг илтгэх үгийг тухайн хүний оршин суугаа газар гэжээ. Харин Монгол Улсын Иргэний хуулийн 22.1 дүгээр зүйлд "Иргэний оршин суугаа газрыг хуулийн дагуу түүний харьяалагдан бүртгүүлсэн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжээр тодорхойлно.", мөн хуулийн 22.2 дугаар зүйлд "Иргэн бүртгүүлсэн газраа байнга оршин суудаггүй бол гол төлөв амьдран суудаг, эсхүл тухайн этгээдийн эд хөрөнгийн дийлэнх хэсэг байгаа газрыг түүний оршин суугаа газар гэж тодорхойлж болно." гэж тус тус оршин суугаа газрын талаарх ойлголтыг тодорхойлсон. Иймд тус конвенцийн агуулгын хүрээнд авч үзвэл, тухайн хүнийг хүчээр алга болгож байгаа учир энэ нь мэдээж хуулийн дагуу биш буюу хууль бус үйлдэл учраас түүний "оршин суугаа" газрыг нуусан гэх нь агуулгын хувьд бүрэн төгс илэрхийлэх орчуулга болж чадахгүй юм. Иргэний хуульд зааснаар иргэний оршин суугаа газар гэдэг нь хуулийн дагуу харьяаллаа бүртгүүлсэн газар байх тул конвенцийг монгол хэлнээ хөрвүүлэхдээ "тухайн хүний байгаа газар", "оршин буй газар" зэрэг үг хэллэгээр өөрчлөн буулгах нь зүйтэй.

Мөн Төрийн мэдээлэл сэтгүүлд уг ОУ-ын гэрээг нийтлэхдээ "конвенц" гэдэг үгийг хоёр өөр янзаар бичсэн байна. Тус ОУ-ын гэрээний эхний хэсэгт "энэхүү **конвенцид**" гэж бичсэн бол 2 дугаар зүйлд "**конвенцын** зорилгод" гэж бичжээ. Хэрэв "конвенцид" гэж бичиж байгаа бол "конвенцийн" гэж бичих ёстой. Практик хэрэглээнд ихэнхдээ "конвенцийн" гэж бичиж заншсан бол монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан

⁴³ A/HRC/16/48/Add.3, para. 28, Report of the Working Group on Enforced or Involuntary Disappearances, 2010.

толь дээрээс үзвэл “конвенцын” гэж бичигдсэн байна. Эдгээрийг хэл зүйн хувьд нягталж, нэгмөр болгох нь зүйтэй.

4. Хуулийн хамгаалалтаас гадуур байлгах шинж

ОУ-ын эрх зүй дэх хүнийг хүчээр алга болгохтой холбоотой бүх тодорхойлолтууд хохирогчийг хуулийн хамгаалалтаас гадуур байлгадаг. Хүчээр алга болгох гэмт хэргийн энэхүү онцлог нь хохирогчийн бусад бүх эрх, эрх чөлөө эдлэхийг түдгэлзүүлж, түүнийг бүрэн хамгаалалтгүй байдалд оруулдаг оршино. Энэ нь хүн бүр бусад бүх эрхийг эдлэх урьдчилсан нөхцөл болох хуулийн өмнө хүнийхээ хувьд хүлээн зөвшөөрөгдөх эрхтэй нягт холбоотой юм.

Тунхаглал болон Ажлын хэсгийн байр сууринд нийцүүлэн бусад бүрэлдэхүүний үр дагавар болох "хохирогчийг хуулийн хамгаалалтаас гадуур байлгах" энэ шинжийг хуульчилсан улс орнуудыг сайн жишиг бүхий гэж үзнэ.⁴⁴ Харин Монгол Улс хараахан энэхүү шинжийг тусгаагүй байна.

5. Хохирол, хор уршиг учирсан байх шинж

Хүчээр алга болгохоос бүх хүнийг хамгаалах тухай ОУ-ын конвенцийн хүрээнд бусдын хууль ёсны эрх, ашиг сонирхолд нь хохирол, хор уршиг учруулсан байхыг шаардаагүй бөгөөд эрх чөлөөг нь хязгаарласан үйлдэл хийсэн байвал хангалттай шинж гэж үздэг. Хэдийгээр хүнийг хүчээр алга болгох гэмт хэргийн хохирогчид хор уршиг учруулаагүй байх тохиолдол цөөн байж болох ч хуулийн төсөлд хохирол, хор уршиг учирснаар л гэмт хэрэг үйлдсэнд тооцож байгаа нь эрх чөлөөг нь хязгаарласан үйлдэлд хариуцлага ногдуулах хүрээг хумьж байна гэж үзэж байна.

6. Конвенцийн дагуу хүлээсэн үүрэг

Хүчээр алга болгохоос бүх хүнийг хамгаалах тухай ОУ-ын конвенц нь “*widespread and systematic*” шинжээрээ хүн төрөлхтний эсрэг гэмт хэргийг заасан ОУ-ын гэрээнд багтдаг. Өөрөөр хэлбэл энэхүү конвенцийн 7 дугаар зүйлийн 1-д заасанчлан оролцогч улс бүр, хүчээр алга болгох гэмт хэргийн онц ноцтой шинжийг харгалзан зохих шийтгэл ногдуулах ёстой. Гэтэл ЭХ болон ЭХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгагдсан байдлыг авч үзвэл, өөр бүлэгт хамаарах гэмт хэргүүдээс тодорхой ялгагдахгүй байна. Мөн 1-5 жилийн хугацаагаар хорих ял шийтгэж байгаагийн улмаас энэ төрлийн гэмт хэрэг нь ЭХ-ийн дагуу хөнгөн гэмт хэрэгт багтана. Үүнээс үзэхэд конвенцид заасан гэмт хэргийн онц ноцтой шинжийг ЭХ-д тусгаагүй байгаа нь ОУ-ын гэрээний үүргээ бүрэн биелүүлээгүй байна гэж үзэхэд хүргэв. Иймд үндсэн гэмт хэрэгт ногдуулах ялыг нэмэгдүүлж, хөнгөн гэмт хэргүүдээс ялгамжтай зохицуулах шаардлагатай.

Хамтран оролцогчдод хариуцлага хүлээлгэх

Конвенцийн 6 дугаар зүйлд заасанчлан оролцогч улс бүр наад зах нь дараах этгээдэд эрүүгийн хариуцлага ногдуулах зорилгоор шаардлагатай арга хэмжээ авах ёстой. Үүнд:

⁴⁴ WGEID, Best Practices on Enforced Disappearances in Domestic Criminal Legislation, supra note 5, para.32.

(a) хүчээр алга болгох үйлдлийг гүйцэтгэсэн, түүнийг гүйцэтгэхийг тушаасан, турхирсан буюу өдөөсөн, гүйцэтгэхийг сэдсэн, түүнд оролцсон буюу хамтарч гүйцэтгэсэн аливаа этгээд;

(b) дарга нь, хэрэв:

i) түүний хяналт, удирдлага дор бодитойгоор харьяалагддаг ажилтан нь хүчээр алга болгох гэмт хэрэг үйлдсэн, эсхүл үйлдэхээр завдсан гэдгийг мэдэж байсан, эсхүл энэ талаарх тодорхой мэдээллийг санаатайгаар үл тоомсорлосон бол;

ii) хүчээр алга болгох гэмт хэрэгтэй холбоотой үйл ажиллагааны хувьд бодит хариуцлага хүлээж байсан, эсхүл бодит хяналт тавьж байсан бол;

iii) хүчээр алга болгох үйлдлийг өөрийн эрх мэдлийн хүрээнд таслан зогсоох буюу түүнээс урьдчилан сэргийлэх, эсхүл мөрдөн байцаалт буюу эрүүгийн мөрдөн мөшгөлт хийлгэхээр уг асуудлыг эрх бүхий байгууллагад шилжүүлэх талаар бүхий л шаардлагатай болон боломжит арга хэмжээ аваагүй бол хамаарна.

ЭХ-ийн 3 дугаар бүлэгт гэмт хэрэгт хамтран оролцох байдлыг тодорхойлсон. Гүйцэтгэгч, зохион байгуулагч, хатгагч, хамжигчийг гэмт хэрэгт хамтран оролцогчид тооцно.⁴⁵ Энэ нь Монгол Улс уг конвенцийн эхний заалтад заасан оролцогчдыг тусгасан зохицуулалт юм. Харин конвенцийн b) дэд хэсэгт заасан гэмт хэргийн субъектүүдийг орхигдуулсан байна. Жишээ нь, эрх бүхий субъектийн удирдлага өөрийн харьяалал дор байдаг этгээд нь хүнийг хүчээр алга болгох гэмт хэрэг үйлдсэнийг мэдсэн ч нуун далдалсан бол энэ төрлийн гэмт хэрэгт хамтран оролцсон этгээдэд тооцогдохгүй учир хариуцлага хүлээхгүй өнгөрөх юм. Иймээс уг конвенцид заасны дагуу, гэмт хэрэгт хамтран оролцсон, хариуцлага хүлээх субъектүүдийг нэмж өргөжүүлэн ЭХ-д тусгах нь зүйтэй.

В. Дүгнэлт

Хүчээр алга болгохоос бүх хүнийг хамгаалах тухай ОУ-ын конвенцид заасан гэмт хэргийг ЭХ-д бүрэн бус тусгасан байна. Монгол Улс НҮБ-ийн Хүнийг хүчээр алга болгохоос хамгаалах асуудал эрхэлсэн хорооноос өгсөн зөвлөмжийн дагуу ЭХ-ийн 13.4 дүгээр зүйлд заасан “Хүнийг хүчээр алга болгох” гэмт хэргийн зохицуулалтад өөрчлөлт оруулахаар ЭХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгажээ. Гэвч конвенцид заасан гэмт хэргийн шинж, хүлээлгэх хариуцлагатай холбоотой хэм хэмжээнд бүрнээ нийцэхээр үр дүнд хүрч чадахааргүй байна. Тухайлбал, хүнийг хүчээр алга болгох үйлдэл нь зөвхөн “хууль бусаар” эрх чөлөөг нь хассан тохиолдлуудаар хязгаарлагдахгүй атал хуулийн төсөлд зөвхөн хууль бусаар эрх чөлөөг нь хассан үйлдлийг оруулж байх тул “хуулийн дагуу эхэлсэн” болон конвенцид зааснаар “өөр бусад хэлбэрээр” эрх хассан үйлдлүүд хамаарахгүйд хүрч байна.

Мөн Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгай чиг үүрэг бүхий байгууллагын удирдах болон гүйцэтгэх албан тушаалтнууд төсөлд тусгагдсан ч төрийн шууд болон шууд бус дэмжлэг авсан этгээдүүд гэмт хэрэгт хамтран оролцсон субъектэд

⁴⁵ Эрүүгийн хууль, 3.1.2 дугаар зүйл, <https://legalinfo.mn/mn/detail/11634> [Сүүлд үзсэн:2022.06.27].

тооцогдохгүй байгаа нь конвенцид заасан гэмт хэргийн шинжийг хангахгүй байна. Түүнчлэн Монгол Улс хэдий төрийн болон төрийн бус байгууллагын субъектийн үйлдсэн гэмт хэргүүдийг тусдаа заалтаар зохицуулахаар хуулийн төсөлд тусгасан байх боловч хоорондын ялгааг сайн гаргаж чадаагүй нь шүүхийн практикт, ялангуяа гэмт хэргийн зүйлчлэлийн хувьд асуудал үүсгэх эрсдэлтэй. "Хохирогчийг хуулийн хамгаалалтаас гадуур байлгах" шинж нь конвенцид заасан гэмт хэргийн үндсэн шинжүүдийн нэг юм. Монгол Улс энэхүү шинжийг мөн тусгаагүй байна.

Хүчээр алга болгохоос бүх хүнийг хамгаалах тухай ОУ-ын конвенцийн хэм хэмжээний хүрээ нь хүний эрх чөлөөг хязгаарласан үйлдэлд үйлчлэхээр байна. Харин ЭХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн зохицуулалт нь хохирол, хор уршиг учирснаар тухайн гэмт хэргийг үйлдсэнд тооцож байгаа юм. Ингэснээр эрх чөлөөг нь хязгаарласан үйлдэлд хариуцлага ногдуулах хүрээг хумьж байна.

Харин нэр томьёо, үг хэллэгийн хувьд "иргэний оршин суугаа газар" гэдэг нь ИХ-д тусгасан нэр томьёотой адил утгаар орчуулагдсан ч агуулгын хувьд ИХ-д заасан нэр томьёо биш юм. Мөн уг конвенцийг орчуулж Төрийн мэдээлэл сэтгүүлд нийтлүүлэхдээ "конвенц" гэдэг үгийг хоёр янзаар бичсэн байгааг анхаарах нь зүйтэй.

Энэхүү конвенцийн дагуу оролцогч улс бүр хүчээр алга болгох гэмт хэргийн онц ноцтой шинжийг харгалзан шийтгэл ногдуулах ёстой. Гэтэл Монгол Улсын тухайн төрлийн гэмт хэрэгт оногдуулж буй ялын хэмжээгээр авч үзвэл, хөнгөн гэмт хэрэгт тооцож байгаа нь конвенцид заасан онц ноцтой шинжийг авч үзээгүй бөгөөд ОУ-ын гэрээний үүргээ бүрэн биелүүлээгүй байна гэж үзэхэд хүргэж байна. Иймд үндсэн гэмт хэрэгт ногдуулах ялыг нэмэгдүүлж хөнгөн гэмт хэргүүдээс ялгамжтай зохицуулах шаардлагатай. Гэмт хэрэгт хамтран оролцогчдод хариуцлага хүлээлгэх хүрээнд Монгол Улс конвенцийн гэмт хэрэгт оролцогчдын талаарх зохицуулалтын б.а)-д заасан оролцогчдыг тусгасан байна. Харин конвенцийн б.б) -д заасан гэмт хэргийн субъектүүдийг орхигдуулжээ. Эдгээрээс үзэхэд ЭХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд, холбогдох заалтыг ОУ-ын гэрээнд нийцүүлэх тал дээр дахин нягтлах шаардлага байна гэж үзэв.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. АГААРЫН ХӨЛГИЙН БҮХЭЭГТ ҮЙЛДСЭН ГЭМТ ХЭРЭГ БОЛОН ТОДОРХОЙ БУСАД ҮЙЛДЛИЙН ТУХАЙ КОНВЕНЦ⁴⁶

Энэхүү конвенцийг Токиогийн конвенц гэж нэрлэдэг бөгөөд 1963 оны 09 дүгээр сарын 14-ний өдөр баталж, 1969 оны 12 дугаар сарын 04-ний өдөр хүчин төгөлдөр болсон. Монгол Улс 1990 оны 07 дугаар сарын 24-ний өдөр гарын үсэг зурж, нэгдэн орсон.

А. Агаарын хөлгийн бүхээгт үйлдсэн гэмт хэрэг болон тодорхой бусад үйлдлийн ойлголт, үндсэн шинж

1. Энэхүү конвенцийг дараах тохиолдолд хэрэглэнэ: (а) ЭХ-ийг зөрчсөн гэмт хэрэг; (б) гэмт хэрэг мөн эсэхээс үл шалтгаалан агаарын хөлөг, түүний дотор байгаа

⁴⁶ Төрийн мэдээлэл, Тусгай дугаар IV боть, МУ-ын ОУ-ын гэрээ, УБ, 2006, 895 дахь тал, <https://legalinfo.mn/mn/detail/1208> мөн эндээс үзнэ үү. [Сүүлд үзсэн:2022.06.25].

хүмүүс, эд хөрөнгө, түүнчлэн агаарын хөлгийн дотоод сахилга, дэг журамд аюул учруулсан хийгээд учруулж болзошгүй үйлдэл.⁴⁷

Уг конвенц нь агаарын хөлгийн бүхээгт үйлдэгдсэн, ЭХ-иар гэмт хэрэг гэж тооцсон үйлдлүүд буюу агаарын хөлгийн болон үүнд байгаа хүн, эд хөрөнгийн аюулгүй байдалд аюул учруулж байгаа болон агаарын хөлгийн бүхээгт дэг журам, сахилга батыг хангахад нэгдмэл хандлагыг тогтоох зорилготой.

Тухайн конвенцид заасан гэмт хэргийн тухайд, уг конвенцийн 11.1-р зүйлд агаарын хөлгийг хууль бусаар булаан авах үйлдлийг тусгахаар оролдсон боловч агаарын хөлгийг хууль бусаар булаан авах бүх хэлбэрийг багтаагаагүй бөгөөд "...хэлэлцэн тохирогч улсууд агаарын хөлгийн удирдлагыг түүний хууль ёсны даргад эгүүлэн өгөх буюу түүний хяналтад байлгахад шаардлагатай бүхий л арга хэмжээ авна." гэснээс өөрөөр талуудад тодорхой үүргийг бий болгоогүй. Өөрөөр хэлбэл, конвенцийн дээрх заалт гэмт хэрэг үйлдэх нөхцөл байдлыг заасан боловч гэмт хэргийг ОУ-ын хэмжээнд тодорхойлоогүй болно.⁴⁸ Иймд дээр дурдсан үйлдлүүдийг ОУ-ын эрх зүйн хүрээнд гэмт хэрэг гэж тооцдоггүй бөгөөд гэмт хэргийн тодорхойлолтыг гэрээлэгч улсын үндэсний хууль тогтоомжийн харьяалалд үлдээдэг.⁴⁹ Үүний үр дүнд уг конвенц нь улс төрийн шинж чанартай болон арьс өнгө, шашин шүтлэгээр ялгаварлан гадуурхах гэмт хэргээс бусад хэлэлцэн тохирогч улсын ЭХ тогтоомжийн дагуу гэмт хэрэгт тооцогддог аливаа үйлдэлд хамаарна (2-р зүйл).

Б. Монгол Улсын Эрүүгийн хуулийн нийцэл

Тэгвэл хууль бус гэж тооцсон үйлдлийг тухайн улсын ямар хуулиудын хүрээнд тооцох вэ; Ялыг ЭХ-д гэмт хэрэг гэж зааснаас гадна гааль, захиргааны гэх мэт харилцааг зохицуулсан хуулиудад заасан хууль бус үйлдэлд оноох ёстой юу гэсэн асуулт гарч ирдэг ч энэ талаар уг конвенцид тодорхойлоогүй. Тус конвенцийн үндсэн зорилгыг харгалзан үзвэл, ял оноох хууль тогтоомжийн хамрах хүрээ нь агаарын хөлгийн нислэгийн аюулгүй байдалд заналхийлж буй гэм хорын болон ЭХ-д заасан хууль бус үйлдлээр хязгаарлагдах ёстой гэж үзэх нь үндэслэлтэй⁵⁰.

Монгол Улсын хувьд агаарын хөлөг, түүний дотор байгаа хүмүүс, эд хөрөнгө, агаарын хөлгийн дотоод сахилга, дэг журамд аюул учруулсан хийгээд учруулж болзошгүй үйлдэлд хамаарах зарим үйлдлийг ЭХ-ийн 27 дугаар бүлэг болох "Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг" хэсэгт гэмт хэрэг болгон хуульчилж өгсөн. Монгол Улсад хүн алах, хүний бие, эд хөрөнгөд хохирол учруулах зэрэг конвенцид зааснаар агаарын хөлгийн бүхээгт үйлдэгдэх боломжтой гэмт хэргүүдийг аль хэдийн хуульчилсан боловч "нислэг үйлдэж буй агаарын хөлөгт", "агаарын хөлгийн бүхээгт" гэх мэтээр тухайн үйлдлийг тодруулж,

⁴⁷ Конвенцийн 1 дүгээр зүйл.

⁴⁸ Sayef Amin, Tokyo Convention: Offence, Jurisdiction (Include cases), Air And Aviation Law, Southeast University Department of Law & Justice LLM Final) -Program. Course Title: International Air and Aviation Law Course Code: LMF 3223, Section: A LLM (Final) – Program Date of Submission: 27/08/2013, <https://www.slideshare.net/SayefAmin1/sayef-amin-air-aviation-law>, [Сүүлд үзсэн: 2022.06.09].

⁴⁹ Commonwealth, Chapter two, Convention on offences and certain other acts committed on board aircraft 1963, ('Tokyo Convention') https://www.unodc.org/pdf/crime/terrorism/Commonwealth_Chapter_2.pdf, [Сүүлд үзсэн: 2022.05.25].

⁵⁰ Jung, Sung Yool, A Legal Analysis of Aviation Security under the International Legal Regime, A thesis submitted to McGill University in partial fulfillment of the requirements of the degree of Master of Laws (LL.M.) 2005, p.15-16.

бусад гэмт хэргээс ялгаж зохицуулсан гэмт хэргүүдэд: ЭХ-ийн 27.1 дүгээр зүйл.Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүн, усан онгоц, агаарын хөлгийн хөдөлгөөнд аюултайгаар халдах; 27.2 дугаар зүйл.Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүн, усан онгоц, агаарын хөлгийн хөдөлгөөнд аюул учруулах; 27.3 дугаар зүйл.Төмөр замын, агаарын, усан замын тээврийн хөдөлгөөний ба ашиглалтын аюулгүй байдлын журам зөрчих; 27.4 дүгээр зүйл.Нисэх багийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцох; 27.5 дугаар зүйл.Осол, зөрчилд өртсөн агаарын хөлгийн бодит хяналтын хэрэгслийг устгах, гэмтээх; 27.6 дугаар зүйл.Агаарын навигацийн тоног төхөөрөмжийг устгаж гэмтээх, нислэгийн хөдөлгөөнд саад учруулах; 27.7 дугаар зүйл.Агаарын хөдөлгөөний аюулгүй байдалд халдах; 27.8 дугаар зүйл.Агаарын хөлгийг авч зугтаах зэрэг үйлдлийг багтаасан байна.

Үүнээс “нислэг” үйлдэж буй гэж агаарын хөлгийг тодруулж өгснөөр конвенцийг хэрэглэх боломжийг харуулж байгаа гэмт хэрэг бол ЭХ-ийн 27.4 дүгээр зүйлд “Нисэх багийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцох” гэж шинээр тусгагдсан гэмт хэрэг буюу конвенцийн дагуу агаарын хөлгийн бүхээгт үйлдэгдэж болох зөрчлийг гэмт хэрэгт тооцсон заалт билээ. Мөн Зөрчлийн тухай хуулийн 14.8,14.9 дүгээр зүйлүүдэд Иргэний нисэхийн тухай хууль зөрчих болон Агаарын зайг нисэхэд ашиглах тухай хууль зөрчих зэрэг зөрчлүүдийг тусгасан байна. Гэвч энэхүү судалгааны хамрах хүрээний улмаас бусад хуульд заасан зөрчлүүдийн талаар судлаагүй болно.

Уг конвенц нь хэлэлцэн тохирогч улсад бүртгэлтэй агаарын хөлөг биш ч гэсэн: (a) гэмт хэрэг тухайн улсын нутаг дэвсгэрт ул мөрөө үлдээсэн; (b) гэмт хэргийг тухайн улсын иргэн буюу байнга оршин суугч өөрөө, эсхүл түүний эсрэг үйлдсэн байх; (c) гэмт хэрэг тухайн улсын аюулгүй байдлын эсрэг чиглэсэн; (d) гэмт хэрэг нь агаарын хөлгийн нислэг буюу хөдөлгөөний талаар тухайн улсад мөрдөгдөж буй аливаа дүрэм буюу журмыг зөрчсөн; (e) тухайн улс ОУ-ын олон талт хэлэлцээрээр хүлээсэн үүргээ биелүүлэхийн тулд хэргийн харьяаллаа хэрэгжүүлэх шаардлагатай байх ⁵¹ тохиолдлуудад агаарын хөлгийн бүхээгт үйлдэгдсэн гэмт хэргийн хувьд тухайн улс эрүүгийн хэргийн харьяаллаа хэрэгжүүлэхээр агаарын хөлөгт хөндлөнгөөс оролцохыг зөвшөөрснөөрөө ач холбогдолтой.

В. Дүгнэлт

Энэхүү конвенцид, хэдий тухайлсан гэмт хэргийг нэг бүрчлэн зааж, тодорхойлоогүй боловч агаарын хөлөгт үйлдэгдсэн гэмт хэргийн төрлүүдийг өргөнөөр авч хуульчилснаар, дээрх (b) хэсэгт дурдсанчлан дэлхийн хаана ч нислэг үйлдсэн Монгол Улсын иргэнийг хамгаалах, ОУ-ын хэмжээнд бусад улстай хамтран ажиллах, террорист үйлдэгчдийг шийтгэх, хэргийн харьяаллаа тогтоож тухайн хэргийг шийдвэрлэхэд өөрийн улсын хувь нэмрийг оруулах боломжийг Монгол Улсад олгож байх тул Монгол Улс агаарын хөлгийн бүхээгт үйлдэгдэж болох бүхий л гэмт хэргүүдийг багтаан хуульчлах хэрэгтэй юм. Ингэж иргэний нисэх, агаарын хөлгийн аюулгүй байдалд халдаж байгаа үйлдлүүдийн талаар бүрэн хуульчлахын тулд иргэний нисэхийн бусад гэрээ, конвенцид заасан, ОУ-д гэмт хэрэг гэж тооцогддог, энэхүү судалгааны тайлангийн бусад холбогдох бүлэгт авч үзэх агаарын хөлөг, нисэх буудлын аюулгүй байдалтай холбоотой гэмт хэргүүдийг ЭХ-даа нэг бүрчлэн тусгах нь зүйтэй.

⁵¹ Агаарын хөлгийн бүхээгт үйлдсэн гэмт хэрэг болон тодорхой бусад үйлдлийн тухай конвенц,1963, 3 дугаар зүйл, <https://legalinfo.mn/mn/detail/1208>, [Сүүлд үзсэн: 2022.05.16].

ГУРАВДУГААР БҮЛЭГ. АГААРЫН ХӨЛГИЙГ ХУУЛЬ БУСААР БУЛААН АВАХ ҮЙЛДЛИЙГ ХОРИГЛОХ ТУХАЙ КОНВЕНЦ⁵²

Энэхүү конвенцийг Гаагийн конвенц гэж нэрлэдэг бөгөөд 1970 оны 12 дугаар сарын 16-ны өдөр батлагдаж, 1971 оны 10 дугаар сарын 14-ний өдөр хүчин төгөлдөр болсон. Монгол Улс 1971 оны 1 дүгээр сарын 18-ны өдөр гарын үсэг зурж, 1971 оны 10 дугаар сарын 08-нд нэгдэн орсон.

А. Агаарын хөлгийг хууль бусаар булаан авах гэмт хэргийн ойлголт, үндсэн шинж

Конвенцийн 3 дугаар зүйлд заасанчлан хэлэлцэн тохирогч улс бүр дурдсан гэмт хэрэгт хүнд ял оногдуулах үүрэг хүлээхээр байна. Монгол Улсын хувьд ЭХ-иар гэмт хэрэгт ял оноох асуудлыг зохицуулдаг тул тухайн гэмт хэргийг ЭХ-даа тусгасан байх шаардлагатай юм.

Конвенцийн 1-р зүйлийн дагуу, нислэг үйлдэж байгаа агаарын хөлгийн бүхээгт: (а) хууль бусаар хүч хэрэглэх буюу хүч хэрэглэхээр заналхийлсэн, эсхүл айлган сүрдүүлэх бусад хэлбэрээр агаарын хөлгийг булаан авсан, эсхүл хяналтаа тогтоосон, эсхүл ийм үйлдэл хийхийг завдсан, эсхүл (b) ийм үйлдлийг үйлдсэн, эсхүл үйлдэхийг завдсан этгээдтэй хамтран оролцсон аливаа этгээдийг гэмт хэрэг үйлдсэн гэж үздэг.

Эдгээр гэмт хэрэг дараах үндсэн шинжийг агуулж байна. Үүнд:

1. Агаарын хөлгийг булаан авах буюу хяналтаа тогтоох үйлдэл;
2. Хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр, эсхүл бусад хэлбэрээр айлган сүрдүүлсэн байх;
3. Хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх үйлдлийн хууль бус байдал;
4. Нислэг үйлдэж буй агаарын хөлгийн бүхээгт үйлдэгдсэн байх гэсэн шинжүүд багтана.

Б. Монгол Улсын Эрүүгийн хуулийн нийцэл

1. Агаарын хөлгийг булаан авах буюу хяналтаа тогтоох үйлдэл

Конвенцид “агаарын хөлгийг хууль бусаар булаан авах” гэсэн нэр томъёонд тодорхойлолт өгөхийг зориогүй⁵³. Мөн агаарын хөлгийг булаан авах, эсхүл хяналтаа тогтоох гэсэн эдгээр хоёр үйлдлийг хооронд нь ялгаж үзэх шаардлагагүй⁵⁴ бөгөөд хамтад нь авч үзвэл нисгэгч онгоц барьцаалагчаар солигдсон, нисгэгч болон нисэх багийн бусад гишүүд, зорчигчид болон нийт агаарын хөлгийн эсрэг чиглэгдэж, барьцаалагчийн зааврыг дагаж мөрдөхийг тушаасан тохиолдлуудыг хамааруулдаг.

Монгол Улсын ЭХ-ийн 27.8 дугаар зүйлд Агаарын хөлөг авч зугтаах гэмт хэргийг “Агаарын хөлгийг авч зугтаах зорилгоор эзлэн авсан, нислэг үйлдсэн бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.” гэж тусгасан. Үүнд конвенцид

⁵² Төрийн мэдээлэл, Тусгай дугаар IV боть, МУ-ын ОУ-ын гэрээ, УБ, 2006, 865 дахь тал, <https://legalinfo.mn/mn/detail/1157> мөн эндээс үзнэ үү. [Сүүлд үзсэн: 2022.06.24].

⁵³ R.H. Mankiewicz, comments on The 1970 Hague Convention, Symposium on Hijacking (1971) 37 J.A.L.C 199.

⁵⁴ Common wealth, Chapter three, convention for the suppression of unlawful seizure of aircraft 1970 ('hague convention'), p.47. https://www.unodc.org/pdf/crime/terrorism/Commonwealth_Chapter_3.pdf, [Сүүлд үзсэн: 2022.04.09].

заасан гэмт хэргийн эхний шинж болох “агаарын хөлгийг булаан авах буюу хяналтаа тогтоох үйлдэл”-ийг “агаарын хөлгийг эзлэн авах” гэж оруулсан бол 2002 оны ЭХ-ийн 225 дугаар зүйлд “агаарын хөлөг авч зугтаасан” гэсэн үйлдлийг тодорхойлсон байна. Агаарын хөлөг авч зугтаах гэдгийг академич С. Нарангэрэл авч үзэхдээ агаарын хөлгийг хууль бусаар эзэмдэн авах⁵⁵ гэж тодорхойлжээ. Агаарын хөлгийг булаан авах буюу хяналтаа тогтоох үйлдлийн агуулгад агаарын хөлгийг эзлэн авах үйлдэл хамаарч болохоор байна.

2. Хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх, эсхүл бусад хэлбэрээр айлган сүрдүүлсэн байх шинж

Агаарын хөлгийг барьцаалсан нь зөвхөн хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх, бусад хэлбэрээр айлган сүрдүүлэх замаар үйлдсэн тохиолдолд гэмт хэрэг болно. Гэмт хэрэг нь агаарын хөлөгт байхгүй хүн, эд хөрөнгийн эсрэг хүч хэрэглэхээр заналхийлэхэд мөн хамаарч болно.⁵⁶

Харин “хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлэх, эсхүл бусад хэлбэрээр айлган сүрдүүлсэн байх” шинжийг 2002 оны ЭХ-ийн 225.2 дугаар зүйлд “Энэ хэргийг хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлж үйлдсэн, эсхүл хөлгийг авч зугтаах зорилгоор эзэлж авсан бол таваас дээш найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.” гэж агаарын хөлгийг авч зугтаасан үйлдлийн хүндрүүлэх бүрэлдэхүүн болгон авч үзсэн буюу агаарын хөлгийг хүч хэрэглэлгүйгээр авч зугтаасан байх боломжтойг харуулж байх боловч хуулийн тайлбарт “агаарын хөлгийг авч зугтаах гэж субъект хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлж агаарын хөлгийг эзлэн авч өөрийн сонгосон чиглэл, маршрутаар авч явахыг хэлнэ”⁵⁷ гэж тайлбарласан байна. Өрөөр хэлбэл агаарын хөлгийг авч зугтаах үйлдэл нь өөрөө хүч хэрэглэсэн байх шинжийг мөн агуулж байгаагаар тайлбарлажээ. 2015 оны ЭХ-иар уг шинжийг хассан бөгөөд “агаарын хөлгийг эзлэн авах” үйлдэлд нь хүч хэрэглэх болон хүч хэрэглэхээр заналхийлэх шинжийг багтааж хуульчилсан гэж судлаачид дүгнэсэн⁵⁸ байна. Эндээс гэмт хэргийн эхний хоёр шинжийн хувьд нэг шинж нь нөгөө шинжээ агуулдаг уу, эсхүл тусдаа бие даасан шинжүүд үү гэсэн асуулт гарч ирнэ.

Энэхүү гэмт хэргийг ОУ-ын эрх зүйд агаарын хөлгийг барьцаалах буюу “Aircraft hijacking” гэж нэрлэдэг ба нислэг үйлдэж буй иргэний агаарын хөлгийг буух газраас нь өөр газар буулгах зорилгоор хууль бусаар булаан авах, эсхүл тус агаарын хөлөгт хууль бусаар хяналтаа тогтоохыг хэлдэг.⁵⁹ Уг тодорхойлолт нь конвенцид зааснаас ялгаатай нь агаарын хөлгийг барьцаалж буй этгээд хууль бусаар булаан авах үйлдэлд хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлсэн байхыг шаардаагүй⁶⁰ байна. Түүнчлэн ОУ-ын иргэний нисэхийн байгууллага (ICAO)-ын Хууль зүйн хороо тухайн заалтын төслийн хэлэлцүүлэгт Австрали улсын төлөөлөгчийн гаргасан “агаарын хөлөгт хууль бусаар хяналтаа тогтоох үйлдэлд “бусад байдлаар” гэж нэмж оруулснаар хүч хэрэглэх, хүч

⁵⁵ С. Нарангэрэл, *Эрх зүйн эх толь бичиг*, Уб, 2007, 10 дахь тал.

⁵⁶ Common wealth, Chapter three, Convention for the suppression of unlawful seizure of aircraft 1970 (‘Hague Convention’) https://www.unodc.org/pdf/crime/terrorism/Commonwealth_Chapter_3.pdf, p.47.

⁵⁷ Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар, Монгол Улсын дээд шүүх, Ханнс-Зайделийн сангийн Монгол дахь төлөөлөгчийн газар, Уб, 2013, 557 дахь тал.

⁵⁸ С. Гантулга, Б. Энхболд, *Эрүүгийн эрх зүйн тусгай анги (сурах бичиг)*, Уб, 2018, 513 дахь тал.

⁵⁹ Rafat, Amir. “Control Of Aircraft Hijacking: The Law Of International Civil Aviation.” *World Affairs*, vol. 134, no. 2, World Affairs Institute, 1971, p.144.

⁶⁰ Мөн тэнд.

хэрэглэхээс заналхийлэхээс гадна бусад байдлаар хяналтаа тогтоох жишээ нь нисгэгчид хахууль өгөх, үгсэн хуйвалдах зэргээр хүч хэрэглэхгүйгээр хяналтаа тогтоох тохиолдлуудыг хамруулна” гэсэн саналыг 7/25-гийн харьцаатай дэмжээгүйгээс⁶¹ булаан авах... үйлдэл болгон хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлсэн байх шаардлагагүй, мөн тухайн заалтын агуулгыг буюу конвенцид заасан гэмт хэрэг нь зөвхөн хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлж агаарын хөлгийг булаан авах тохиолдлуудыг л хамааруулахыг эрмэлзсэн нь конвенц боловсруулагчдын байр суурь юм. Иймд агаарын хөлгийг булаан авах, хяналтаа тогтоох үйлдэл нь хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх... үйлдлийг агуулах боломжтой ч, конвенцийн агуулгад булаан авах шинжийг тодотгож өгч буй зайлшгүй байх ёстой нэг шинж болж байна. Уг шинжийг заавал агуулсны үндсэн дээр агаарын хөлөг булаан авсан үйлдэл нь уг конвенцийн дагуу гэмт хэрэгт тооцогдох ёстой. Тиймээс ч конвенцид, булаан авсан буюу хяналтаа тогтоосон үйлдлийг тодотгохын тулд хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлсэн шинжийг тусгайлан дурдаж өгсөн болов уу. Одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй ЭХ-д энэхүү шинжийг хасаж хуульчилснаар, “эзлэн авах” үйлдэлд хүч хэрэглэсэн шинж багтаж байгаа гэж тайлбарлахад бас асуудалтай юм.

3. Хүч хэрэглэх, заналхийлэх үйлдлийн хууль бус байдал

Тус конвенцийн 1-р зүйлд заасан “хууль бусаар” гэдэг нь тухайн үйлдлийг хуулиар зөвшөөрөөгүй, хууль ёсны үндэслэлгүй байхыг ойлгоно. Гурав дахь шинж болох эдгээр үйлдлүүд хууль бус байх шинж нь өөрөөр хэлбэл эдгээр үйлдэлд хууль зүйн үндэслэл байх ёсгүй⁶² гэсэн үг юм. Монгол Улс ЭХ-даа энэ төрлийн гэмт хэргийг хуульчилж гэмт хэрэгт тооцон ял оногдуулахаар заасан тул дээрх шинжийг агуулсан гэж үзнэ.

4. Нислэг үйлдэж буй агаарын хөлгийн бүхээгт үйлдэгдсэн байх шинж

Энэхүү конвенцийн 3 дугаар зүйлийн 1-д зааснаар конвенцийн зорилгод зааснаар, ачаалсны дараа бүх гадна хаалгыг хаасан үеэс эхлэн ачаа буулгахаар уг хаалгуудын аль нэгийг нээх хүртэл агаарын хөлгийг нислэг үйлдэж байгаад тооцно. Албадан буулт хийлгэсэн тохиолдолд зохих эрх бүхий этгээд агаарын хөлөг, түүний бүхээгт байгаа хүмүүс, эд хөрөнгийн төлөө хүлээх хариуцлагыг өөртөө шилжүүлж авах хүртэл нислэгийг үргэлжилж байгаад тооцдог.

Түүнчлэн энэхүү Гаагийн конвенц нь гэмт хэрэг үйлдсэн агаарын хөлгийн хөөрөх газар буюу бодит буух газар нь тухайн агаарын хөлгийг бүртгүүлсэн талын нутаг дэвсгэрээс гадуур байгаа тохиолдолд л үйлчилдэг. Иймд А талд бүртгэгдсэн агаарын хөлгөөр тухайн талын нутаг дэвсгэрт орон нутгийн нислэг үйлдэж байх үед онгоц барьцаалагдсаны улмаас бодит буух цэг нь тухайн нутаг дэвсгэрийн гадна байгаа тохиолдолд уг конвенцийг хэрэглэнэ. Энэхүү конвенц нь В талын нутаг дэвсгэрийн хоёр цэгийн хооронд нислэг үйлдэж байх үед А талд бүртгэгдсэн агаарын хөлөгт хийсэн үйлдэлд мөн хамаарна. Иймээс конвенцийг хэрэглэх хүрээнд газарт байгаа буюу конвенцид тодорхойлсон нислэг үйлдээгүй үеийн агаарын хөлөг хамаарахгүй.

⁶¹ Legal committee, 17th session, p.28, para 39, 41.

⁶² Shubber, Sami. “Aircraft Hijacking under the Hague Convention 1970: A New Regime?” *The International and Comparative Law Quarterly*, vol. 22, no. 4, [Cambridge University Press, British Institute of International and Comparative Law], 1973, p.696, <http://www.jstor.org/stable/757662>. , [Сүүлд үзсэн.2022.05.22].

Нислэг үйлдэж буй агаарын хөлөгт гэмт хэрэг үйлдэгдсэн байх дөрөв дэх шинжийг 2002 оны хуульд “*нислэгт буюу газарт байгаа агаарын хөлгийг* авч зугтаасан” гэж хуульчилсан байхад 2015 оны хуулиар, “агаарын хөлгийг авч зугтаах зорилгоор эзэлж авсан, мөн зорилгоор агаарын хөлгөөр *нислэг үйлдсэн бол*” гэж тус тусдаа хоёр үйлдэл болгож тусгасан. Ингэснээр:

Нэгдүгээрт, “эзлэн авсан” гэсэн объектив шинжийг тодруулсан⁶³ боловч агаарын хөлгийг илэрхийлэх нөхцөл байдлыг нэгд, ерөнхийлсөн буюу жишээ нь грашдаа байгаа болон зорчигчгүй, цэргийн зэрэг бүх төрлийн агаарын хөлөг хамаарахаар зохицуулснаар өөр өөр мөн чанартай гэмт хэргүүдийг нэгтгэж үзсэн байна. Харин энэхүү конвенц нь зөвхөн иргэний агаарын хөлөгт хамаарах бөгөөд цэрэг, гааль, цагдаагийн үйлчилгээнд ашигладаг агаарын хөлөгт хамаарахгүй⁶⁴ буюу конвенцийн зорилго нь иргэний нисэхийн аюулгүй байдлыг хамгаалахад оршдог.

Мөн ЭХ-ийн 27.4-т заасан нисэх багийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцох гэмт хэрэгт “нислэг” гэдгийг тодорхойлж, нислэг үйлдэж байхад уг гэмт хэрэг үйлдэгдэж байгаа гэдгийг тодруулснаар Токио болон Монреалийн конвенцид заасан үйлдлийг хамарч байгаа. Гэвч ЭХ-ийн агаарын хөлөгт холбогдох гэмт хэргүүдийн зөвхөн энэ заалтад л “нислэг” гэдгийг тодорхойлсноор энэхүү шинж нислэгийн үед үйлдэгдэж байгаа бусад гэмт хэрэг, ялангуяа Гаагийн конвенцид заасан агаарын хөлгийг булаан авах гэмт хэргийн хувьд орхигдож байгаа юм. Өөрөөр хэлбэл зарим конвенцид хамаарах гэмт хэргийг хуульчлахдаа конвенцид заасан шинжийг хуульчилсан мөртөө өөр конвенцид тухайн шинжийг зааж, мөн л нислэг үйлдэж байх үеийн гэмт хэргийг тусгасан байхад конвенцийн холбогдох гэмт хэргийн шинж болгож ЭХ-д хуульчлаагүй нь өрөөсгөл тул хуульд эдгээр шинжийг нислэгт буй агаарын хөлөгт холбогдох гэмт хэргүүдэд бүгдэд нь жигд тусгах хэрэгтэй.

Хоёрдугаарт, 2015 оны хуулийн дагуу агаарын хөлгөөр нислэг үйлдэх үйлдлийг хийснээр гэмт хэрэг төгсөхөөр байна. Өөрөөр хэлбэл нислэг үйлдсэнийг гэмт хэргийн үндсэн үйлдэл болгож хуульчилснаар ЭХ-ийн 17.1 дүгээр зүйлд заасан хулгайлах гэмт хэрэгтэй адил зүйлчлэх эрсдэлийг үүсгэж байгаа бөгөөд конвенцийн зорилго, тухайн гэмт хэрэгт хамгаалагдах эрх ашиг болон ЭХ-д хуульчилсан хууль ёсны болон шударга ёсны зарчмаас хазайсан байна. Харин конвенцид заасны дагуу энэ нь гэмт хэргийн үйлдэл биш үйлдлийг тодотгосон шинж болж байгаа юм.

Гуравдугаарт, конвенцийн хувьд, авч зугтаах зорилгыг тусгаагүй ба зөвхөн агаарын хөлгийг булаан авах буюу хяналтаа тогтоох үйлдэл л байх ёстой гэж заасан. Энэ үйлдэл нь дээр дурдсанчлан барьцаалагчийн заавраар хэрэгжинэ. Барьцаалагч хэрвээ агаарын хөлгийг авч зугтаах заавар өгөөгүй бол энэхүү конвенцид заасан гэмт хэрэгт хамаарахааргүй байна.

5. Гэмт хэргийн субъект

Субъектийн хувьд, гэмт хэргийг зөвхөн онгоцонд зорчиж буй этгээд үйлдсэн байхаар заасан. Өөрөөр хэлбэл, субъектийн уг хязгаарлалтаар өөр агаарын хөлгөөс, эсхүл онгоц нисэхээс өмнө онгоцонд тэсрэх бодис тавьж нислэгийг сүрдүүлэх

⁶³ ХЗДХЯ, *Эрүүгийн хуулийн шинэчлэсэн найруулга* (Сурагч багш нарт зориулсан гарын авлага), Уб, 2017, 272 дахь тал.

⁶⁴ Агаарын хөлгийг хууль бусаар булаан авах үйлдлийг хориглох тухай конвенц, 3.2 дугаар зүйл.

тохиолдлууд хамаарахгүй гэсэн үг юм. Харин 2015 оны хуулийн дагуу субъект нь ЭХ-д заасан хэрэг хариуцах чадвартай, 16 насанд хүрсэн нийтлэг субъект байхаар заасан ба конвенцид хамаарахгүй бусад субъектүүдийг багтааж нийтлэг байдлаар өргөжүүлж зохицуулсан байна. Хэдий гэмт хэргийн субъект өргөн байснаараа илүү өргөн хүрээний тохиолдлуудыг хамрах боломжтой мэт боловч дээр дурдсан тохиолдлууд нь конвенцийг хэрэглэх хүрээнд багтаж, конвенцид заасан гэмт хэрэг болж чадах уу гэдэг нь өөр асуудал юм.

6. Конвенцийн дагуу хүлээх үүрэг

Конвенцийн 2 дугаар зүйлд зааснаар хэлэлцэн тохирогч улс бүр дурдсан гэмт хэрэгт хүнд ял оногдуулах үүрэг хүлээнэ. Гэхдээ улс орнуудад ял оногдуулах практик өөр өөр байдаг тул гэмт хэрэгт хорих ялын хэмжээ болон бусад байдлаар тодорхой шийтгэл оногдуулаагүй. Өөрөөр хэлбэл энэхүү заалт нь тухайн улсын бүрэн эрхт байдалд зүй бусаар нөлөөлөх бөгөөд энэ нь хэлэлцэн тохирогч олон орны конвенцийг соёрхон батлах хүчин чармайлтад саад учруулах тул конвенцид, хэлэлцэн тохирогч улсуудад хүлээлгэх ялын доод хэмжээг заагаагүй⁶⁵ ч, хэлэлцэн тохирогч улсууд нь конвенцийн 7 дугаар зүйлд заасны дагуу өөрийн улсын хилийн дотор гарсан ноцтой гэмт хэрэгт хамаарах дотоодын хууль тогтоомжид заасан ялыг зөвхөн улс бүрийн онцгой бүрэн эрхийн хүрээнд хэрэглэх үүрэгтэй.⁶⁶ Иймээс конвенцид гэмт хэргийн ноцтой байдлыг харуулсан шийтгэл ногдуулахыг шаарддаг тул зохистой гэж үзвэл бүх насаар нь хорих ялыг оролцуулан тухайн улсын хувьд ялын дээд хэмжээг ногдуулах ёстой байна.⁶⁷

2015 оны ЭХ-ийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг 2 жил, түүнээс дээш хугацаагаар оногдуулахаар тогтоосон гэмт хэргийг хүнд гэмт хэрэгт⁶⁸ тооцдог ба дээрх гэмт хэрэгт 5-12 жил, хүндрүүлэх бүрэлдэхүүнд нь 12-20 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр заасан байх тул Монгол Улс энэхүү конвенцид заасан гэмт хэргийг мөн хүнд гэмт хэрэгт тооцсон. Ингэснээр уг ОУ-ын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлсэн байна. Харин 2002 оны ЭХ-д заасан гэмт хэргийн ангиллын дагуу, уг гэмт хэрэг хүндэвтэр гэмт хэрэгт багтсан буюу конвенцид заасан хамгийн дээд ял оноох үүргээ дутуу биелүүлж байсанд тооцогдоно.

Хамтран оролцогчдод хариуцлага хүлээлгэх нь

Гэмт хэрэгт хамтран оролцогчдод адил хариуцлага онооно. Конвенцийн 1.(b)-д заасанчлан ийм үйлдлийг үйлдсэн, эсхүл үйлдэхийг завдсан этгээдтэй хамтран оролцсон буюу гэмт хэрэг үйлдсэн, эсхүл үйлдэхийг завдсан этгээдтэй хамтарч оролцсон аливаа этгээд, хэрэв тухайн хүний үйлдэл нь мөн агаарын хөлөгт үйлдэгдсэн бол түүнийг мөн гэмт хэрэг үйлдсэнд тооцно. ЭХ-д гэмт хэрэг үйлдсэн, эсхүл үйлдэхийг завдсан этгээдтэй хамтран оролцсон аливаа этгээдийг гэмт хэргийн гүйцэтгэгч, хамжигч, хатгагч, зохион байгуулагч зэргээр тусгасан. Гэсэн ч конвенцийн хүрээнд гэмт

⁶⁵ Abraham Abramovsky, "Multilateral Conventions for the Suppression of Unlawful Seizure and Interference with Aircraft, Part II: The Montreal Convention" (1975) 14 Colum. J. Transnat'l L.268 at 295.

⁶⁶ Mc Whinney, "Edward, Aerial Piracy and International Terrorism, The illegal Diversion of Aircraft and International Law", 2nd ed. (Dordrecht, the Netherlands ; Boston:Martinus Nijhoff, 1987). pp 42.

⁶⁷ Commonwealth, Chapter three, convention for the suppression of unlawful seizure of aircraft 1970 ('hague convention'), p.71. https://www.unodc.org/pdf/crime/terrorism/Commonwealth_Chapter_3.pdf

⁶⁸ Монгол Улсын Эрүүгийн хууль, 2.6.1 дүгээр зүйл, <https://legalinfo.mn/mn/detail/11634>, [Сүүлд үзсэн:2022.03.02].

хэргийг нуун дарагдуулсан этгээдийг хамтран оролцсон “аливаа этгээд”-д хамааруулж байгаа нь тодорхойгүй тул конвенцид заасныг тодорхой хэмжээгээр хангасан гэж үзнэ.

Гэмт хэрэг үйлдсэн, үйлдэхээр завдсан этгээд болон хамтран оролцсон этгээдүүдэд, бүгдэд нь хамгийн дээд хэмжээний ял оноохоор конвенцид тусгасан. Монгол Улсын ЭХ-д гэмт хэрэг үйлдэхээр завдсан тохиолдолд шүүх уг үйлдлийн шинж ба гэмт хэргийг төгсгөж чадаагүй нөхцөл байдлыг харгалзан энэ хуулийн тусгай ангид тухайн гэмт хэрэгт оногдуулахаар заасан ялын дээд хэмжээний гуравны хоёроос хэтрүүлэхгүйгээр ял оногдуулна⁶⁹ гэж заасан байна. Үүнээс үзвэл уг гэмт хэрэг үйлдэхээр завдсан этгээдэд 12 жилийн гуравны хоёр буюу 8 жилээс хэтрүүлэхгүй хорих ял оноохоор байна. Энэ нь мөн хуульд зааснаар хүнд гэмт хэрэгт тооцогдсон хэвээр байна. Харин АНУ-д агаарын хөлгийг барьцаалах гэмт хэргийг АНУ-ын холбооны хуулиудын эмхэтгэлд тусгасан байдаг бөгөөд энэхүү үйлдэлд хамгийн багадаа 20 жил, хүний амь нас эрсэдсэн бол бүх насаар хорих зэрэг ял оноодог.⁷⁰ Иймээс Монгол Улсын хувьд энэхүү гэмт хэрэг нь хүнд гэмт хэрэгт тооцогдож байгаа ч оногдуулах ялын хэмжээ нь бага байхыг үгүйсгэхгүй юм.

Гэмт хэрэгт хамтран оролцогчдын хувьд, хамжигч этгээдэд гүйцэтгэгчээс ихгүй ял оногдуулж⁷¹ байгаа бол гэмт хэргийн хатгагчид гүйцэтгэгчээс багагүй⁷² ял оногдуулахаар тус тус заажээ. Иймд гэмт хэрэгт хамтран оролцогчдод мөн ял оногдуулахаар хуульчлах үүргээ зохих ёсоор биелүүлсэн байна.

В. Дүгнэлт

Дээр дурдсан байдлаас дүгнэвэл, агаарын хөлөг авч зугтаах гэмт хэргийг Монгол Улс ЭХ-даа тусгасан байна Гэвч “хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх эсхүл бусад хэлбэрээр айлган сүрдүүлсэн байх” зэрэг шинжийг тодорхойлоогүй бөгөөд конвенцид заасны дагуу нислэг үйлдэж буй “агаарын хөлгийн бүхээгт үйлдэгдсэн байх шинж” буюу үйлдлийг тодотгосон шинжийг гэмт хэргийн үйлдэл болгож тусгажээ. Ингэснээр ЭХ-д заасан бусад гэмт хэргийн төрөлтэй төстэй болж, конвенцид заасан агуулгаас зөрүүтэй болоход хүрч байна. Харин энэ төрлийн гэмт хэрэгт 5-12 жил, хүндрүүлэх нөхцөлд нь 12-20 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэж зааснаар Монгол Улс хүнд гэмт хэрэгт тооцон хуульчилж, конвенцид заасан үүргээ биелүүлсэн. Мөн конвенцийн дагуу, уг төрлийн гэмт хэрэгт хамтран оролцогчдод мөн хариуцлага хүлээлгэж, гүйцэтгэгчээс багагүй ял оноох үүргээ эрх зүйн хүрээнд биелүүлсэн байна.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ИРГЭНИЙ НИСЭХИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЭСРЭГ ХУУЛЬ БУС ҮЙЛДЛИЙГ ХОРИГЛОХ ТУХАЙ МОНРЕАЛИЙН КОНВЕНЦ⁷³

Энэхүү конвенц 1971 оны 09 дүгээр сарын 23-ны өдөр батлагдаж, 1973 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр хүчин төгөлдөр болсон. Монгол Улс 1972 оны 02 дугаар сарын 18-ны өдөр гарын үсэг зурж, 1972 оны 09 дүгээр сарын 14-нд соёрхон баталсан.

⁶⁹ Монгол Улсын Эрүүгийн хууль, 2.8.2 дугаар зүйл, <https://legalinfo.mn/mn/detail/11634>, [Сүүлд үзсэн: 2022.03.02].

⁷⁰ U.S. Code, Title 49, subtitle VII, part A, subpart IV, chapter 465, § 46502, <https://www.law.cornell.edu/uscode/text/49/46502> [Сүүлд үзсэн: 2022.05.10].

⁷¹ Монгол Улсын Эрүүгийн хууль, 3.5.2 дугаар зүйл, <https://legalinfo.mn/mn/detail/11634> [Сүүлд үзсэн: 2022.06.27].

⁷² Мөн тэнд, 3.4.2 дахь заалт.

⁷³ Төрийн мэдээлэл, Тусгай дугаар IV боть, МУ-ын ОУ-ын гэрээ, УБ, 2006, 870 дахь тал, <https://legalinfo.mn/mn/detail/1158> мөн эндээс үзнэ үү. [Сүүлд үзсэн: 2022.04.16].

А. Иргэний нисэхийн аюулгүй байдлын эсрэг хууль бус үйлдлүүдийн ойлголт, үндсэн шинж

1. Хэрэв аливаа этгээд дараах үйлдлийг хууль бусаар болон санаатайгаар үйлдсэн бол түүнийг гэмт хэрэг үйлдсэн гэж үзнэ⁷⁴: (а) нислэг үйлдэж буй агаарын хөлгийн бүхээгт яваа хүний эсрэг хүч хэрэглэсэн бөгөөд энэ нь тухайн агаарын хөлгийн аюулгүй байдалд эрсдэл учруулахаар байвал;

(b) нислэг хийх боломжгүй болгох буюу нислэгийн үед аюул учруулахуйц байдлаар ашиглалтад байгаа агаарын хөлгийг бүрмөсөн эвдсэн, эсхүл түүнд гэмтэл учруулсан;

(c) ашиглалтад байгаа агаарын хөлгийг эвдэх, эсхүл түүнийг бүрмөсөн эвдэх буюу нислэг үйлдэх боломжгүй болохуйц хохирол учруулахаар гэмтээх чадалтай төхөөрөмж, бодисыг ямар нэг аргаар байрлуулах буюу байрлуулахад чиглэсэн үйл ажиллагаа явуулсан;

(d) агаарын навигацийн тоног төхөөрөмжийг эвдсэн, гэмтээсэн, эсхүл түүний ашиглалтад саад учруулсан бөгөөд аливаа иймэрхүү үйл ажиллагаа нь агаарын хөлгийн нислэгийн аюулгүй байдалд аюул учруулсан;

(e) худал гэдгийг нь мэдсээр байж агаарын хөлгийн нислэгт аюул учруулж болохуйц мэдээлэл өгснийг тус тус гэмт хэрэг үйлдсэн гэж үзнэ.

2. Хэрэв аливаа этгээд дараах үйлдлийг гүйцэтгэсэн бол түүнийг гэмт хэрэг үйлдсэн гэж бас үзнэ:

(a) энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэргийг үйлдэхээр завдсан;

(b) ийм гэмт хэрэг үйлдсэн буюу үйлдэхийг завдаж байгаа этгээдийн үйлдэлд хамтран оролцсон.

Гаагийн конвенцид заасан гэмт хэрэг нь нисэх онгоцыг хорлон сүйтгэх, устгах үйлдэлд хамаарахгүй бөгөөд гэмт хэргийг зөвхөн онгоцон дотор байгаа этгээд үйлдэхээр зааснаар конвенцийн хамрах хүрээнд хязгаарлалт тавьдаг. Иймээс энэхүү хязгаарлалтад хамаарахгүй үйлдлийг таслан зогсоох, шийтгэх талаар зохицуулсан нэмэлт гэрээ байгуулах шаардлагын үндсэн дээр Монреалийн конвенц батлагдсан. Уг конвенцид иргэний нисэхийн аюулгүй байдлын эсрэг 5 төрлийн гэмт хэргийг тусгасан. Тохиолдол тус бүрд эдгээр үйлдэл нь хууль бус бөгөөд санаатайгаар үйлдэгдсэн байх ёстой.⁷⁵ Уг үйлдэл нь санаатай байх ёстой гэсэн шаардлага нь зөвхөн хийсэн үйлдэлд хамаарахаас түүний үр дагаварт хамаарахгүй.⁷⁶ Өөрөөр хэлбэл үр дагаврыг санаатай бий болгосон байх шаардлагагүй гэсэн хэлбэрийн бүрэлдэхүүнтэй гэмт хэрэг байна.

⁷⁴ Конвенцийн 1 дүгээр зүйл.

⁷⁵ Common wealth, Chapter Four, Convention For The Suppression Of Unlawful Acts Against The Safety Of Civil Aviation 1971 ('Montreal Convention'), p.77.

https://www.unodc.org/pdf/crime/terrorism/Commonwealth_Chapter_4.pdf, [Сүүлд үзсэн: 2022.04.09].

⁷⁶ Мөн тэнд.

1. Конвенцийн хамрах хүрээ

Нислэг нь ОУ-ын болон дотоодын нислэгээс үл хамааран Монреалийн конвенцийн 4 дүгээр зүйл болон Гаагийн конвенцийн 3 дугаар зүйлд заасан гадаад бүрэлдэхүүнтэй байх нь эдгээр конвенцийг хэрэглэх гол нөхцөл болдог. Гаагийн конвенцийн 3(2) дахь зүйлтэй нэгэн адил, энэхүү конвенц нь зөвхөн иргэний агаарын хөлгүүдэд хамаарах бөгөөд цэрэг, гааль, цагдаагийн байгууллагад ашиглагдах агаарын хөлөгт хамаарахгүй.⁷⁷ Мөн энэхүү конвенцийн зорилгод нислэг үйлдэж буй онгоц нь Гаагийн конвенцид заасантай адил утгаар хэрэглэгдэнэ. Харин ашиглалтад байгаа гэж газрын бие бүрэлдэхүүн буюу багаас тодорхой нислэг хийхээр агаарын хөлгийг нислэгийн өмнө бэлтгэж эхэлсэн үеэс уг агаарын хөлөг талбайд бууснаас хойш хорин дөрвөн цаг өнгөрөх хүртэл хугацаанд агаарын хөлгийг ашиглалтад байгаад тооцох⁷⁸-оор конвенцид заасан. Мөн агаарын хөлөг нислэгээ аль ч тохиолдолд үргэлжлүүлж байгаа бүх хугацааг онгоц ашиглалтад байгаа хугацаанд тооцдог. ЭХ-д заасан агаарын хөлөг нь ОУ-ын болон дотоодын нислэг үйлдэж байсан эсэхээс үл хамааран Монгол Улсад бүртгэлтэй агаарын хөлөг, агаарын навигацийн тоног төхөөрөмжид хамаарна.

Б. Монгол Улсын Эрүүгийн хуулийн нийцэл

Конвенцид тусгасан гэмт хэргүүдийн төрлийг нэг бүрчлэн авч үзье.

1. Нислэг үйлдэж буй агаарын хөлгийн бүхээгт яваа хүний эсрэг хүчирхийлсэн бөгөөд энэ нь тухайн агаарын хөлгийн аюулгүй байдалд аюул учруулах гэмт хэрэг

Энэ төрлийн гэмт хэрэгт дараах шинжүүд байна. Үүнд:

- 1) Хүний эсрэг хүчирхийлсэн үйлдэл байх;
- 2) Тухайн хүн нь агаарын хөлгийн бүхээгт байх;
- 3) Агаарын хөлөг нь нислэг үйлдэж буй байх;
- 4) Хүчирхийлсэн үйлдэл нь агаарын тухайн хөлгийн аюулгүй байдалд аюул учруулах шинжтэй байх зэрэг орно.

а) Force ба Violence

“Төрийн мэдээлэл” сэтгүүлд тус конвенцийг нийтлэхдээ “act of violence” гэдэг үйлдлийг “хүч хэрэглэсэн” гэж орчуулсан байх бөгөөд энэ нь Агаарын хөлгийг хууль бусаар булаан авах үйлдлийг хориглох тухай Гаагийн конвенцид заасан хууль бусаар хүч хэрэглэх буюу хүч хэрэглэхээр заналхийлсэн... бусад хэлбэрээр агаарын хөлгийг булаан авах гэмт хэргийн “by force” буюу хүч хэрэглэх (use of force) үйлдэлтэй нэгэн адил орчуулагджээ. АНУ-ын холбооны хуулиудын эмхэтгэлд агаарын хөлгийг дээрэмдэх гэмт хэргийг (A) “*aircraft piracy*” means *seizing or exercising control of an aircraft in the special aircraft jurisdiction of the United States by force, violence, threat of force or violence, or any form of intimidation, and with wrongful intent.*⁷⁹ гэж тодорхойлохдоо дээрх үйлдлүүдийн аль нэгийг нь бус, хоёуланг нь “эсхүл” гэж үгээр холбож тусгасан байна. Мөн Гаагийн конвенцид заасан хүч хэрэглэхээр заналхийлэх (threat of force) үйлдэл нь “*The threat of force contemplates all cases where the use of force or violence is*

⁷⁷ Тус конвенцийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг.

⁷⁸ Convention for the suppression of unlawful acts against the safety of civil aviation, (1971), Article 2(b).

⁷⁹ U.S. Code, Title 49, SUBTITLE VII, PART A, subpart iv, CHAPTER 465, § 46502, <https://www.law.cornell.edu/uscode/text/49/46502> с, [Сүүлд үзсэн:2022.04.15].

*threatened against members of the crew or passengers, or the aircraft itself.*⁸⁰ гэж агаарын хөлөг, түүний зорчигчид болон хөлгийн багийн гишүүдэд аюул учруулж байгаа хүч хэрэглэсэн, эсхүл хүчирхийлсэн үйлдлүүдийг⁸¹ тус бүрд нь харгалзаж үзэхээр тайлбарласан байна.

“Use of force” нэр томъёог ОУ-д ихэвчлэн хууль сахиулагч баривчлах, таслан зогсоох үйлдлийг хэтрүүлж хүч хэрэглэсэн болон зэвсэгт мөргөлдөөний үед цэргүүд хүч хэрэглэсэн зэргээр хэрэглэдэг бөгөөд эсрэгээрээ хууль сахиулагч нарт хэтрүүлж “act of violence” хийсэн гэж хэрэглэх нь цөөн юм. Мөн эрдэмтэн Уиллиамс⁸² хүчирхийллийн 7 шинжийг авч үзсэн байх бөгөөд үүнд “use of physical force” буюу биеийн хүч хэрэглэсэн үйлдлийг хамааруулж байна. Америкийн прагматист Жон Дьюи үзэхдээ “хүнийг живэхээс аврах эсвэл хэн нэгнийг өөрийгөө гэмтээхээс урьдчилан сэргийлэх зэрэг нь бүгд хүчирхийлэл биш гэдгийг илтгэх бөгөөд хүчирхийллийн бүх үйлдэлд ч хүч хэрэглэсэн байх шаардлагагүй, жишээ нь хордуулах замаар алах гэх мэт” гэж хэлжээ. Харин түүний хэлснээр хүч нь хор хөнөөлтэй, аюултай болсон үед л хүчирхийллийн үйлдэл болж хувирдаг ба үүнээс гадна хүчирхийлэл болохын тулд санаатай буюу зориуд үйлдсэн байх ёстой гэж үздэг.⁸³

Монреалийн конвенцийн хүрээнд, “хүчирхийлсэн үйлдэл” гэдэгт зэвсэгт халдлага, агаарын хөлөгт сууж явсан хүмүүсийн амь насанд халдах, цохих, боомилох, хордуулах, үхэлд хүргэх тарилга хийх зэрэг бусад аргаар халдсан халдлагууд орно.⁸⁴ Харин конвенцийн төсөлд⁸⁵ зөвхөн зэвсэгт халдлагыг оруулахаар тусгасан байжээ.

Монгол Улсад “use of violence”-ыг “хүчирхийлсэн” гэж үг хэллэгээр биш хүч хэрэглэсэн шинжтэй адилхан тайлбарлан хэрэглэж байгаа бөгөөд “хүч хэрэглэсэн” гэдэгт хохирогч гэмт этгээдийг зодох, өвтгөх, эрүүл мэндэд нь хохирол учруулах зэргээр бие махбодод халдсаныг⁸⁶ буюу субъект хохирогчийн биед шууд хүч хэрэглэсэн үйлдлээр халдсаныг⁸⁷ ойлгохоор байгаа нь мөн Монгол Улсын эрүүгийн хэргийн шүүхэд хүний биеийг хутгалсан үйлдлийг хүч хэрэглэсэн үйлдэлд тооцон гэмт хэргийг шийдвэрлэж⁸⁸ байна. Үүнээс үзэхэд, конвенцид зааснаар зорчигчдын амь насанд халдсан халдлага болон зэвсэгт халдлага зэрэг конвенцийн үйлчлэх хүрээний бүх үйлдлийг хүч хэрэглэсэн үйлдэлд багтааж байгааг анзаарч болох юм.

Гэхдээ Монгол Улсын ЭХ-д нэгэнт хүч хэрэглэсэн үйлдэл болон хүчирхийлсэн, хүчирхийлэлд оруулсан, хүчирхийллийн аргаар... гэх мэтээр “хүчирхийлсэн” гэсэн нэр

⁸⁰ Common wealth, Chapter three, convention for the suppression of unlawful seizure of aircraft 1970 (‘hague convention’), p.48. https://www.unodc.org/pdf/crime/terrorism/Commonwealth_Chapter_3.pdf.

⁸¹ Энэхүү судалгааны ажлын хүрээнд дээрх үйлдлүүдийг хооронд нь ялгах үүднээс “use of force” болон “perform an act of violence”-ыг харгалзан хүч хэрэглэх/ хүчирхийлсэн, хүчирхийллийн үйлдэл хийх зэргээр хэрэглэлээ.

⁸² Williams R. 1976. Keywords. Oxford: Oxford Univ. Press.

⁸³ Bufacchi, Vittorio. (2005). Two Concepts of Violence. Political Studies Review. 3. pp 195. 10.1111/j.1478-9299.2005.00023.x.

⁸⁴ Thomas, C. S., and M. J. Kirby. “The Convention for the Suppression of Unlawful Acts against the Safety of Civil Aviation.” The International and Comparative Law Quarterly, vol. 22, no. 1, 1973, p.165, <http://www.jstor.org/stable/758272>. [Сүүлд үзсэн:2022.04.11].

⁸⁵ Legal Committee Working Draft No. 782., Мөн тэндээс дам ишлэв.

⁸⁶ С. Гантулга, Б. Энхболд, *Эрүүгийн эрх зүйн тусгай анги (сурах бичиг)*, Уб, 2018, 36 дахь тал.

⁸⁷ Т. Золбоо, Сургалтын эрүүгийн хууль, Эрүү, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль /шинэчилсэн найруулга/ 2020 он, 88, 91 дэх талаас тус тус үзнэ үү.

⁸⁸ Чингэлтэй дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол, 2022.03.11, дугаар: 2022/ШЦТ/227, https://shuukh.mn/single_case/64666?daterange=2000-01-01%20-%202022-04-17&id=1&court_cat=2&bb=1 [Сүүлд үзсэн:2022.04.18].

томьёог ялгамжтай хэрэглэж хуульчилсан байгаа. Мөн эдгээр нэр томьёог ОУ-ын гэрээнүүдэд ч ялгамжтай заасныг анхаарч конвенцийн дагуу, ЭХ-д холбогдох гэмт хэргүүдийг монгол хэл рүү орчуулж тусгахдаа хүч хэрэглэсэн болон хүчирхийлсэн үйлдлүүдийг ялгамжтай болгох нь зүйтэй.

ЭХ-ийн 27.4 дүгээр зүйлд, нисэх багийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцох гэмт хэргийг шинээр хуульчилсан бөгөөд тухайн зүйлийн 2 дахь хэсэг буюу энэ төрлийн гэмт хэргийн ял хүндрүүлэх шинж нь конвенцид заасан гэмт хэргийн шинжүүдийг хангаж байна гэж хэлж болохоор байна. Үүнд:

“Зорчигч агаарын хөлгийн нислэгийн үед нислэгийн үйл ажиллагаанд саад учруулсан, нисэх багийн гишүүн, бусад зорчигчтой зүй бусаар харилцсаны улмаас хүний эрүүл мэнд, амь нас, бусдын эд хөрөнгөд хохирол учрах нөхцөлийг бүрдүүлсэн, нислэгийн үйл ажиллагаа удаан хугацаагаар саатсан бол дөрвөн зуун тавин нэгжээс хоёр мянга долоон зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас зургаан сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.” гэж тусгажээ. Гэхдээ конвенцид тусгасан, “хүчирхийлсэн үйлдэл”-ийг манай улс ЭХ-д тусгаагүй байна. Харин ЭХ-д, нисэх багийн гишүүн, бусад зорчигчтой “зүй бусаар харилцсан” гэж тусгасан. ЭХ-ийн 27.4.2 дугаар зүйлийн тайлбараас харвал “зорчигч нислэгийн үед нисэх багийн гишүүн, бусад зорчигчид **хүч хэрэглэх**, айлган сүрдүүлэх, маргаан үүсгэх, **хөлгийн эд зүйлийг устгах, гэмтээх**, эсхүл эдгээр үйлдэлд бусдыг өдөөн турхирч, нислэгийн хэвийн үйл ажиллагаа, зорчигчдын амгалан тайван байдлыг алдуулсан, үүнээс шалтгаалан нислэг удаан хугацаагаар саатсаныг ойлгоно”⁸⁹ гэж зарим судлаач тайлбарлажээ. Үүнээс үзвэл хөлгийн эд зүйлийг устгах, гэмтээх үйлдэл нь нислэгийн үед аюул учруулж байгаа эсэх нь тодорхойгүй байна. Иймээс бие даасан гэмт хэрэг болж конвенцид тусгагдсан, нислэгийн үед аюул учруулахуйц байдлаар **“агаарын хөлөгт гэмтэл учруулах”** гэмт хэрэг мөн зүй бусаар харилцсан үйлдэлд орж байна. Ингэснээр “зүй бусаар харилцсан” үйлдлийг маш өргөн агуулгатай болгожээ. Иймээс тус конвенцид заасан гэмт хэргийн төрлүүдийг салгаж, ойлгомжтой зохицуулахын тулд конвенцид заасан хүчирхийлсэн үйлдлийг агуулгын хувьд тодотгон, конвенцид тусгасан байдлыг харгалзан гэмт хэргийн төрлүүдийг нэг бүрчлэн, тусад нь хуульчлах хэрэгтэй гэж үзэж байна.

б) Агаарын хөлгийн аюулгүй байдал

Уг хүчирхийлсэн үйлдэл нь тухайн агаарын хөлгийн аюулгүй байдалд **аюул учруулахаар** байх шинжийг агуулах бөгөөд дээр дурдсан хуулийн заалтаас харвал **...хүний эрүүл мэнд, амь нас, бусдын эд хөрөнгөд хохирол учрах нөхцөлийг бүрдүүлсэн** үйлдлээр уг шинжийг илэрхийлсэн байх боломжтой байна. Үүнээс агаарын хөлгийн аюулгүй байдалд аюул учруулах нөхцөлийг дээр дурдсан шинж хангаж байгаа эсэхийг авч үзье.

“Амь насыг хохироох, бие махбодод хүнд гэмтэл учруулах, эд хөрөнгө, байгаль орчинд ноцтой хохирол учруулах”⁹⁰ гэсэн үг хэллэг нь Монреалийн конвенцийн 1 дүгээр

⁸⁹ С. Гантулга, Б. Энхболд, *Эрүүгийн эрх зүйн тусгай анги (сурах бичиг)*, Уб, 2018, 509 дахь тал.

⁹⁰ Уг нэр томьёог Цөмийн террорист үйлдлийг хориглох тухай 2005 оны конвенцийн 2 дугаар зүйл, 1997 оны Терроризмын зорилгоор бөмбөг хэрэглэхийг хориглох тухай конвенцийн 2 дугаар зүйл, 2005 оны

зүйлд хэрэглэгдсэн томъёоллоос өөр⁹¹ талаар Монреалийн конвенцийг боловсруулах явцад гаргасан ажлын тайланд дурджээ. Монреалийн конвенцийн төслийн үеийн хуралдаанд зарим төлөөлөгчид “Агаарын хөлгийн аюулгүй байдалд аюул учруулаагүй байхад онгоцонд байгаа хүний амь насанд аюул учруулсан үйлдлийг гэмт хэрэг болгож чадаагүй цоорхой бүх конвенцид байгаа юм шиг санагдсан.”⁹² гэж хэлж байв. Түүнчлэн агаарын хөлгийн аюулгүй байдалд зайлшгүй аюул учруулахгүйгээр газарт болон агаарт хохирол учруулах хэрэгсэл болгож агаарын хөлгийг ашигласан үйлдлүүд нь конвенцийг боловсруулж байх тухайн үед аюултай үйлдэлд тооцогддоггүй байсан. Хэдийгээр Монреалийн конвенцид тодорхойлсон гэмт хэргийн зарим шинж нь эдгээр үйлдлийн заримд хамаарах боломжтой ч тухайн үйлдлийн ноцтой байдлыг ойшоогоогүй, эсвэл ийм зорилгоор агаарын хөлгийг ашиглахыг тусгайлан гэмт хэрэгт тооцоогүй.⁹³ Үүний үр дүнд ийм үйлдлийг ОУ-ын хэмжээнд эрүүгийн хариуцлага хүлээлгэхийн тулд Монреалийн конвенцид нэмэлт, өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлага гарсан⁹⁴ зэргээс үзэхэд конвенцид тусгасан агаарын хөлгийн аюулгүй байдалд халдсан үйлдэл нь хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө зэрэгт хохирол учруулсан үйлдлээс өөр гэмт хэрэгт тооцогдохоор байна.

Гэхдээ зарим судлаачийн авч үзсэнээр, хэрвээ эдгээр үйлдэл нь бүхээгт үймээн самуун, сандрал үүсгэж, багийн гишүүдийг үүргээ биелүүлэхэд нь саад учруулахад хүргэх буюу онгоцыг хэв журамд нь буцаан оруулахын тулд нисэх багийнхан агаарын хөлгийн удирдлагын хэсгийн байраа орхиж, улмаар үүргээ гүйцэтгэх чадвар нь буурснаар онгоц доторх дэг журам, сахилга бат, аюулгүй байдал муудаж, нислэг аюулд орох тохиолдлууд тус конвенцийн 1-р зүйлд заасан гэмт хэргийн хүрээнд үйлдэгдэж болно гэж үзжээ.⁹⁵ Гэсэн ч нисэх багийнхан удирдлагын бүхээгээс гараагүй, зорчигчид үймээн самуун гаргаагүй, хүчирхийлсэн үйлдэл гарсан ч зорчигчид мэдээгүй тохиолдлууд нь агаарын хөлгийн аюулгүй байдалд аюул учруулахааргүй байх тул конвенцийн хамрах хүрээнээс гадуур үйлдэл болох юм. Үүний дагуу ЭХ-ийн дээрх заалтын хувьд нислэгийн үйл ажиллагаа саатсан гэдэг нь нисгэгч бүхээгнээс гарсан, эсхүл жолоогоо барихад нь саад болсон гэдгийг илэрхийлж байх боломжтой тул агаарын хөлгийн аюулгүй байдалд халдсан шинжийг хангаж болох юм. Гэвч конвенцид заасан гэмт хэрэг нь агаарын хөлөг ямар хугацаагаар аюулд орсон байхыг тусгаагүй ба “нислэгийн үйл ажиллагаа удаан хугацаагаар саатсан” гэж хугацааг нь нэмэгдүүлж хуульчилснаар зорчигч агаарын хөлөгт зүй бусаар харилцсаны улмаас хэсэг хугацаанд буюу богино хугацаанд нислэгийн үйл ажиллагаа саатсаныг гэмт хэрэг гэж үзэхгүйд хүрч байна. Иймд ЭХ-ийн 27.4.2 дахь хэсгийг өөрчлөн найруулах нь зүйтэй.

Далайн навигацийн аюулгүй байдлын эсрэг хууль бус үйлдлийг хориглох тухай конвенцийн 3bis-р зүйлээс авсан болно.

⁹¹ International Civil Aviation Organization, Special Sub-Committee on The Preparation of One or More Instruments Addressing New and Emerging Threats Montréal, 3–6 July 2007, Report, 44 дүгээр дэд хэсэг, https://www.icao.int/secretariat/legal/LC34_Docs/LC_SC-NET_Report_en.pdf [Сүүлд үзсэн:2022.05.09].

⁹² International Conference on Air Law, Montreal, September 1971, Vol II, Documents CUI Doc No 4, Second Meeting Commission of the Whole, Thursday 9 September 1971, ICAO Doc 9081-LC/170-1.

⁹³ International Civil Aviation Organization, Special Sub-Committee on The Preparation of One or More Instruments Addressing New and Emerging Threats Montréal, 3–6 July 2007, Report, 25 дугаар дэд хэсэг, https://www.icao.int/secretariat/legal/LC34_Docs/LC_SC-NET_Report_en.pdf, [Сүүлд үзсэн:2022.05.09].

⁹⁴ Мөн тэнд 25 дугаар дэд хэсэг.

⁹⁵ Jung, Sung Yool, “A Legal Analysis of Aviation Security under the International Legal Regime”, A thesis submitted to McGill University in partial fulfillment of the requirements of the degree of Master of Laws (LL.M), 2005.

Монгол Улсад агаарын хөлгийн хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль байхгүй бөгөөд агаарын тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын болон техник ашиглалтын болон аюулгүй ажиллагааны талаар цаашид хууль зүйн тодорхой зохицуулалт хэрэгтэй байгаа тухай 2002 оны ЭХ-ийн төмөр зам, усан болон агаарын тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал болон техник ашиглалтын журам зөрчих гэмт хэргийн тайлбарт тусгажээ. Иймээс бусад төстэй хууль тогтоомжуудаас авч үзвэл: Иргэний Нисэхийн Ерөнхий Газраас гаргасан Иргэний нисэхийн дүрмийн 2020 оны өөрчлөлт орсон нэр томъёоны тайлбарт “Нислэгийн аюулгүй байдал” / “Flight safety” гэж иргэний нисэхийн үйл ажиллагааг хүний амь нас, эрүүл мэнд болон эд хөрөнгөд хохирол учруулах эрсдэлгүй гүйцэтгэх нөхцөл болон чадвар⁹⁶ -ыг хэлэхээр тайлбарлажээ. Гэвч энэхүү тодорхойлолтоор Иргэний нисэхийн тухай хуульд “нисэхийн аюулгүй ажиллагаа”⁹⁷ гэдгийг илэрхийлж харин “нисэхийн аюулгүй байдал”⁹⁸ гэдэгт нисэхийг хөндлөнгийн хууль бус үйлдлээс хамгаалахтай холбогдсон цогцолбор арга хэмжээг хэлэхээр заасан байна.

Үнэндээ хуульд заасан аюулгүй байдал гэдэг нь аюулгүй хамгаалалт (air security/ aviation security)-ыг илэрхийлэх ойлголт бөгөөд нисэхийн аюулгүй байдал (air safety/ aviation safety)-аас агуулгын хувьд ялгаатай ойлголт юм. Өөрөөр хэлбэл нисэхийн аюулгүй хамгаалалт нь иргэний нисэхийг хөндлөнгийн хууль бус оролцооноос хамгаалах арга хэмжээ, хүний болон материаллаг нөөцийн цогц бөгөөд хөндлөнгийн хууль бус оролцоо нь терроризм, хорлон сүйтгэх ажиллагаа, амь нас, эд хөрөнгөд заналхийлэх, хуурамч заналхийллийн мэдээлэл дамжуулах, тэсрэх бодисоор халдах гэх мэт байж болно.⁹⁹ Харин нисэхийн аюулгүй байдал нь нислэгийн осол, гэмтлийн тоог бууруулахад чиглэгддэг бөгөөд ингэхдээ сургалт, боловсролын үйл ажиллагаа болон холбогдох хууль тогтоомжуудаар зохицуулахыг эрмэлздэг.¹⁰⁰ Нислэгийн аюулгүй байдалд аюул учруулах гэдэгт, аюулгүй ажиллагааг хангах боломжгүй, эсвэл аюултай нөхцөл байдалд хүргэж болзошгүй аливаа тохиолдлыг хэлдэг. Үүнд гол төлөв үндсэн бүтцийн мэдэгдэхүйц хагарал, хэв гажилт, зэврэлт, эвдрэл, шаталтын шинж тэмдэг, цахилгаан нум, гидравлик шингэн эсвэл түлшний их хэмжээний алдагдал, онцгой байдлын систем эсхүл системийн нийт эвдрэл зэрэг орно.¹⁰¹

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд зааснаар "Замын хөдөлгөөний аюулгүй байдал" гэж замын хөдөлгөөнд оролцогчийг зам тээврийн осол, түүнээс үүдэн гарах хор уршгаас хамгаалсан байдал¹⁰² бөгөөд аюулгүй байдал гэдэг ойлголт нь бүх эрсдэлээс хамгаалах өргөн хүрээний, цогц ойлголт юм. 2002 оны ЭХ-д

⁹⁶ Иргэний нисэхийн дүрмийн нэр томъёоны тайлбар, 2020, <https://mcaa.gov.mn/wp-content/uploads/2018/03/IND-1-2.pdf> [Сүүлд үзсэн: 2022.04.29].

⁹⁷ Иргэний нисэхийн тухай хууль, 1999 он, 3.1.13 дугаар зүйл, <https://legalinfo.mn/mn/detail/298> [Сүүлд үзсэн: 2022.04.18].

⁹⁸ Мөн тэнд, 3.1.17 дугаар зүйл.

⁹⁹ Vijay Kumar Singh, Trends in Safety and Security Regulations of Civil Aviation (Paper Presented at the Seventh International Conference on “Legal Regime of Sea, Antarctica, Air and Space” organized by Indian Society of International Law, New Delhi from 15-17 January 2010) <https://deliverypdf.ssrn.com/delivery.php?ID=508086097113083111073007081070084113049050018065023030127118006097116125127096115089060053008103037029119007123085118031084101061041040055013065092064071071085010069017010086007110110003108006122090007070106122116067092103120027077077072029126094086094&EXT=pdf&INDEX=TRUE> [Сүүлд үзсэн: 2022.05.05].

¹⁰⁰ Мөн тэнд.

¹⁰¹ <https://www.lawinsider.com/dictionary/endanger-flight-safety>, [Сүүлд үзсэн: 2022.05.11].

¹⁰² Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, 3.1.8 дугаар зүйл, <https://legalinfo.mn/mn/detail/11224> [Сүүлд үзсэн: 2022.04.18].

“агаарын хөлгийн аюулгүй байдлыг алдагдуулах” гэсэн нэр томъёог шинээр нэмэх хэрэгтэй¹⁰³ талаар доктор Д. Зүмбэрэллхам дурдсан байдаг. Харин 2015 оны ЭХ-д уг гэмт хэргийг шинээр тусгахдаа үүнийг хэрэгжүүлсэн эсэх нь эргэлзээтэй.

Түүнчлэн ЭХ-ийн 27.7 дугаар зүйлд агаарын хөдөлгөөний аюулгүй байдалд халдах гэмт хэргийг тусгасан ч энэ гэмт хэргийг зөвшөөрөлгүй арилжааны нислэг үйлдэх зэрэг тусгай субъектийн үйлдэх гэмт хэрэг болгон оруулсан байна.

Түүнчлэн ЭХ-ийн нэг бүлгийн гэмт хэрэг болох 27.1-р зүйлийн ..., агаарын хөлгийн хөдөлгөөнд аюултайгаар халдах гэмт хэрэгт ..., **агаарын хөлгийн аюулгүй ажиллагаанд** нөлөөлж хүний эрүүл мэнд, амь насанд **аюул учруулах**, эсхүл бусдын эд хөрөнгөд **ноцтой хохирол учруулах нөхцөлийг бүрдүүлсэн** гэж хохирол, аюул учруулах шинжийг ялгамжтайгаар, мөн агаарын хөлгийн аюулгүй ажиллагаа гэж нэмэлтээр тусгасан байна. ЭХ-ийн 27 дугаар бүлэгт Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэргүүд багтсан бөгөөд энэхүү бүлэгт заасан гэмт хэргүүдийн хамгаалагдах нийтлэг эрх ашиг нь зайлшгүй хөдөлгөөний аюулгүй байдал байдаг. Тэгвэл нэг бүлгийн адилхан хамгаалагдах эрх ашигтай гэмт хэргүүдийн нэг объект нь хүний эрүүл мэнд, амь нас, бусдын эд хөрөнгөд хамтад нь **хохирол учрах** нөхцөлийг бүрдүүлсэн гэж, харин нөгөөд нь хүний эрүүл мэнд, амь насанд **аюул учруулах** нөхцөлийг бүрдүүлж, эд хөрөнгөнд хохирол учруулах хэмээн аюул, хохирол учруулах шинжээр ялгаатай зохицуулсан нь хуулийн дотоод уялдаа холбоог алдагдуулахад хүргэж байна.

Иймд Монгол Улсын ЭХ-д “агаарын хөлгийн аюулгүй байдал”-д аюул учруулах ойлголтыг конвенцид заасан гэмт хэрэг бүрээр нэмж, аюулгүй ажиллагаа, аюулгүй байдал, аюулгүй хамгаалалт зэрэг ойлголтуудыг цэгцлэх, мөн хуулийн дотоод уялдаа холбоог хангах зорилгоор ЭХ-ийн 27.4.2 болон 27.1 дүгээр зүйлд заасан хүний эрүүл мэнд, амь нас, бусдын эд хөрөнгөд хамтад нь **хохирол учирдаг уу, эсхүл хүний эрүүл мэнд, амь насанд аюул учирч, эд хөрөнгөд хохирол учирдаг уу** гэсэн асуултад хариулт өгөх байдлаар хуулийн зохицуулалтын нэг мөр байдлыг сахих нь зүйтэй юм.

в) Конвенцийн дагуу хүлээх үүрэг

Монреалийн конвенцид заасан гэмт хэргүүд нь Гаагийн конвенцтой адилаар гэмт хэргийн ноцтой шинжийг харгалзан хүнд буюу хамгийн дээд хэмжээний ялыг оноох ёстой гэмт хэргүүд байдаг. Өөрөөр хэлбэл хүчирхийлсэн үйлдэл нь тухайн агаарын хөлгийн аюулгүй байдалд нөлөөлөхүйц тийм ноцтой байх ёстой бөгөөд ингэж бусад энгийн, хөнгөн гэмт хэргүүдээс ялгарч байгаа юм. Гэтэл 2015 оны ЭХ-д хамгийн ихдээ 6 сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэж байгаа нь конвенцид заасан гэмт хэргийг бүрэн ухамсарлаж хуульчлаагүй, үүргээ биелүүлээгүй үйлдэл юм.

¹⁰³Д. Зүмбэрэллхам, “Терроризмтой тэмцэх тухай ОУ-ын конвенцууд, тэдгээрт нийцүүлэн үндэсний хууль тогтоомжийг боловсронгуй болгох нь”, *Монгол Улсын Ерөнхийлөгчийн тамгын газар, “ОУ-ын терроризм ба Монгол Улс* онол практикийн бага хурлын эмхэтгэл, Уб, 2004, 118 дахь тал.

2. Нислэг хийх боломжгүй болгох буюу нислэгийн үед аюул учруулахуйц байдлаар, ашиглалтад байгаа агаарын хөлгийг устгасан, эсхүл түүнд гэмтэл учруулах гэмт хэрэг

Агаарын хөлгийг бүрмөсөн эвдсэн, эсхүл түүнд гэмтэл учруулсан үйлдэл нь агаарын хөлөг ашиглагдаж байгаа үед тохиолдохыг заасан бөгөөд ингэснээр энэхүү гэмт хэрэг нь түүнээс өмнө үйлдсэн агаарын хөлгийн эсрэг хорлон сүйтгэх ажиллагаанд хамаарахгүй. Гэмт хэргийн субъект нь зөвхөн агаарын хөлөгт байгаа хүмүүсээр хязгаарлагдахгүй бөгөөд нислэг эхлэхээс өмнө агаарын хөлөгт хорлон сүйтгэх ажиллагаа явуулах болон өөр агаарын хөлгөөс нислэг үйлдэж буй агаарын хөлөг рүү дайрах зэрэг бусад тохиолдлууд орно. Агаарын хөлгийг устгаагүй гэмтэл учруулсан тохиолдолд гэмтэл нь агаарын хөлгийг нисэх чадваргүй болгох, эсвэл нислэгийн үед үүний аюулгүй байдалд аюул учруулах эрсдэлтэй байх ёстой.¹⁰⁴ “Төрийн мэдээлэл” сэтгүүлд нийтлэгдсэн Конвенцийн орчуулгад “бүрмөсөн эвдсэн” гэж томъёолсон байх бөгөөд харин конвенцид ингэж хүч нэмэгдүүлсэн байдлаар эвдэх үйлдлийг тодорхойлоогүй бөгөөд “destroy” гэдэг нь “устгасан” гэсэн утгатай ба энэ нь өөрөө дахин сэргээн засварлагдахааргүй бүр мөсөн эвдсэн гэсэн агуулгыг илэрхийлдэг тул цаашид “устгах” гэдэг үгийг хэрэглэв.

Уг гэмт хэргийг ЭХ-ийн 27.1 дүгээр зүйлд “Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүн, усан онгоц, агаарын хөлгийн хөдөлгөөнд аюултайгаар халдах” гэмт хэрэг болгон хуульчилсан. Уг заалтыг дор дэлгэрүүлэн авч үзье.

27.1.1. “Зөөх, тээвэрлэх зориулалттай хэрэгсэл, тэдгээрийн эд ангийг устгасан, гэмтээсэн, ашиглах боломжгүй болгосон, хэвийн үйл ажиллагаанд саад учруулсан, ... үүнтэй төстэй аюултай үйлдэл хийх замаар төмөр замын хөдлөх бүрэлдэхүүн, усан онгоц, агаарын хөлгийн аюулгүй ажиллагаанд нөлөөлж хүний эрүүл мэнд, амь насанд аюул учруулах, эсхүл бусдын эд хөрөнгөд ноцтой хохирол учруулах нөхцөлийг бүрдүүлсэн бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.”

Үүнд заасан гэмт хэргүүдийг харвал агаарын хөлгийг¹⁰⁵ устгасан, агаарын хөлгийг гэмтээсэн, агаарын хөлгийн хэвийн үйл ажиллагаанд саад учруулсан зэрэг гурван тусдаа үйлдлийг багтаасан. Гэтэл энэхүү үйлдлийг тайлбарласан судлаачдын тайлбараас харвал зөөх, тээвэрлэх зориулалттай хэрэгсэл, тэдгээрийн эд ангийг устгасан, гэмтээсэн, ашиглах боломжгүй болгосон, хэвийн үйл ажиллагаанд саад учруулсан гэж эдгээр хэрэгсэл, тэдгээрийн эд ангийг зориулалтын дагуу ашиглах, хэвийн ажиллах боломжгүй, өөрөөр хэлбэл, сэргээн засварлагдахааргүй эсхүл сэргээн засварласны дараагаар зориулалтын дагуу ашиглах, хэвийн ажиллахаар болгохыг ойлгоно¹⁰⁶ гэжээ. Өөрөөр хэлбэл хуулийн энэхүү тайлбар нь устгах, гэмтээх болон

¹⁰⁴ Common wealth, Chapter Four, Convention For The Suppression Of Unlawful Acts Against The Safety Of Civil Aviation 1971 (‘Montreal Convention’), p.77, https://www.unodc.org/pdf/crime/terrorism/Commonwealth_Chapter_4.pdf, [Сүүлд үзсэн:2022.04.19].

¹⁰⁵ Зөөх, тээвэрлэх зориулалттай хэрэгсэлд агаарын хөлөг орж байгаа бөгөөд одоогийн авч үзэж буй конвенцид агаарын хөлөг холбогдох учир зөөх, тээвэрлэх зориулалттай хэрэгслийн оронд агаарын хөлөг гэж хэрэглэлээ.

¹⁰⁶ С. Гантулга, Б. Энхболд, *Эрүүгийн эрх зүйн тусгай анги* (сурах бичиг), УБ, 2018, 503 дахь тал.

хэвийн үйл ажиллагаанд саад учруулсан үйлдлүүдийг ялгаж тайлбарлаагүй бөгөөд эдгээр гурван үйлдлийг нэгтгэж нэг утга санааг илэрхийлж буйгаар тайлбарласан байна. Ингэснээр агаарын хөлгийн хэвийн үйл ажиллагаанд саад учруулах үйлдэл нь тодорхойгүй байдлаар үлдсэн. Мөн уг гэмт хэргийг 2002 оны ЭХ-ийн 219 дугаар зүйлд “Тээврийн хэрэгсэл, зам харилцааны төхөөрөмжийг эвдэх, гэмтээх” гэж заасан байсан бөгөөд 2015 оны хуулиар уг гэмт хэргийг зөвхөн хэлбэрийн шинжтэй болгон өөрчилсөн¹⁰⁷, үйлдлийн агуулгыг нь өөрчлөөгүй талаар хуулийн төсөл боловсруулагчид дурдсан байна. Иймээс ЭХ-ийн 27.1 дүгээр зүйлийн дээрх хэсэг нь устгах, гэмтээх үйлдлийг л тусгасан агуулгатай буюу хуульд тусгахдаа устгасан, гэмтээсэн, үүнээс гадна **агаарын хөлгийг устгах, гэмтээх замаар** хэвийн үйл ажиллагаанд саад учруулсан гэсэн агуулгаар хэмээн ойлгогдож байна.

Гэвч ЭХ-д “агаарын хөлгийн хэвийн үйл ажиллагаанд саад учруулсан” гэж өмнөх шинжтэйгээ хамааралгүй байхаар тусдаа үйлдлээр тусгасан нь ЭХ-ийн 27.4.2-т заасан “... нислэгийн үйл ажиллагаанд саад учруулсан” үйлдлээс мөн хуулийн 27.6.1 дэх хэсэгт “... нислэгийн хөдөлгөөнд саад учруулсан” гэсэн үйлдлээс ялгахад бэрхшээл учруулж байна. Ингэснээр агаарын хөлгийн хэвийн үйл ажиллагаа, нислэгийн үйл ажиллагаа, нислэгийн хөдөлгөөн зэрэг өөр өөр нэр томъёо гарч ирж, эдгээрийг агаарын хөлгийн аюулгүй байдалтай уялдуулах шаардлага тулгарч байна. Өмнөх хэсэгт дурдсанчлан, ЭХ-ийн 27.1-р зүйлд заасан агаарын хөлгийн аюулгүй ажиллагаа нь агаарын хөлгийн аюулгүй байдал болохыг дурдах нь зүйтэй юм.

ЭХ-д агаарын хөлгийг устгасан, гэмтээсэн байх шинжийг тусгасан байх боловч агаарын хөлгийн “нислэгийн үе”-д болон “ашиглалтад байх” зэрэг шинжийг тухайлан хуульчлаагүй байна.

Энэхүү гэмт хэрэгтэй холбоотой бусад орны хууль тогтоомжийг судалж үзэв. Герман улс конвенцид заасан уг гэмт хэргийг ЭХ-даа Нислэгийн болон далайн замын хөдөлгөөнд халдах гэмт хэрэг болгон хуульчилсан ба нислэг үйлдэж буй агаарын хөлөг, хөлөг онгоц, эсвэл үүнд байгаа ачааг устгах, гэмтээхийн тулд галт зэвсэг ашигласан, эсхүл дэлбэрэлт бий болгосон, эсхүл гал гаргасан бол таван жилээс доошгүй хугацаагаар хорих ял шийтгэнэ.¹⁰⁸ гэж хуульчилжээ. Энэтхэг улс нь Монреалийн конвенцийн дагуу Иргэний нисэхийн аюулгүй байдлын эсрэг хууль бус үйлдлийг хориглох тухай хууль¹⁰⁹ гаргасан бөгөөд үүнд “Нислэгийн үед агаарын хөлөгт хүчирхийлэл үйлдсэн гэмт хэрэг” хэмээн зааж конвенцид заасан гэмт хэргүүдийг бүгдийг нь утга агуулгын хувьд ижилтгэн хуульчилсан ба бүх насаар нь хорих ял шийтгэхээр байна. Түүнчлэн Шинэ Зеланд улс Нисэхийн гэмт хэргийн тухай хуультай¹¹⁰ бөгөөд тухайн хуульд мөн л конвенцид заасан гэмт хэргүүдийг утга найруулгын хувьд адил байхаар зохицуулсан бөгөөд 14 жилээс хэтрүүлэхгүй ял оногдуулахаар заасан байна. Харин Монгол Улс уг гэмт хэрэгт конвенцид заасан “нислэгийн үе”-д болон “ашиглалтад байх” шинжүүдийг хуульчлаагүй бөгөөд үүргээ умартан торгох, эсхүл

¹⁰⁷ ХЗДХЯ, *Эрүүгийн хуулийн шинэчлэсэн найруулга* (Сурагч багш нарт зориулсан гарын авлага), Уб, 2017, 266 дахь тал.

¹⁰⁸ German Criminal Code in the version published on 13 November 1998 (Federal Law Gazette I, p. 3322), as last amended by Article 2 of the Act of 19 June 2019 (Federal Law Gazette I, p. 844), Section 316.c, https://www.gesetze-im-internet.de/englisch_stgb/englisch_stgb.html, [Сүүлд үзсэн: 2022.04.15].

¹⁰⁹ The Suppression of Unlawful Acts Against Safety Of Civil Aviation Act, 1982, Act No. 66 Of 1982, Chapter 2, Article 3, <https://legislative.gov.in/sites/default/files/A1982-66.pdf>, [Сүүлд үзсэн: 2022.05.25].

¹¹⁰ Aviation Crimes Act 1972, Public Act 1972 No 137, Version as at 28 October 2021, <https://www.legislation.govt.nz/act/public/1972/0137/latest/whole.html#DLM409174>, [Сүүлд үзсэн: 2022.04.01].

зорчих эрхийг хязгаарлах, эсхүл хамгийн багадаа 1 жилийн хорих ял оногдуулахаар байгаа нь гэмт хэргийн нийгэмд учруулах аюул заналыг үл ухаарч буй хэрэг юм.

3. Ашиглалтад байгаа агаарын хөлгийг устгах, эсхүл нислэг үйлдэх боломжгүй болохуйц гэмтэл учруулах, эсхүл нислэгийн үед агаарын хөлгийн аюулгүй байдалд аюул учруулахуйц гэмтээх төхөөрөмж, бодисыг ямар нэг аргаар ашиглалтад байгаа агаарын хөлөгт байрлуулах буюу байрлуулахад чиглэсэн үйл ажиллагаа явуулах гэмт хэрэг

Ашиглалтад байгаа агаарын хөлөгт ямар нэг аргаар төхөөрөмж, бодисыг байрлуулах буюу байрлуулахад чиглэсэн үйл ажиллагаа явуулсан байх ёстой бөгөөд энэхүү төхөөрөмж эсхүл бодис нь:

- 1) Ашиглалтад байгаа агаарын хөлгийг устгахуйц, эсхүл
- 2) Нислэг үйлдэх боломжгүй болохуйц гэмтэл учруулахуйц, эсхүл
- 3) Нислэгийн үед агаарын хөлгийн аюулгүй байдалд аюул учруулахуйц гэмтэл учруулахаар байх ёстой.

Энэ заалт нь агаарын хөлөгт тэсрэх бөмбөг байрлуулсан тохиолдлыг хамрах зорилготой бөгөөд “Төхөөрөмж, эсвэл бодис” гэдэг нь ихэнх төрлийн тэсрэх бөмбөгийг багтаасан өргөн агуулгатай.¹¹¹ Тэсрэх бөмбөгийг онгоцонд оруулах эсвэл гадна талд нь бэхлэх замаар гэмт хэрэг үйлдэгдэх боломжтой.¹¹² Уг заалт агаарын хөлгийг “ашиглалтад байх”-ыг шаарддаг. Гэхдээ энэ нь тухайн үйлдлийг хийх үед ашиглалтад байх ёстой гэсэн үг биш харин ашиглалтын хугацаа эхлэхээс өмнө үйлдлийг хийх нь хангалттай бөгөөд ашиглалтад байх аль ч хугацаанд тэсрэх бөмбөг тэнд үлдэх нөхцөлийг ойлгоно.¹¹³

Монгол Улсын ЭХ-д дээрх гэмт хэргийг тусгайлан зохицуулаагүй. Гэхдээ ЭХ-ийн 27.1 дүгээр зүйлд “Зөөх, тээвэрлэх зориулалттай хэрэгсэл, тэдгээрийн эд ангийг устгасан... буруу дохио, анхааруулга өгсөн, **үүнтэй төстэй аюултай үйлдэл** хийх замаар ... агаарын хөлгийн аюулгүй ажиллагаанд нөлөөлж хүний эрүүл мэнд, амь насанд аюул учруулах, эсхүл бусдын эд хөрөнгөд ноцтой хохирол учруулах нөхцөлийг бүрдүүлсэн...” гэсэн нь агаарын хөлөгт халдсан дээрх үйлдлүүдтэй төстэй аюултай үйлдлүүдэд хамааруулсан байж болох юм. Гэсэн ч энэ нь хэт ерөнхий бөгөөд конвенцид заасантай адилаар тодорхой, нарийвчилсан заалт биш юм.

4. Агаарын навигацийн тоног төхөөрөмжийг устгасан, гэмтээсэн, эсхүл түүний ашиглалтад саад учруулсан бөгөөд ийм аливаа үйл ажиллагаа нь агаарын хөлгийн нислэгийн аюулгүй байдалд аюул учруулж болзошгүй гэмт хэрэг

Конвенцийн 4.5 дугаар зүйлд заасанчлан агаарын навигацийн тоног төхөөрөмж нь ОУ-ын агаарын навигацид хэрэглэгддэг байх ёстой. Нислэгийн явцад яг тодорхой агаарын хөлгийн аюулгүй байдалд аюул учруулах шаардлагагүй, харин нислэгийн үед

¹¹¹ Common wealth, Chapter Four, Convention For The Suppression Of Unlawful Acts Against The Safety Of Civil Aviation 1971 ('Montreal Convention'), p.78, https://www.unodc.org/pdf/crime/terrorism/Commonwealth_Chapter_4.pdf, [Сүүлд үзсэн: 2022.04.09].

¹¹² Мөн тэнд.

¹¹³ Мөн тэнд.

ямарваа нэгэн агаарын хөлгийн аюулгүй байдалд ерөнхий аюул учруулж байгаа шинж нь хангалттай юм.¹¹⁴ Энэ гэмт хэрэгт дараах шинжүүд байна. Үүнд:

- 1) агаарын навигацийн тоног төхөөрөмжийг устгасан,
- 2) агаарын навигацийн тоног төхөөрөмжийг гэмтээсэн,
- 3) агаарын навигацийн тоног төхөөрөмжийн ашиглалтад саад учруулсан байх бөгөөд эдгээр нь бүгд агаарын хөлгийн нислэгийн аюулгүй байдалд аюул учруулж болзошгүй байх ёстой.

б) Монгол улсын ЭХ-ийн нийцэл

Уг гэмт хэргийг ЭХ-ийн 27.6 дугаар зүйлд “Агаарын навигацийн тоног төхөөрөмжийг устгаж гэмтээх, нислэгийн хөдөлгөөнд саад учруулах” гэмт хэрэг болгон хуульчилсан байна. Үүнд:

1. Агаарын навигацийн тоног төхөөрөмжийг устгаж, гэмтээж нислэгийн хөдөлгөөнд саад учруулсан бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
2. Энэ гэмт хэргийн улмаас хүний эрүүл мэндэд хүнд хохирол учирсан, хүний амь нас хохирсон; их хэмжээний хохирол учирсан бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ гэжээ.

27.6.1 дэх заалтад агаарын навигац нь аль улсынх байх зэргээр нарийвчлан тодорхойлоогүй тул конвенцид заасан ОУ-ын агаарын навигацийн тоног, төхөөрөмж хэрэглэгдэнэ. Гэхдээ конвенцид заасан агаарын хөлгийг устгасан, гэмтээсэн байх шинжийг дангаар нь гэмт хэрэг болгоогүй, харин устгах, гэмтээх замаар “нислэгийн хөдөлгөөнд саад учруулсан” үйлдлийг гэмт хэрэгт тооцжээ. Өөрөөр хэлбэл конвенцид тусгасан агаарын навигацийн тоног төхөөрөмжийн ашиглалтад саад учруулсан тусдаа зохицуулалттай гэмт хэрэг болон устгасан, гэмтээсэн үйлдлийг тусад нь хуульчлаагүй байна. Хэрэв нислэгийн хөдөлгөөнд саад учруулсан гэдгээр “нислэгийн хөдөлгөөнд саад учруулсан” шинжийг хангаж байна гэж үзвэл устгах, гэмтээх зэргээр тухайн үйлдлийн аргыг тодорхойлсон байх тул устгасан, гэмтээснээс бусад байдлаар навигацийн тоног, төхөөрөмжийн ашиглалтад саад учруулсан үйлдлийг тооцохгүй байх эрсдэл үүсэж байна.

Харин гэмт хэргийн нэршлийн хувьд “27.6 дугаар зүйл. Агаарын навигацийн тоног төхөөрөмжийг **устгаж гэмтээх**, нислэгийн хөдөлгөөнд саад учруулах” буюу устгаж гэмтээсэн мөн нислэгийн хөдөлгөөнд саад учруулсан байх гэж тусдаа үйлдлээр илэрхийлсэн байгаа ч “устгаж гэмтээх” гэж гэмтээсэн үйлдлийг тодотгосон байдлаар устгах гэдэг үгийг ашигласнаар зөвхөн конвенцид заасан агаарын навигацийн тоног төхөөрөмжийг гэмтээсэн үйлдлийг тусгасан гэж ойлгогдохоор байна. Харин конвенцийн

¹¹⁴ Common wealth, Chapter Four, Convention For The Suppression Of Unlawful Acts Against The Safety Of Civil Aviation 1971 ('Montreal Convention'), p.78.
https://www.unodc.org/pdf/crime/terrorism/Commonwealth_Chapter_4.pdf, [Сүүлд үзсэн: 2022.04.09].

дагуу агаарын навигацийн тоног төхөөрөмжийг устгасан, гэмтээсэн нь мөн ялгаатай үйлдлүүд юм.

Мөн агаарын хөлгийн аюулгүй байдалд аюул учруулж болзошгүй байх талаар хуульд үгчлэн тусгаагүй бөгөөд хэрэв нислэгийн хөдөлгөөнд саад учруулсан үйлдлийг уг шинж мөн гэж үзсэн ч агаарын навигацийн тоног төхөөрөмжийн ашиглалтад саад учруулсан байх шинжийг хуульчлаагүй байхаар байна. Хуулийн заалтын хүндрүүлэх бүрэлдэхүүнд энэ гэмт хэргийн улмаас хүний эрүүл мэндэд хүнд хохирол учирсан, хүний амь нас хохирсон; их хэмжээний хохирол учирсан зэргийг тусгасан хэдий ч конвенцид заасан гэмт хэрэг нь агаарын хөлгийн аюулгүй байдалд аюул учруулж болзошгүй нөхцөлийг бий болгосон төдийд л гэмт хэрэгт тооцогдож байгааг анхаарах нь зүйтэй. Өөрөөр хэлбэл заавал хүн нас барсан... зэрэг тохиолдол байх шаардлагагүй юм.

Гэмт хэргийн хариуцлагын хувьд ЭХ-ийн 27.6.1-д заасанчлан, багадаа таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр байгаа нь ЭХ-ийн дагуу хөнгөн гэмт хэрэгт тооцогдож байх тул конвенцид зааснаар хүнд гэмт хэрэгт тооцох үүргээ биелүүлээгүй гэж үзэж байна.

5. Худал гэдгийг нь мэдсээр байж мэдээлэл өгснөөр нислэг үйлдэж буй агаарын хөлгийн аюулгүй байдалд аюул учруулах гэмт хэрэг

ЭХ-д уг гэмт хэргийг тусдаа зүйл заалт болгон тусгаагүй, харин 27.1.1-р зүйлд ...буруу дохио, анхааруулга өгсөн, үүнтэй төстэй аюултай үйлдэл хийх замаар...агаарын хөлгийн аюулгүй ажиллагаанд нөлөөлж хүний эрүүл мэнд, амь насанд аюул учруулах, эсхүл бусдын эд хөрөнгөд ноцтой хохирол учруулах нөхцөлийг бүрдүүлсэн бол гэмт хэрэгт тооцохоор заасан. Агаарын хөлгийн аюулгүй ажиллагаа нь агаарын хөлгийн аюулгүй байдал болох талаар өмнө нь тайлбарлаж байсан. Үүнээс гадна мэдээллийг дохио, анхааруулга болгож өөрчилсөн нь гэмт хэргийн агуулгын хувьд ноцтой гажихгүй гэж үзэж байна. Иймд конвенцид заасан гэмт хэргийг тусгасан байна гэж үзэв.

Гишүүн орнуудын тухай Монреалийн конвенцийн үүрэг нь Гаагийн конвенцийн үүрэг хариуцлагатай маш төстэй боловч тэдгээрийг хэрэглэх хүрээндээ өргөтгөл хийсэн байдаг. Конвенцийн 3 дугаар зүйлийн дагуу хэлэлцэн тохирогч улс бүр энэхүү конвенцийн 1 дүгээр зүйлд дурдсан гэмт хэрэгт хүнд ял оногдуулах үүрэг хүлээдэг.

Монгол Улсын хувьд дээрх гэмт хэрэгт, ЭХ-ийн 27.1.1-д заасны дагуу таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр байгаа нь мөн л ялын хөнгөн хэлбэрт тооцогдож байна.

6. Гэмт хэргийн субъект

Конвенцид заасан гэмт хэргүүд нь нислэг үйлдэж буй агаарын хөлөгт байгаа хүний эсрэг чиглэсэн байх боловч Гаагийн конвенцоос ялгаатай нь гэмт этгээд заавал

агаарын хөлөг дотор байх албагүй юм.¹¹⁵ Өөрөөр хэлбэл конвенцид заасныг хатуу үгчилж тайлбарлавал хүч хэрэглэсэн хүн, эсхүл хүмүүс онгоцны гадна байж болно гэсэн үг юм.¹¹⁶ Иймээс уг заалт нь нислэг үйлдэж буй агаарын хөлгийн гаднаас агаарын хөлгийн дотор байгаа хүмүүсийн эсрэг пуужин харвах, нислэгийн өмнө онгоцонд бөмбөг байрлуулах зэрэг үйлдэлд мөн хамаарна.

Харин ЭХ-д “Нислэг үйлдэж буй агаарын хөлгийн бүхээгт яваа хүний эсрэг хүчирхийлсэн бөгөөд энэ нь агаарын тухайн хөлгийн аюулгүй байдалд аюул учруулах” гэмт хэргийг тусгахдаа субъектийн хувьд зөвхөн зорчигч байхаар хязгаарласан нь конвенцид заасан нисэх онгоцны гаднаас халдах бусад тохиолдлыг хамруулалгүй орхигдуулсан байна. Хэдийгээр 27.4.1-р зүйлд заасан гэмт хэргийн субъект нь заавал зорчигч байх талаар хуульд тусгаагүй боловч зарим судлаач нийтлэг субъект¹¹⁷ гэж, мөн зарим судлаач зорчигчийг заасан байна¹¹⁸ хэмээн саналын зөрүүтэй авч үзжээ. Хэдий 27.4.1-р зүйлийн үндсэн гэмт хэргийн субъектийг нийтлэг субъект гэж үзсэн ч уг зүйлд нислэгийн баг, зорчигчдын эсрэг хүч хэрэглэсэн үйлдэл хамаарахгүй. Иймээс ЭХ-д Монреалийн конвенцийн 1 (а)-д заасан гэмт хэргийн шинжүүдийг бүрнээ нийцүүлэх шаардлагатай.

7. Санаатай болон хууль бусаар гэмт хэрэг үйлдэх нь

Гэмт хэргийн тохиолдол тус бүрд эдгээр үйлдэл нь хууль бус бөгөөд санаатай үйлдэгдсэн шинжтэй байх ёстой. Харин ЭХ-ийн 2.3.1 дүгээр зүйлд заасны дагуу гэм буруу нь санаатай, эсхүл болгоомжгүй хэлбэртэй байдаг. Гэсэн ч ЭХ-д санаатай үйлдсэн бүх гэмт хэргийг санаатай гэж үгчлэн тодотгоогүй бөгөөд болгоомжгүй үйлдсэн гэж ялгаж тусгаагүй бол санаатай үйлдсэн гэж үзэх боломжтой байх тул тус ОУ-ын гэрээнд заасан гэмт хэргийн санаатай үйлдэгдсэн байх шинжийг дотоодын хуульд тусгасан гэж үзэж болох юм. ЭХ-д тусгагдсан гэдэг үүднээс авч үзвэл тус конвенцид заасан үйлдлийн хууль бус байх шинжийг зарим талаар хангасан гэж үзэж байна.

8. Конвенцийн дагуу хүлээх үүрэг

Конвенцийн дагуу гэмт хэрэг бүрт хүнд ял оногдуулах ёстой бөгөөд гэмт хэрэг бүр дээр задалж авч үзсэн.

- Хамтран оролцогчдод хариуцлага хүлээлгэх

Энэ асуудлыг тус конвенцийн 1.2 дугаар зүйлд дараах байдлаар зохицуулсан. Үүнд: Хэрэв аливаа этгээд дараах үйлдлийг мөн үйлдсэн, гүйцэтгэсэн бол түүнийг бас гэмт хэрэг үйлдсэн гэж үзнэ:

- (а) энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэргийг үйлдэхээр завдсан;

¹¹⁵ Common wealth, Chapter Four, Convention For The Suppression Of Unlawful Acts Against The Safety Of Civil Aviation 1971 ('Montreal Convention'), p.77, https://www.unodc.org/pdf/crime/terrorism/Commonwealth_Chapter_4.pdf, [Сүүлд үзсэн:2022.04.15].

¹¹⁶ Thomas, C. S., and M. J. Kirby. "The Convention for the Suppression of Unlawful Acts against the Safety of Civil Aviation." *The International and Comparative Law Quarterly*, vol. 22, no. 1, 1973, p.165, <http://www.jstor.org/stable/758272>. [Сүүлд үзсэн:2022.04.15].

¹¹⁷ Т. Золбоо, Сургалтын эрүүгийн хууль, Эрүү, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль /шинэчилсэн найруулга/ УБ, 2020 он, 207 дахь талаас үзнэ үү.

¹¹⁸ С. Гантулга, Б. Энхболд, *Эрүүгийн эрх зүйн тусгай анги (сурах бичиг)*, УБ, 2018, 508 дахь тал.

(b) ийм гэмт хэрэг үйлдсэн буюу үйлдэхийг завдаж байгаа этгээдийн үйлдэлд хамтран оролцсон.

В. Дүгнэлт

ЭХ-д конвенцийн 1(а)-д заасан гэмт хэргийг тусгасан байна. Гэвч энэхүү гэмт хэргийн шинж болох “хүчирхийлсэн” үйлдлийг “зүй бусаар харилцсан” гэж өөрөөр тусгасан нь үүнтэй холбоотой судлаачдын тайлбараас үзэхэд тусдаа хоёр гэмт хэргийн агуулгыг нэгтгэж, нэлээд өргөн агуулгатай болгосон байна.

Конвенцид тусгасан гэмт хэргийн “агаарын хөлгийн аюулгүй байдалд халдсан” байх шинжийг “хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө зэрэгт хохирол учруулсан” үйлдлээр илэрхийлсэн нь конвенцид заасан гэмт хэргийн агуулгаас зөрүүтэй болгожээ. Мөн ЭХ-ийн 27.4.2 дахь заалтын “нислэгийн үйл ажиллагаа удаан хугацаагаар саатсан” гэж хугацааг нь нэмэгдүүлж хуульчилснаар зорчигч агаарын хөлөгт зүй бусаар харилцсаны улмаас хэсэг хугацаанд буюу богино хугацаанд нислэгийн үйл ажиллагаа саатсаныг гэмт хэрэг гэж үзэхгүйд хүрч байна.

ЭХ-ийн нэг бүлэгт заасан гэмт хэргүүдийг тодорхойлсон заалтууд болох 27.4.2 болон 27.1.1 -д хүний эрүүл мэнд, амь насанд хохирол учрах ба аюул учрах хэмээн ялгаатай байдлаар томъёолсон байна. Ингэснээр хуулийн үг хэллэгийн нэг мөр байдлыг алдагдуулсан гэж үзлээ. Түүнчлэн ялын хувьд, 2015 оны ЭХ-д энэ гэмт хэрэгт хамгийн ихдээ 6 сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэж байгаа нь конвенцид заасан гэмт хэргийн зохицуулалтыг бүрэн тусгаж хуульчлаагүй буюу ОУ-ын гэрээний үүргээ биелүүлээгүй явдал юм.

Нислэг хийх боломжгүй болгох буюу нислэгийн үед аюул учруулахуйц байдлаар ашиглалтад байгаа агаарын хөлгийг устгасан, эсхүл түүнд гэмтэл учруулсан байх гэмт хэргийг ЭХ-д мөн тусгасан байна. Судлаачид ЭХ-ийн 27.1 дүгээр зүйлийг “устгах, гэмтээх замаар хэвийн үйл ажиллагаанд саад учруулсан” гэж нэг утга санааг илэрхийлж байгаагаар тайлбарласан байх боловч ЭХ-д “Агаарын хөлгийг устгасан, гэмтээсэн, хэвийн үйл ажиллагаанд саад учруулсан” гэж гурван тусдаа үйлдэл байхаар тусгажээ. Хууль тогтоогчид энэхүү заалтыг судлаачдын тайлбарласан агуулгын хүрээнд хэлэлцсэн байх боломжтой ч ЭХ-д өөр агуулгаар хуульчлагдсан байна. Ингэж ЭХ-д “агаарын хөлгийн хэвийн үйл ажиллагаанд саад учруулсан” гэх тусдаа үйлдлийг тусгаснаар ЭХ-ийн 27.4.2 болон 27.6.1-т тус тус заасан “... нислэгийн үйл ажиллагаанд саад учруулсан,” болон “... нислэгийн хөдөлгөөнд саад учруулсан” үйлдлээс ялгахад бэрхшээл учруулж байгаа юм. Мөн ЭХ-д конвенцид заасан “нислэгийн үе”-д болон “ашиглалтад байх” агаарын хөлөг гэсэн шинжийг хуульчлаагүй байна.

Зарим улсад конвенцийн 1(b)-д заасан энэхүү гэмт хэрэгт бүх насаар нь хорих зэрэг хүнд ял оноож байхад Монгол Улс уг гэмт хэрэгт конвенцид зааснаас өөрөөр буюу торгох, эсхүл зорчих эрхийг хязгаарлах, эсхүл хамгийн багадаа 1 жилийн хорих ял оногдуулж байгаа нь гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанарыг үл хайхарч буй хэрэг юм.

Ашиглалтад байгаа агаарын хөлөгт ямар нэг аргаар төхөөрөмж, бодисыг байрлуулах буюу байрлуулахад чиглэсэн үйл ажиллагаа явуулсан байх гэмт хэргийн төрлийг ЭХ-д тусгаагүй байна.

Конвенцийн 1(d)-д заасан гэмт хэргийн хувьд ЭХ-ийн 27.6.1 дүгээр зүйлд агаарын навигацийн тоног төхөөрөмжийг устгах, гэмтээх замаар “нислэгийн хөдөлгөөнд саад учруулсан” үйлдлийг гэмт хэрэгт тооцжээ. Ингэснээр:

1. Конвенцид заасан агаарын навигацийн тоног төхөөрөмжийг устгасан, гэмтээсэн байх шинжийг дангаар нь гэмт хэргийн төрөл болгоогүй үр дагавар;
2. “Нислэгийн хөдөлгөөнд саад учруулсан” үйлдэл нь конвенцид заасан тухайн тоног төхөөрөмжийн “ашиглалтад саад учруулсан” үйлдэл мөн гэж үзвэл “устгаж, гэмтээж нислэгийн хөдөлгөөнд саад учруулсан” гэж тодотгосон тул устгаж, гэмтээлгүйгээр ашиглалтад саад учруулсан үйлдлүүдийг багтаагаагүй хязгаарлалтыг тус тус үүсгэж байгаа юм.

Мөн хуулийн заалтын нэршил болон гэмт хэргийн тодорхойлолт агуулгын зөрөөтэй байгааг дурдах нь зүйтэй. Гэмт хэргийн хариуцлагын тухайд ЭХ-ийн 27.6.1-д заасан нь хөнгөн гэмт хэрэгт тооцогдож байх тул конвенцид зааснаар хүнд гэмт хэрэгт тооцох үүргээ биелүүлээгүй байна.

Харин конвенцийн 1(e) -д заасан гэмт хэргийн төрлийг бүрэн тусгажээ. Гэвч ялын хэмжээ нь хангалтгүй байна. Тухайн төрлийн гэмт хэргийг ЭХ-д тусдаа заалт болгож тусгалгүй, тус хуулийн 27.1.1-д “...буруу дохио, анхааруулга өгсөн, үүнтэй төстэй аюултай үйлдэл хийх замаар...агаарын хөлгийн аюулгүй ажиллагаанд нөлөөлж хүний эрүүл мэнд, амь насанд аюул учруулах, эсхүл бусдын эд хөрөнгөд ноцтой хохирол учруулах нөхцөлийг бүрдүүлсэн” бол гэмт хэрэгт тооцохоор заасан байна. Тус конвенцид заасан гэмт хэргийн төрлүүдийн санаатай үйлдэгдсэн байх шинжийг ЭХ-д тусгажээ.

Харин тус конвенцийн орчуулгад, тусдаа өөр нэр томъёонууд болох “use of violence” ба “use of force” гэсэн нэр томъёог нэгэн адил “хүч хэрэглэсэн” гэж орчуулсан байна. Мөн “Destroy” буюу “устгах” гэж хуульд хэрэглэж тогтсон үгийг конвенцийн орчуулгад “бүр мөсөн эвдсэн” гэж орчуулсныг өөрчлөх нь зүйтэй. Үүнээс гадна иргэний нисэхийн шинэчлэгдсэн дүрэмд “нислэгийн аюулгүй байдал” гэж зөвөөр тодорхойлсон ч холбогдох хуульд өөрчлөлт оруулах замаар нэр томъёог жигдлээгүй, мөн “нисэхийн аюулгүй байдал”, “аюулгүй хамгаалалт” гэсэн ойлголтуудыг хооронд нь хольж, буруу хэрэглэсэн байна.

Эдгээрээс үзэхэд, ЭХ-д конвенцид заасан гэмт хэрэгтэй холбоотой хэм хэмжээг оновчгүй тусгаснаас гадна оногдуулах ялын хэмжээ нь ч мөн адил тохирохгүй буюу конвенцийн дагуу хүнд гэмт хэрэгт тооцсон гэмт хэрэгт ЭХ-аар хөнгөн гэмт хэрэгт тооцогдох ял оногдуулсан, зарим гэмт хэрэгт бүр хорих ял ч оноогоогүй байна. Эдгээр гэмт хэрэг нь террорист үйлдлүүдийн нэг хэлбэр учраас конвенцид зааснаар гэмт хэргийн төрлийг тодорхойлж, ялын хэмжээг чангатгах нь зүйтэй. Ингэснээр холбогдох гэмт хэргүүдийг үйлдэхээр завдсан болон хамтран оролцсон этгээдүүдэд ч мөн адил хариуцлага тооцож, ОУ-ын гэрээ ба ЭХ-ийн нийцлийг хангах боломж бүрдэнэ.

**ТАВДУГААР БҮЛЭГ. ИРГЭНИЙ НИСЭХИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЭСРЭГ ХУУЛЬ
БУС ҮЙЛДЛИЙГ ХОРИГЛОХ ТУХАЙ МОНРЕАЛЬ ХОТНОО 1971 ОНЫ 9 ДҮГЭЭР
САРЫН 23-НЫ ӨДӨР ҮЙЛДСЭН КОНВЕНЦИЙН ОУ-ЫН ИРГЭНИЙ НИСЭХЭД
ҮЙЛЧИЛДЭГ НИСЭХ БУУДАЛ ДАХЬ ХҮЧИРХИЙЛСЭН ХУУЛЬ БУС ҮЙЛДЛИЙГ
ХОРИГЛОХ ТУХАЙ НЭМЭЛТ ПРОТОКОЛ¹¹⁹**

Уг протокол нь 1988 оны 02 дугаар сарын 24-нд батлагдаж, 1989 оны 08 дугаар сарын 06-нд хүчин төгөлдөр болсон. Монгол Улс тус протоколд 1999 оны 09 дүгээр сарын 22-ны өдөр нэгдэн орсон.

Энэхүү протокол нь Иргэний нисэхийн аюулгүй байдлын эсрэг хууль бус үйлдлийг хориглох тухай конвенцийн заалтыг ОУ-ын иргэний агаарын тээвэрт үйлчлэх нисэх онгоцны буудлуудад үйлдэгдэж буй террорист үйлдлүүдийг хамруулахаар өргөтгөсөн байна.

А. Гэмт хэргийн ойлголт, үндсэн шинж

Уг протоколын 2 дугаар зүйлд заасны дагуу Конвенцийн 1 дүгээр зүйлд дор дурдсан агуулгатай 1bis хэсэг шинээр нэмсэн. Энэ нь:

“1bis. Дараах үйлдлийг хууль бусаар санаатайгаар аливаа төхөөрөмж, бодис буюу зэвсэг хэрэглэн хийснийг гэмт хэрэг үйлдсэн гэж үзнэ:

(а) ОУ-ын иргэний нисэхэд үйлчилдэг нисэх буудал дахь хүний эсрэг хүчирхийлсэн үйлдэл үйлдсэн бөгөөд энэ нь түүнд хүнд гэмтэл учруулсан, амь насыг нь хохироосон, эсхүл хүнд гэмтэл учруулж буюу амь насыг нь хохироож болзошгүй байдалд хүргэсэн бол; эсхүл

(b) ОУ-ын иргэний нисэхэд үйлчилдэг нисэх буудлын төхөөрөмж буюу уг нисэх буудал дахь ашиглалтад бус байгаа агаарын хөлгийг устгасан буюу ноцтой гэмтэл учруулсан, эсхүл нисэх буудлын ажиллагааг тасалдуулсан нь тухайн нисэх буудлын аюулгүй байдалд заналхийлсэн буюу заналхийлж болзошгүй байвал”

Монреалийн конвенц болон түүний нэмэлт протокол нь хууль зүйн хувьд нэгэн адил хүчин чадалтай баримт бичиг гэж тооцогдох ёстой. Эдгээр баримт бичигт аль алинд нь тусгасан, англи хэлний “*destroy*” гэж бичигдсэн үйлдлийг Монреалийн конвенцийн орчуулгад монгол хэлнээ, агаарын хөлгийг “бүрмөсөн эвдсэн” гэж орчуулсан бол уг конвенцийн нэмэлт протоколд агаарын хөлгийг “эвдсэн” гэж өөрөөр томъёолсон. Түүнчлэн “*damages*” гэсэн үгийг агаарын хөлгийг “гэмтээсэн”, эсхүл “хохирол учруулсан” гэж өөр өөрөөр орчуулсан байна. энэхүү судалгааны хүрээнд, өмнө нь тайлбарласны дагуу “*destroy*” гэсэн үгийг “устгах”, “*damages*” гэсэн үгийг “гэмтээсэн” гэж хэрэглэв.

¹¹⁹ Төрийн мэдээлэл, Тусгай дугаар IV боть, МУ-ын ОУ-ын гэрээ, УБ, 2006, 911 дэх тал, <https://legalinfo.mn/mn/detail/1209> мөн эндээс үзнэ үү. [Сүүлд үзсэн:2022.05.10].

Эдгээр гэмт хэрэгт “ямар нэгэн төхөөрөмж, бодис, зэвсэг” ашигласан байх шинжийг шаарддаг нь маш өргөн агуулгатай хэдий ч хүчирхийллийн үйлдлийг зэвсэггүй хүн үйлдсэн тохиолдолд гэмт хэрэг үйлдсэнд тооцохгүй.¹²⁰

Хүчирхийллийн үйлдэл нь хүний эсрэг шинжтэй байх бөгөөд ноцтой гэмтэл, үхэлд хүргэх, эсвэл хүргэж болзошгүй байх шинжийг агуулах ёстой. Хүнийг санаатай алах, хүнд гэмтэл учруулсан байх шаардлага байхгүй бөгөөд халдлага үйлдэгч нь ноцтой гэмтэл учруулж, үхэлд хүргэсэн, эсхүл хүргэж болзошгүй хүчирхийллийн үйлдлийг санаатай үйлдсэн байх нь уг гэмт хэргийг хангалттай тодорхойлно.¹²¹

Ийм үйлдлийн хууль бус байдлыг нисэх онгоцны буудал нутаг дэвсгэрт нь байрладаг талын хуулиар тогтооно. Иймээс Монгол Улсын хууль тогтоомжоор хориглосон үйлдэл байх ёстой. Мөн уг үйлдэл нь хүний амь насанд аюул учруулах буюу нисэх онгоцны буудлын аюулгүй байдалд заналхийлсэн байх шинжээрээ “энгийн” хүчирхийллийн үйлдлээс ялгагдана.

Уг нэмэлт протоколд заасан дээрх үйлдлийг ОУ-ын иргэний агаарын тээврийн нисэх онгоцны буудалд үйлдсэн байхыг хамруулдаг. “Нисэх онгоцны буудал” гэж конвенцид тодорхойлоогүй боловч нисэх онгоцны буудал болон нисэх онгоцны буудлын бусад газар, түүний дотор хөөрөх зурвасыг багтаах зэрэг өргөн агуулгатай ойлголт юм.

Б. Монгол Улсын Эрүүгийн хуулийн нийцэл

ОУ-ын иргэний нисэхэд үйлчилдэг нисэх буудал дахь хүн болон тоног, төхөөрөмж, агаарын хөлгийн эсрэг хүчирхийлсэн үйлдлийг Монгол Улс гэмт хэрэгт тухайлан тооцоогүй. Харин 2 дугаар зүйлийн 1(b) хэсэгт заасан гэмт хэргийн ОУ-ын иргэний нисэхийн осол, гамшгаас урьдчилан сэргийлэхтэй холбоотой тоног төхөөрөмж нь 2015 оны ЭХ-ийн 17.8 дугаар зүйлийн “Эд хөрөнгө устгах, гэмтээх” гэмт хэргийн хүндрүүлэх шинж болох “Нийтийн эзэмшлийн ... осол, гамшгаас урьдчилан сэргийлэх тусгай зориулалтын хэрэгсэл, тоног төхөөрөмжийг устгасан, гэмтээсэн...” үйлдэлд хамаарч болох юм. Гэвч торгох, зорчих эрхийг хязгаарлах, эсхүл хамгийн дээд тал нь хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр заасныг үзэхэд энэ нь уг нэмэлт протоколын тухайлсан зорилгод нийцэхгүй юм.

Протоколын “...ашиглалтад бус байгаа агаарын хөлгийг устгасан буюу ноцтой гэмтэл учруулсан, эсхүл нисэх буудлын ажиллагааг тасалдуулсан.” гэмт хэргийг 2015 оны ЭХ-ийн 27.1 дүгээр зүйлд “Зөөх, тээвэрлэх зориулалттай хэрэгсэл, тэдгээрийн эд ангийг устгасан, гэмтээсэн, ашиглах боломжгүй болгосон, хэвийн үйл ажиллагаанд саад учруулсан, ... замаар...агаарын хөлгийн аюулгүй ажиллагаанд нөлөөлж хүний эрүүл мэнд, амь насанд аюул учруулах, эсхүл бусдын эд хөрөнгөд ноцтой хохирол учруулах нөхцөлийг бүрдүүлсэн.” хэмээн тусгасан гэж үзвэл Монгол Улс Монреалийн конвенцид тусгасан ашиглалтад байгаа агаарын хөлгийг устгасан, гэмтээсэн гэмт хэрэг болон тус конвенцийн нэмэлт протоколд заасан ашиглалтад бус байгаа агаарын хөлгийн эсрэг үйлдсэн гэмт хэргүүдийг нэгтгэж хуульчилсанд тооцогдохоор байна.

¹²⁰ Common wealth, Chapter 5, Protocol for the suppression of unlawful acts of violence at airports serving international civil aviation 1988 ('Montreal Protocol'), p.103, https://www.unodc.org/pdf/crime/terrorism/Commonwealth_Chapter_5.pdf [Сүүлд үзсэн:2022.05.23].

¹²¹ Мөн тэнд.

Гэхдээ энэхүү нэмэлт протоколд заасан гэмт хэргийн объект болох ОУ-ын нисэх буудлын аюулгүй байдал нь тус протоколын чухал элементийн нэг юм. Гэсэн ч Монреалийн протокол нь 2 дугаар зүйлийн 1 (b) хэсэгт заасан “тухайн нисэх онгоцны буудлын аюулгүй байдал” гэсэн ойлголтыг тодорхойлоогүй бөгөөд нисэх буудлын аюулгүй байдал ямар үед аюулд өртсөнд тооцогдох чиглэлийг бас өгөөгүй. Үүний дүнд “нисэх буудлын аюулгүй байдалд аюул учруулах түвшин”, ялангуяа хууль бус үйлдэл буюу нисэх онгоцны буудлын үйлчилгээнд саад учруулах тохиолдол улс бүрд өөр өөр байдаг. Цаашилбал, зарим улсад ОУ-ын нисэх онгоцны буудалд гарсан аливаа хууль бус үйлдлийг энэхүү Протоколын хамрах хүрээнд оруулах боломжтой байдаг.¹²²

Харин Монгол Улсын Иргэний нисэхийн тухай хуульд нисэхийн аюулгүй байдал нь хөндлөнгийн хууль бус үйлдлийн улмаас алдагдах талаар заасан байна. “Хөндлөнгийн хууль бус үйлдэл”¹²³ гэдэгт иргэний нисэхийн аюулгүй байдалд нөлөөлөх дараах үйлдэл болон оролдлогыг хамруулсан. Үүнд:

- a. агаарын хөлгийг хууль бусаар булаан эзлэх;
- b. үйлчилгээнд гарсан агаарын хөлгийг устгах;
- c. агаарын хөлөгт болон нисэх буудалд хүн барьцаалах;
- d. агаарын хөлөг, нисэх буудлын хамгаалагдсан бүс болон агаарын навигацийн тоног төхөөрөмж, байгууламжид хүч түрэмгийлэн нэвтрэх;
- e. гэмт хэрэг үйлдэх зорилгоор агаарын хөлгийн бүхээг, нисэх буудалд зэвсэг, эсхүл аюултай хэрэгсэл болон эд зүйлсийг нэвтрүүлэх;
- f. үйлчилгээнд гарсан агаарын хөлгийг хүний амь нас, эрүүл мэндэд ноцтой гэмтэл учруулах буюу үхэлд хүргэх, эсхүл эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд ноцтой хохирол учруулах зорилгоор ашиглах;
- g. нислэг үйлдэж буй, эсхүл газарт байгаа агаарын хөлгийн аюулгүй ажиллагаа, нисэх буудал, түүний барилга байгууламж дахь зорчигч, нисэх багийн гишүүд, газрын үйлчилгээний ажилтан болон иргэдийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй хуурамч мэдээ, мэдээллийг тараах зэрэг орж байна.

В. Дүгнэлт

Энэхүү нэмэлт протоколын 2.1.(a)-д заасан гэмт хэргийг огт тусгаагүй, 2.1.(b)-д заасан гэмт хэргийн “нисэх буудлын аюулгүй байдал”-д халдсан шинжийг ЭХ-д тусгаагүй байгаа учир ЭХ-ийг уг протоколд бүрэн нийцүүлээгүй гэж үзэж байна. Конвенцийн орчуулгад агаарын хөлгийг бүр мөсөн эвдсэн гэж, харин протоколын орчуулгад агаарын хөлгийг эвдсэн гэж орчуулсан байна. Мөн *damages* гэсэн үгийг агаарын хөлгийг гэмтээсэн эсхүл хохирол учруулсан гэж өөр өөрөөр орчуулсныг анхаарах хэрэгтэй. Хэдий Монгол Улс Иргэний нисэхийн тухай хуулиар “Хөндлөнгийн хууль бус үйлдэл”-ийг тодорхойлсон байх боловч тус протоколд тусгасан ОУ-ын иргэний нисэхэд хамаарах гэмт үйлдлүүдийг ЭХ-д гэмт хэрэгт тооцоогүй байна. Иймд тус протоколд заасан, ОУ-ын иргэний нисэх буудалд үйлдэгдсэн, хүнийг алах болон хүний биед гэмтэл учруулах, агаарын хөлгийг эвдэх зэрэг гэмт үйлдлийг ЭХ-д нэмж

¹²² Jung, Sung Yool, “A Legal Analysis of Aviation Security under the International Legal Regime”, A thesis submitted to McGill University in partial fulfillment of the requirements of the degree of Master of Laws (LL.M.) p.39 2005.

¹²³ Иргэний нисэхийн аюулгүй байдлын журам, Засгийн газрын 2021 оны 136 дугаар тогтоолын хавсралт, 1.5.29 дүгээр заалт.

тусгах нь зүйтэй.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ. МАНСУУРУУЛАХ ЭМИЙН ТУХАЙ НЭГДСЭН КОНВЕНЦ¹²⁴

Энэхүү конвенц 1961 оны 03 дугаар сарын 30-ны өдөр батлагдаж, 1964 оны 12 дугаар сарын 13-ны өдөр хүчин төгөлдөр болсон. Монгол Улс 1990 оны 12 дугаар сарын 6-нд нэгдэн орсон.

А. Гэмт хэргийн ойлголт, үндсэн шинж

Мансууруулах эмийг гагцхүү анагаах ухааны болон эрдэм шинжилгээний хэрэглээгээр хязгаарлах, энэ зорилго, зорилтод хүрэхэд ОУ-ын хамтын ажиллагаа шаардлагатайг онцолж, өмнө үйлчилж байсан гэрээнүүдийг нэгтгэн, нэгдсэн конвенц баталсан нь 1961 оны Мансууруулах эмийн тухай нэгдсэн конвенц юм. Уг конвенцоор мансууруулах бодисыг хянах ОУ-ын механизмыг бий болгосон. Мансууруулах эм, бэлдмэлийн ангиллыг гаргаж, ангилал тус бүрийн хэрэглээний хязгаарыг тогтоож, нэгдэн орсон улсуудад уг конвенцид нийцсэн дотоодын хууль тогтоомж батлан, мөрдөхийг үүрэг болгосон байдаг.

Конвенцид тусгасан гэмт хэргийн ойлголтыг авч үзвэл:

Тус конвенцийн “Шийтгэлийн заалт” гэсэн 36 дугаар зүйлийн 1.а)-д Тал бүр энэхүү конвенцийн заалтуудыг зөрчиж мансууруулах эм тарималжуулах, үйлдвэрлэх, бэлтгэх, гаргаж авах, бэлдэх, эзэмших, санал болгох, худалдахаар санал болгох, түгээх, худалдан авах, худалдах, аливаа нөхцөлөөр хүргүүлэх, зуучлах, илгээх, дамжин өнгөрүүлэн илгээх, тээвэрлэх, импортлох болон экспортлох, түүнчлэн тухайн талын үзэж байгаагаар энэхүү конвенцид харш байж болох аливаа бусад үйлдлийг санаатайгаар үйлдсэн бол шийтгэвэл зохих гэмт хэрэг гэж үзэх, мөн ноцтой гэмт хэрэгт тохирох шийтгэл, тухайлбал хорих буюу эрх чөлөөг нь хасах бусад шийтгэл хүлээлгэх явдлыг хангах арга хэмжээг өөрийн үндсэн хуулийн хязгаарлалтыг харгалзан авна гэж заасан. Энэ нь гэмт хэрэгт тооцогдох үйлдлүүдийг тоочихоос гадна энэхүү конвенцид харш байж болох аливаа бусад үйлдлийг санаатай үйлдсэн бол мөн гэмт хэрэг гэж үзэж өргөжүүлж хуульчлах боломжийг улс орнуудад олгожээ.

Түүнчлэн ноцтой гэмт хэрэгт тохирох шийтгэл, тухайлбал хорих буюу эрх чөлөөг нь хасах бусад шийтгэл хүлээлгэх арга хэмжээг өөрийн үндсэн хуулийн хязгаарлалтыг харгалзан авна гэж заасан нь нэг талаар гэмт хэрэгт тооцож тохирох шийтгэл хүлээлгэхийг даалгасан ч нөгөө талаар тухайн улсын бодлого, эрх зүйн зохицуулалтаас эрүүгийн хариуцлага хамаарахаар уян хатан шинжтэй зохицуулалт юм.

Энэхүү 1 дэх хэсэгт жагсаасан гэмт хэрэг бүрийг хэд хэдэн оронд үйлдсэн бол тусдаа гэмт хэрэг гэж үзнэ; тэдгээр гэмт хэргийн аль нэгийг үйлдэхэд санаатайгаар хамтран оролцох, үйлдэхээр үгсэн тохиролцох, завдах, түүнчлэн энэ зүйлд дурдсан гэмт хэрэгт холбогдуулан бэлтгэх үйлдэл хийх болон санхүүгийн үйл ажиллагаа явуулах нь 1 дэх хэсэгт заасны дагуу шийтгэвэл зохих гэмт хэрэг болно; тийм гэмт хэргийн төлөө гадаад улсад оногдуулсан шийтгэлийг рецидив гэмт хэрэгтнээр тогтоох зорилгоор харгалзан үзнэ гэж тус тус заажээ.

¹²⁴ Төрийн мэдээлэл, тусгай дугаар IV боть, МУ-ын ОУ-ын гэрээ, УБ, 2006, 957 дахь тал; Эрх зүйн мэдээллийн нэгдсэн сан: <https://legalinfo.mn/mn/detail/1206> [Сүүлд үзсэн:2022.06.10].

Б. Монгол Улсын Эрүүгийн хуулийн нийцэл

Тус конвенцид, улс орнууд конвенцийн үндсэн зорилгод нийцүүлэн төрийн бодлого, эрх зүйн хүрээндээ холбогдох арга хэмжээ авах боломжтой гэж заасан. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтэд хяналт тавих ажлыг чангатгах, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, байгууллага хоорондын үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах, алба хаагчдыг сургаж, мэргэшүүлэх, дээрх бодисын хор хөнөөлөөс хүн амын эрүүл мэнд, удмын санг хамгаалах, урьдчилан сэргийлэх ажлын арга хэлбэрийг өөрчилж, боловсронгуй болгох зорилгоор Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хөтөлбөр болон үндэсний хэмжээний бусад бодлогын баримт бичгийг батлан хэрэгжүүлж байна.

Монгол Улсын ЭХ-ийн “Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг” хэмээх 20 дугаар бүлгийн 20.7-20.10 дугаар зүйлүүдэд Мансууруулах эмийн тухай нэгдсэн конвенцид заасан гэмт хэргийн холбогдох хэм хэмжээг тусгасан. 20.7 дугаар зүйлд Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэргийг 20.7.1-д “Хориглосон мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг **худалдаалах зорилгогүйгээр** хууль бусаар бэлтгэсэн, хадгалсан, бусдад өгсөн, олж авсан бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.” 20.7.2-т “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг **худалдаалах зорилгоор** хууль бусаар олж авсан, бэлтгэсэн, боловсруулсан, хадгалсан, тээвэрлэсэн, илгээсэн, худалдсан бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.” гэж **ангилж** хуульчилжээ. Энэ гэмт хэргийг байнга тогтвортой; улсын хилээр нэвтрүүлж үйлдсэн бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ; зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол арван хоёр жилээс хорин жил хүртэл хугацаагаар, эсхүл бүх насаар хорих ял шийтгэнэ; Хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж дөчин мянган нэгжээс хоёр зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

ЭХ-ийн 20.7 дугаар зүйлд Тайлбар- “Энэ зүйлд заасан гэмт хэрэг үйлдэж, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээртэй адилтгах зүйлийг сайн дураараа шилжүүлэн өгсөн, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээртэй адилтгах зүйлийн хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсооход идэвхтэй туслалцаа үзүүлсэн, түүнийг үйлдсэн хүнийг илчилсэн, гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг илрүүлсэн хүнийг ялаас чөлөөлнө.” гэсэн нь эрх зүйд урамшууллын аргыг нэвтрүүлсэн хэлбэр юм.

ЭХ-ийн 20.8 дугаар зүйлд Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэх орон байраар хангах; 20.9 дүгээр зүйлд Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг завших; 20.10 дугаар зүйлд Мансууруулах үйлчилгээ бүхий ургамлыг хууль бусаар тариалах гэмт хэргийг тусгаж, тэдгээрт ял оногдуулах, хүндрүүлэх нөхцөлийг заасан.

Тус конвенцид гэмт хэрэгт тооцохоор нэрлэж тоочсон нийт үйлдлийг ЭХ-д тусгасан эсэх дээр үгчлэн авч үзвэл, “үйлдвэрлэх”, “санал болгох, худалдахаар санал болгох”, “түгээх”, “аливаа нөхцөлөөр хүргүүлэх”, “зуучлах”, “дамжин өнгөрүүлж илгээх”, “импортлох болон экспортлох” зэргийг хуульчлаагүй байна. Тухайлбал, “үйлдвэрлэх”

тухайд хууль зүйн ухааны доктор, профессор Б.Болдбаатар “ЭХ-д хууль бус “үйлдвэрлэл” -ийн талаар огт тусгагдаагүй, 2002 оны ЭХ-ийн 193 дугаар зүйлд заасан “Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг үйлдвэрлэх, бэлтгэх журам зөрчих” зүйл, ангийг хассан нь ... хүндрэл учруулж байна. Зөрчлийн тухай хуулиар хариуцлага хүлээлгэх нь гэмт этгээдүүд ял завших боломжийг олгосон байна”¹²⁵ гэж үзжээ. Конвенцид “санхүүгийн үйл ажиллагаа явуулах”, “үйлдэхээр үгсэн тохиролцох” ыг тухайлан дурдсаныг ЭХ-д үгчлэн тусгаагүй байгаа ч тухайн гэмт хэрэгт бэлтгэх, худалдах гэдэгт хамааруулан ойлгож болох юм. Мөн ЭХ-д гэмт хэрэгт хамтран оролцох нэг хэлбэр болох зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн байх шинжийг ЭХ-ийн 20.7 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, 20.8 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 20.10 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт хүндрүүлэх бүрэлдэхүүн болгон тусгайлан авч үзсэн байна.

Мансууруулах эм сэтгэцэд нөлөөт бодисыг завших гэмт хэрэгт тусгай субъектийн үйлдлийг хамруулсан. 2015 онд ЭХ-ийг шинэчлэхдээ мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг албан тушаалтан албаны чиг үүрэг, бүрэн эрх, нөлөөг урвуулан ашиглаж завшсан бол гэмт хэрэгт тооцохоор заасан. Мэргэжлийн болон албан тушаалын байдлаа ашиглаж үйлдсэн бол ял хүндрүүлэхээр авч үзэж байсныг гэмт хэргийн үндсэн шинж болгожээ. Хуульд, аюултай гэмт хэрэгтнээр тооцох үндэслэлийг заасан боловч конвенцийн үндэслэл буюу “мансууруулах эмийг урвуулан ашиглах” гэмт хэрэгт гадаад улсад шийтгүүлснийг харгалзан үзэх тухай заагаагүй байна.

Мөн мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах, мансууруулах үйлчилгээ бүхий ургамлыг хууль бусаар тариалах гэмт хэргийг тус тус, хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж, торгох ял шийтгэн хуулийн этгээдэд хариуцлага хүлээлгэх зохицуулалт ЭХ-д бий.

В. Дүгнэлт

Монгол Улсын ЭХ-д мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисыг хууль бусаар ашиглах, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэх орон байраар хангах, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисыг завших, мансууруулах үйлчилгээ бүхий ургамлыг хууль бусаар тариалах гэмт хэргүүдийг энгийн болон хүндрүүлэх бүрэлдэхүүнтэй хуульчилж, оногдуулах ялын хэмжээг заасан. Харин тухайн конвенцид гэмт хэрэгт тооцох үйлдлүүдийг нарийвчлан тоочсоныг үгчлэн авч үзвэл, зарим үйлдлийг ЭХ-д тусгаагүй байна. Үүнийг зарим үйлдлийг нэгтгэх байдлаар ЭХ-д тусгасан байна хэмээн хамруулж ойлгох боломжтой ч конвенцтой нийцүүлэх үүднээс зарим зайлшгүй тухайлан тусгах шаардлагатай үйлдлүүдийг орхигдуулсан байж болзошгүй.

Зайлшгүй тусгахаар заасан хэм хэмжээ (хамтран оролцогчдын үйлдлийг гэмт хэрэгт тооцож ял оногдуулах гэх мэт) БОУ- орнууд өөрсдийн бодлого, эрх зүйн хүрээнд нэмж тусгах боломжтой гэж конвенцид заасан нээлттэй арга хэмжээний хүрээнд тусгай субъектийн үйлдлийг хамруулах, хуулийн этгээдэд хариуцлага хүлээлгэхээс гадна уг конвенцид заасан үүргээ эрх зүйн хүрээнд биелүүлэх үүднээс урамшууллын аргыг

¹²⁵ Б.Болдбаатар, “Хар тамхи, мансууруулах бодисын хууль бус эргэлттэй тэмцэж буй хууль тогтоомжийн хэрэгжилт, тулгамдаж буй асуудал”, *Хар тамхины гэмт явдал: шалтгаан, нөхцөл, урьдчилан сэргийлэх арга зам*” сэдэвт эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл, Уб, 2018, 15 дахь тал.

хэрэглэх зэрэг нэлээд хүчин чармайлт гаргасан байна гэж үзэв. Хууль зүйн бодлогын хүрээнд, Тус конвенцийн хүрээнд гэмт хэрэгт тооцохоор заасан үйлдлүүдийг ЭХ-д гэмт хэрэгт тооцож бүрэн тусгаагүй байдлыг нягтлахын зэрэгцээ Зөрчлийн тухай хуульд тусгаж зөрчилд тооцож буй зарим үйлдэл тус конвенцийн дагуу гэмт хэрэгт тооцогдох эсэхийг тогтоож, ОУ-ын гэрээнд нийцүүлэх замаар дотоодын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлага байхыг үгүйсгэхгүй юм.

ДОЛДУГААР БҮЛЭГ. СЭТГЭЦЭД НӨЛӨӨЛӨХ БОДИСЫН ТУХАЙ КОНВЕНЦ¹²⁶

1971 оны 02 дугаар сарын 21-ний өдөр баталж, 1976 оны 08 дугаар сарын 16-ны өдөр хүчин төгөлдөр болсон. Монгол Улс 1999 оны 12 дугаар сарын 15-нд соёрхон баталсан.

А. Гэмт хэргийн ойлголт, үндсэн шинж

1961 оны Мансууруулах эмийн тухай нэгдсэн конвенцийн бий болгосон тогтолцооноос гадуур үлдсэн, тухайн үедээ шинэ зах зээлийн онцлогоос болж үүсэж байсан сэтгэцэд нөлөөлөх бодистой холбоотой харилцааг журамлах үүднээс 1971 онд Сэтгэцэд нөлөөлөх бодисын тухай конвенц батлагдсан. Энэхүү конвенц батлагдсанаар хууль бус үйлдвэрлэл, хэрэглээг хязгаарлах, хүн амыг хорт зуршлаас хамгаалахад чиглэгдсэн ОУ-ын эрх зүйн орчин бүрдсэн. Эдгээр үйлдэл нь нийтэд аюултай байдлаар үйлдэгддэг тул бусад гэмт хэргээс ялгагдах ёстой.¹²⁷ Уг конвенцид 1961 оны конвенцид багтаагүй мансууруулах бодисуудыг нэгтгэн нийт 4 жагсаалт гарган 1 дүгээр жагсаалтад орсон бодисыг хатуу хяналтад авч, хэрэглэхийг хориглох талаас нь оролцогч орнууд арга хэмжээ авах, мөн 2,3,4 дүгээр жагсаалтад орсон бодисыг мөн хяналтад авч зөвхөн эмчийн жороор олгож байхаар зохицуулжээ.

Конвенцид тусгасан гэмт хэргийн талаарх хэм хэмжээг авч үзвэл:

Тус конвенцийн “Шийтгэлийн заалт” гэсэн 22 дугаар зүйлийн 1. а)-д “Тал бүр энэхүү конвенцийн дагуу хүлээх үүргээ биелүүлэх үүднээс баталсан хууль буюу журамд харш, санаатайгаар үйлдсэн аливаа үйлдлийг шийтгэвэл зохих гэмт хэрэг гэж үзэх бөгөөд ноцтой гэмт хэрэгт тохирох шийтгэл, тухайлбал хорих буюу эрх чөлөөг нь хасах бусад шийтгэл хүлээлгэх явдлыг өөрийн үндсэн хуулийн хязгаарлалтыг харгалзан хангана.” гэж заасан. Энэ нь нэг талаас Сэтгэцэд нөлөөлөх бодисын тухай конвенцид нийцсэн хүрээнд хууль тогтоомж батлах, нөгөө талаас тухайн хууль тогтоомжид заасныг зөрчиж, санаатай үйлдсэн аливаа үйлдлийг шийтгэвэл зохих гэмт хэрэгт тооцож, тохирох ял оногдуулах тухай ойлголт юм.

Мөн 22 дугаар зүйлийн 1.b)-д “Сэтгэцэд нөлөөлөх бодис урвуулан хэрэглэгчид тийм гэмт хэрэг үйлдсэн бол талууд дээрх хэсгийг үл харгалзан шийтгэл буюу ялын оронд, эсхүл нэмэлт болгож тэднийг эмчлэх, хүмүүжүүлэх, эмнэлгийн дараах эмчилгээ хийх, нөхөн сэргээх, нийгмийн амьдралд эргүүлэн оруулах арга хэмжээнд 20 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт нийцүүлэн хамруулахаар зааж болно.” гэж заасан. Энэ нь

¹²⁶ Төрийн мэдээлэл, Тусгай дугаар IV боть, МУ-ын ОУ-ын гэрээ, УБ, 2006, 1005 дахь тал, <https://legalinfo.mn/mn/detail/1292> мөн эндээс үзнэ үү. [Сүүлд үзсэн: 2022.06.10].

¹²⁷ Монгол Улсын дээд шүүх, Ханнс-Зайделийн сангийн Монгол дахь төлөөлөгчийн газар, *Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар*, УБ, 2013, 490 дэх тал.

холбогдох гэмт хэрэг үйлдсэн этгээдийг шийтгэх зарчмыг зөвхөн баримтлалгүй, хүмүүнлэгийн чанартай арга хэмжээнүүд авах боломжийн тухай хөндсөн болно.

Энэхүү конвенцоор сэтгэцэд нөлөөлөх бодисын ангилал, хэрэглээний хязгаарыг тогтоосон ба конвенцийн I-IV жагсаалтад орсон бодистой холбоотой гэмт хэрэгт тооцогдох өөр хоорондоо холбоотой үйлдлийг хэд хэдэн оронд үйлдсэн бол үйлдэл бүрийг тусдаа гэмт хэрэг гэж үзнэ; тэдгээр гэмт хэргийн аль нэгийг үйлдэхэд санаатайгаар хамтран оролцох, үйлдэхээр үгсэн тохиролцох, завдах, түүнчлэн энэ конвенцийн хүрээний гэмт хэрэгт холбогдуулан бэлтгэх үйлдэл хийх болон санхүүгийн үйл ажиллагаа явуулах нь шийтгэвэл зохих гэмт хэрэг болно; тийм гэмт хэргийн төлөө гадаад улсад оногдуулсан шийтгэлийг рецидив байдлыг тогтоох зорилгоор харгалзан үзнэ; конвенцид дурдсан гэмт хэргийг үйлдэхэд ашигласан, эсхүл зориулагдсан сэтгэцэд нөлөөлөх аливаа бодис, эсхүл өөр бодис, түүнчлэн аливаа тоног төхөөрөмжийг түр хураах буюу бүрмөсөн хураана гэж заасан.

Б. Монгол Улсын Эрүүгийн хуулийн нийцэл

Монгол Улс Сэтгэцэд нөлөөлөх бодисын тухай конвенцийн дагуу хүлээх үүргээ биелүүлэх үүднээс, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын эргэлтэд хяналт тавих, энэ төрлийн бодисын хор хөнөөлөөс хүн амын эрүүл мэнд, удмын санг хамгаалах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулах зорилт тавьж, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль батлан хэрэгжүүлж байна. Тус хуулийн 16.2-т “Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд ЭХ, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.” гэж заасан. Иймээс сэтгэцэд нөлөөлөх бодис, тэдгээрийн түүхий эдийг бэлтгэх, хуваарилах, худалдах, хэрэглэх, тээвэрлэх, хадгалах, устгах, Монгол Улсын хилээр нэвтрүүлэх, тус улсын нутаг дэвсгэр дээгүүр дамжин өнгөрүүлэх талаар Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль, бусад хууль тогтоомжоор тогтоосон үйл ажиллагаа¹²⁸-тай холбоотой гэмт хэргийг ЭХ-д тодорхойлно.

ЭХ-д мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, түүний хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэргийн зохицуулалтыг хамтад нь томъёолж, 20.7 дугаар зүйлд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах, мансууруулах эм, 20.8 дугаар зүйлд Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэх орон байраар хангах; 20.9 дүгээр зүйлд Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг завших; 20.10 дугаар зүйлд Мансууруулах үйлчилгээ бүхий ургамлыг хууль бусаар тариалах гэмт хэргийг тусгаж, тэдгээрт ял оногдуулах, хүндрүүлэх нөхцөлийг заасан. Эдгээр гэмт хэргийн төрлийг ЭХ-д хуульчлахдаа ОУ-ын гэрээний хэм хэмжээнд хэрхэн нийцүүлснийг тус судалгааны Зургадугаар бүлгийн Б. “Монгол Улсын ЭХ-ийн нийцэл” хэсгээс мөн үзнэ үү.

Конвенцийн 22 дугаар зүйлийн 2 хэсгийн (а) ii-т заасан гэмт хэргийн аль нэгийг үйлдэхэд санаатайгаар хамтран оролцох, үйлдэхээр үгсэн тохиролцох, завдах¹²⁹ үйлдлийг шийтгэвэл зохих гэмт хэрэг хэмээн тусгасан. 2002 оны ЭХ-ийн 192.3.5 дахь заалтад заасан Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл,

¹²⁸ Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль, 3.1.2 дугаар зүйл.

¹²⁹ Сэтгэцэд нөлөөлөх бодисын тухай конвенц, 1971, 22 дугаар зүйлийн 2.2 хэсэг.

<https://old.legalinfo.mn/law/details/1292> . [Сүүлд үзсэн: 2022.06.10].

бодисыг хууль бусаар бэлтгэх, олж авах, хадгалах, тээвэрлэх, илгээх, борлуулах гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүнд “үгсэн тохиролцох” үйлдлийг хамааруулж, ОУ-ын гэрээнд нийцүүлсэн байв. Харин 2015 оны ЭХ-аас үүнийг хасаж, ЭХ-ийн 2.7.1 дүгээр зүйлд зааснаар гэмт хэрэгт бэлтгэхэд багтаан, гэмт хэргийн хамтран оролцогчдод тооцож хуульчилсан байна. Өөрөөр хэлбэл, гэмт хэрэг үйлдэхийг завдсан болон үйлдэл хийхээр бэлтгэсэн этгээдүүд хариуцлага хүлээх боломжтой.

Харин ЭХ-д конвенцийн “санхүүгийн үйл ажиллагаа явуулах” үйлдлийг үгчлэн хуульчлаагүй боловч ЭХ-ийн 20.7.2-т зааснаар эдгээрийг худалдах зорилгоор явуулсан үйл ажиллагаа гэж хамааруулсан бололтой. Ингэснээрээ “санхүүгийн үйл ажиллагаа явуулах” үйлдлийн хүрээг хумьж, хязгаарласан байж болзошгүй. Иймээс ЭХ-д дээрх үйлдлийг нэмж хуульчлах шаардлагатай эсэхийг нягтлах нь зүйтэй.

Мөн конвенцийн 22 дугаар зүйлийн 3-т “ 1, 2 дахь хэсэгт дурдсан гэмт хэргийг үйлдэхэд ашигласан, эсхүл зориулагдсан сэтгэцэд нөлөөлөх аливаа бодис, эсхүл өөр бодис, түүнчлэн аливаа тоног төхөөрөмжийг түр хураах буюу бүрмөсөн хураана.” гэж заасан боловч ЭХ-д заасан холбогдох гэмт хэрэгт хөрөнгө хураах ялыг хамтад нь хэрэглэх талаар тусгаагүй байна.

В. Дүгнэлт

Сэтгэцэд нөлөөлөх бодисын тухай конвенцид сэтгэцэд нөлөөлөх бодисын ангилал, хэрэглээний хязгаарлалтыг тогтоосон.

ЭХ-д мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, түүний хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэргийн зохицуулалтыг хамтад нь томъёолсон учир энэхүү бүлгийн дүгнэлтийг тус судалгааны Зургадугаар бүлгийн В-д тусгасан дүгнэлтийн холбогдох хэсгээс мөн үзнэ үү.

Хамтран оролцогчдын үйлдлийг гэмт хэрэгт тооцож ял оногдуулахаас гадна тусгай субъектийн үйлдлийг хамруулах, хуулийн этгээдэд хариуцлага хүлээлгэхээс гадна урамшууллын аргыг хэрэглэсэн нь конвенцид заасан үүргээ хэрэгжүүлж буй арга хэлбэр юм.

Тус конвенцийн хүрээнд гэмт хэрэгт тооцогдох зарим үйлдлийг нэгтгэх байдлаар ЭХ-д тусгасан байна хэмээн хамруулж ойлгох боломжтой ч конвенцтой нийцүүлэх үүднээс зайлшгүй тусгах шаардлагатай зарим гэмт үйлдлийг орхигдуулсан эсэхийг нягтлах шаардлагатай. Хууль зүйн бодлогын хүрээнд, конвенцийн дагуу гэмт хэрэгт тооцогдох үйлдлүүдийг Зөрчлийн тухай хуульд тусгах байдлаар гэмт хэрэг гэж үзэлгүй, зөрчилд тооцож буй эсэхийг мөн харьцуулж үзэх нь зүйтэй. Энэхүү судалгааны хүрээнд ЭХ-ийн зохицуулалтыг ОУ-ын гэрээнд нийцэж буй эсэхийг судалж байгаа учир бусад хуулийн зохицуулалтыг дэлгэрэнгүй хамруулаагүй болно. Мөн тус конвенцид заасан гэмт хэргийг үйлдэхэд ашигласан, эсхүл зориулагдсан сэтгэцэд нөлөөлөх аливаа бодис, эсхүл өөр бодис, түүнчлэн аливаа тоног төхөөрөмжийг түр хураах буюу бүрмөсөн хураах үзэл баримтлалыг ЭХ-д тусгаж, гэмт хэрэгт хөрөнгө хураах ялыг хамтад нь хэрэглэх асуудлыг шийдвэрлэх шаардлагатай.

НАЙМДУГААР БҮЛЭГ. МАНСУУРУУЛАХ ЭМ, СЭТГЭЦЭД НӨЛӨӨЛӨХ БОДИСЫН ХУУЛЬ БУС ЭРГЭЛТИЙН ЭСРЭГ НҮБ-ЫН КОНВЕНЦ¹³⁰

Энэхүү конвенц нь 1988 оны 12 дугаар сарын 20-ны өдөр батлагдаж, 1990 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр хүчин төгөлдөр болсон ба Монгол Улс 2003 оны 6 дугаар сарын 25-ны өдөр нэгдэн орсон.

Энэ конвенцоор, тус судалгааны 6,7 дугаар бүлэгт судалсан 1961 оны Мансууруулах эмийн тухай нэгдсэн конвенц болон 1971 оны Сэтгэцэд нөлөөлөх бодисын тухай конвенцид хориглосон мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлттэй холбоотой асуудлыг ОУ-ын хамтын ажиллагааны төвшинд шийдэх зорилготой.

Өөрөөр хэлбэл өмнө нь батлагдсан холбогдох хоёр конвенцийн туслах хэрэгсэл хэмээн ойлгож болох юм. Тус конвенцид “хууль бус эргэлт” гэдгийг тодорхойлж, нэгдэн орсон улсууд ямар ямар үйлдлүүдийг гэмт хэрэгт тооцохыг зааж, дотоодын хууль тогтоомждоо тусгахыг үүрэг болгосон байдаг. Түүнчлэн дотоодын хууль тогтоомжийг конвенцид нийцүүлэхтэй холбоотой арга замыг тусгасан.

Конвенц нь мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисын хяналтын тогтолцоо, хууль бус эргэлтийн эсрэг авах арга хэмжээний талаар, түүнтэй холбоотой мөнгө угаах үйл ажиллагааг зогсоох, эрүүгийн эрх зүйн асуудлаар ОУ-ын хамтын ажиллагааг сайжруулах зэрэг зорилтууд тавьсан бөгөөд 1961, 1971 оны конвенцуудыг үр дүнд хүргэхэд арга барил, механизм, тогтолцооны үүднээс туслахад чиглэсэн гэж ойлгож болно.

А. Гэмт хэргийн ойлголт, үндсэн шинж

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг НҮБ-ын конвенцийн 1 дүгээр зүйлийн “m” хэсэгт “Мансууруулах эм сэтгэцэд нөлөөлөх бодисын **хууль бус эргэлт**” гэж энэхүү конвенцийн 3 дугаар зүйлийн 1 болон 2 дахь хэсэгт заасан гэмт хэрэгт дараах зүйлийг хамруулахаар заажээ.¹³¹ Үүнд:

3 дугаар зүйл. Гэмт хэрэг, түүнд хүлээлгэх хариуцлага

1. Тал бүр, санаатайгаар үйлдэгдсэн дараах үйлдлийг дотоодын хуулийн дагуу эрүүгийн гэмт хэрэг гэж тодорхойлох арга хэмжээ авна:

- a) i) 1961 оны конвенц, нэмэлт өөрчлөлт оруулсан уг конвенц болон 1971 оны конвенцийн заалтыг зөрчиж аливаа мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисыг үйлдвэрлэх, бэлтгэх, гаргаж авах, бэлдэх, санал болгох, худалдахаар санал болгох, түгээх, худалдах, ямар ч нөхцөлөөр хамаагүй хүргэх, зуучлах, илгээх, дамжуулан өнгөрүүлж илгээх, тээвэрлэх, экспортлох, импортлох;
- ii) 1961 оны конвенц, нэмэлт, өөрчлөлт оруулсан уг конвенцийн заалтыг зөрчиж мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисыг үйлдвэрлэх зорилгоор опиумын намуу, кока бут, каннабис ургамлыг тарималжуулах;

¹³⁰ Төрийн мэдээлэл, Тусгай дугаар IV боть, МУ-ын ОУ-ын гэрээ, УБ, 2006, 1005 дахь тал, <https://legalinfo.mn/mn/detail/1239> мөн эндээс үзнэ үү. [Сүүлд үзсэн:2022.06.10].

¹³¹ Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг НҮБ-ын конвенц, 1988, 1.m хэсэг.

- iii) (i) дэд хэсэгт заасан аливаа үйл ажиллагааг явуулах зорилгоор мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисыг хадгалах, худалдан авах;
 - iv) мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисыг тарималжуулах, үйлдвэрлэх эсхүл бэлтгэхэд зориулагдсаныг мэдсээр байж I хүснэгт, II хүснэгтэд заасан тоног төхөөрөмж, эд зүйлс, бодисыг бэлтгэх, тээвэрлэх, түгээх;
 - v) (i), (ii), (iii), (iv) дэд хэсэгт тодорхойлсон гэмт хэргийг удирдах, санхүүжүүлэх, зохион байгуулах.
- b) i) аливаа гэмт хэрэг болон энэ хэсгийн (a) дэд хэсгийн дагуу тогтоосон гэмт хэрэг үйлдсэний үр дүнд бий болсон, эсхүл дурдсан гэмт үйлдэлд оролцсоны үр дүнд бий болсон хөрөнгө гэдгийг мэдсээр байж хөрөнгийн хууль бус эх үүсвэрийг халхавчлах, нуун дарагдуулах болон гэмт хэрэг үйлдсэн аливаа этгээдэд гэмт үйлдлийнхээ эрх зүйн үр дагавраас зайлсхийхэд нь туслах зорилгоор уг хөрөнгийг хувиргах, шилжүүлэх;
- ii) энэ хэсгийн (a) дэд хэсгийн дагуу тогтоосон гэмт хэрэг үйлдсэний үр дүнд бий болсон, эсхүл тийм гэмт хэрэг үйлдэхэд оролцсоны үр дүнд бий болсон хөрөнгө гэдгийг мэдсээр байж түүний жинхэнэ мөн чанар, эх үүсвэр, байрлал, захиран зарцуулах арга, хөдөлгөөн, хөрөнгөтэй холбоотой жинхэнэ эрх эсхүл эзэмшигчийг халхавчлах, нуун дарагдуулах;
- c) Үндэсний хууль тогтоомжийнхоо заалтууд, эрх зүйн тогтолцооныхоо гол зарчмуудыг баримтлан:
- i) энэ хэсгийн (a) дэд хэсгийн дагуу тогтоосон гэмт хэрэг болон гэмт хэргүүд, эсхүл тухайн гэмт хэрэг болон гэмт хэргүүдэд оролцсон үйлдлийн улмаас бий болсон хөрөнгийг хүлээж авахдаа энэ тухай мэдсээр байж олж авсан, эзэмшсэн, хэрэглэсэн;
 - ii) I хүснэгт, II хүснэгтэд заасан тоног төхөөрөмж, эд зүйлс болон бодисыг аливаа мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисыг хууль бусаар тарималжуулах, үйлдвэрлэхэд ашиглаж байгаа, эсхүл тийм зорилгоор ашиглахад зориулагдсан болохыг мэдсээр байж эзэмших;
 - iii) энэ зүйлийн дагуу тогтоосон аливаа гэмт хэргийг үйлдэх, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисыг хууль бусаар хэрэглэхэд олон нийтийг аливаа хэлбэрээр өдөөн хатгах, уриалах;
 - iv) энэ зүйлээр тогтоосон аливаа гэмт хэргийг үйлдэхэд оролцсон, холбогдсон, үйлдэхээр үгсэн тохиролцсон, үйлдэхийг завдсан, түүнчлэн үйлдэх үед хамжсан, хатгасан, дэмжлэг үзүүлсэн эсхүл зөвлөгөө өгсөн.

2. Тал бүр Үндсэн хуулийнхаа заалтууд, эрх зүйн тогтолцооныхоо зарчмыг баримтлан 1961 оны конвенц, нэмэлт өөрчлөлт оруулсан 1961 оны конвенц, 1971 оны конвенцийг зөрчиж аливаа мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисыг хувийн хэрэгцээнд зориулж санаатайгаар хадгалах, олж авах, тарималжуулахыг дотоодын хуульдаа гэмт хэрэг гэж тодорхойлоход шаардлагатай байж болох арга хэмжээ авна.

Б. Монгол Улсын Эрүүгийн хуулийн нийцэл

Хууль бус эргэлтийг гэмт хэрэгт тооцож, шийтгэх нь конвенцийн үндсэн онцлогийн нэг бөгөөд 3.1 дэх хэсэгт заасан “Тал бүр дараах зүйлийг санаатайгаар үйлдсэн тохиолдолд өөрийн дотоодын хууль тогтоомжийн дагуу эрүүгийн гэмт хэрэг гэж тогтооход шаардлагатай арга хэмжээг авна” гэснийг бүх талууд заавал биелүүлэх ёстой¹³² байна. Иймээс үүний дагуу Монгол Улс энэхүү ОУ-ын гэрээнд заасан төрлийн гэмт хэргүүдийг ЭХ-даа хуульчилж, гэмт хэрэгт тооцох нь зайлшгүй хүлээх үүргийн нэг билээ.

1. Конвенцийн 3 дугаар зүйлийн 1.а) хэсэгт заасан гэмт үйлдлүүд

ЭХ-ийн 20.7-20.10-р зүйлүүдээр конвенцид холбогдох гэмт хэргийг зүйлчилж өгсөн байна. Конвенцийн 3.1.а).i) заалтын хувьд 1961, 1971 оны конвенцуудтай ихэнх заалтууд нь адилхан бөгөөд ЭХ-д мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисыг үйлдвэрлэх, гаргаж авах, санал болгох, худалдахаар санал болгох, түгээх, ямар ч нөхцөлөөр хамаагүй хүргэх, зуучлах, дамжуулан өнгөрүүлж илгээх, экспортлох болон импортлох зэрэг үйлдлийг үгчлэн тусгаагүй байна. Харин конвенцид заасан “үйлдвэрлэх” гэсэн үйлдлийг манай улс Зөрчлийн тухай хуулийн 6.4.2.1 дүгээр зүйлд хуульчилснаас үзэхэд уг үйлдлийг гэмт хэрэгт тооцолгүй, зөрчилд тооцсон байна. Мөн ЭХ-ийн 20.7.3.3 дахь заалт нь “улсын хилээр нэвтрүүлж үйлдсэн бол” гэж 20.7.1-д заасан үндсэн гэмт хэргийг хүндрүүлэн авч үзэж байх тул экспортлох, импортлох үйлдлийг илэрхийлсэн гэж үзэж болохгүй юм. Харин Монгол Улс Зөрчлийн тухай хуулийн 6.4.2.8 дугаар зүйлд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг улсын хилээр нэвтрүүлэх гэж тухайн гэмт үйлдлийг зөрчилд тооцсоныг харж болно. Гэрээний талуудын хувьд эдгээр үйлдлийг үндсэн гэмт хэрэгт тооцох ёстой байдаг ч Монгол Улс зөрчилд тооцсон нь ОУ-ын гэрээнд нийцээгүй байна гэж үзэв.

3.1.а).ii)-т заасан “... мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисыг үйлдвэрлэх зорилгоор опиумын намуу, кока бут, каннабис ургамлыг тарималжуулах” гэмт хэргийг ЭХ-ийн 20.10 дугаар зүйлд “Мансууруулах үйлчилгээ бүхий ургамлыг хууль бусаар тариалах” гэмт хэрэг гэж конвенцид заасан ургамлуудыг тухайлан дурдалгүй, ерөнхийд нь мансууруулах үйлчилгээтэй бүх ургамлыг хамруулахаар хуульчилснаас үзэхэд конвенцийн заалтыг өргөжүүлсэн байна.

Харин 3.1.а).iii)-т заасан гэмт хэргийн төрлийг үзвэл “(i) дэд хэсэгт заасан аливаа үйл ажиллагааг явуулах зорилгоор мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисыг хадгалах, худалдан авах” гэж, (i) дэд хэсэгт заасан бүх үйлдэлд хамааруулах байдлаар хадгалах, худалдан авах үйлдэлд зорилго нэмж гэмт хэрэгт тооцохоор заажээ. Дэлгэрүүлбэл, конвенцийн (i) дэд хэсэгт заасан “үйлдвэрлэх, бэлтгэх, гаргаж авах, бэлдэх, санал болгох... гэх мэт” шинжүүд нь бүгд хадгалах болон худалдан авах үйлдлийн зорилго болж өөр өөр гэмт хэргүүд болохоор байна. ЭХ-ийн зохицуулалтаас авч үзэхэд 20.7.1 болон 20.7.2 дугаар зүйлд “худалдаалах зорилгоор/ худалдаалах зорилгогүйгээр” гэж ялгаж авч үзсэн байна. ЭХ-д ингэж ялгаж заасан нь конвенцид заасан дээрх зорилгуудыг ерөнхийд нь багтаах боломжтой тул зорилгын хувьд

¹³² Commentary on the United Nations Convention against illicit traffic in narcotic drugs and psychotropic substances, 1988, p.50, para 3.4.
https://www.unodc.org/documents/commissions/CND/Int_Drug_Control_Conventions/Commentaries-OfficialRecords/1988Convention/1988_COMMENTARY_en.pdf, [Сүүлд үзсэн: 2022.06.25].

хангасан гэж үзье. Харин конвенцид заасан “худалдаж авах” үйлдэл ЭХ-д тусгагдаагүй байна.

3.1.а).iv) дэх хэсэгт заасан “...тоног төхөөрөмж, эд зүйлс, бодисыг бэлтгэх, тээвэрлэх, түгээх” гэмт хэргийн хувьд “бэлтгэх” үйлдлийг ЭХ-ийн 20.7.1 болон 20.7.2-т, “тээвэрлэх” үйлдлийг ЭХ-ийн 20.7.2-т тус тус тусгасан байна. Харин “түгээх” үйлдлийг үгчлэн тусгаагүй. Гэхдээ ЭХ-ийн бусад зүйлүүд, тухайлбал: 20.12 дугаар зүйл. Эрүүл ахуйн шаардлага хангаагүй хүнсний бүтээгдэхүүн ... **түгээх**; 20.14 дүгээр зүйл. Хууль бусаар эм, биобэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл ... **түгээх** зэргээр “түгээх” үйлдлийг үгчилж хуульчилсан практик байгаа тул энэхүү гэмт үйлдлийг мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хувьд мөн үгчлэн хэрэглэж болохоор байна. Харин “мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисыг тарималжуулах, үйлдвэрлэх, эсхүл бэлтгэхэд зориулагдсаныг мэдсээр байж” гэсэн зорилгыг мөн тусгаагүй ч энэ нь ЭХ-д заасан “худалдаалах зорилго”-д хамаарч болох юм. Гэвч конвенцийн дээрх зүйлд дурдсан тоног төхөөрөмж, эд зүйлсийг бэлтгэх, тээвэрлэх, түгээх үйлдлийг ЭХ-д тусгаагүй байна.

Конвенцийн 3.1.а)v)-д, (i), (ii), (iii), (iv) дэд хэсэгт тодорхойлсон гэмт хэргийг *удирдах, санхүүжүүлэх, зохион байгуулах* зэрэг гэмт хэргийг тусгажээ. Харин ЭХ-ийн 3.3 дугаар зүйлийн дагуу, гэмт хэрэг үйлдэхийг санаачилсан, **удирдсан**, төлөвлөсөн, гэмт хэрэг хамтран үйлдэгчдийн үүрэг, оролцоог хуваарилсан, **зохион байгуулалттай гэмт бүлэг байгуулсан этгээдийг** гэмт хэргийн зохион байгуулагч гэж тооцохоор заасан бөгөөд зохион байгуулалттай гэмт бүлэг байгуулсан, удирдсан хүнийг тухайн үйлдэлд нь болон зохион байгуулалттай гэмт бүлгийн бусад гишүүний үйлдсэн гэмт хэргийн гүйцэтгэгчид тооцож ял оногдуулахаар зааснаас үзэхэд “удирдсан” гэх үйлдлийг “зохион байгуулсан” үйлдлээс ялгаж тусгаагүй, харин гэмт хэргийг зохион байгуулсан үйлдэл дотор удирдах үйлдлийг багтааж ойлгож болохоор байна. Харин конвенцийн 3.1.а)v)-д заасанчлан i-iv-т заасан “санхүүжүүлэх” үйлдлийг тусгаагүйгээрээ ЭХ сул талтай болжээ.

2. Конвенцийн 3 дугаар зүйлийн 1.b) хэсэгт заасан гэмт үйлдлүүд

Конвенцийн 3.1.b) хэсэгт заасны дагуу, аливаа гэмт хэрэг болон энэ хэсгийн (a) дэд хэсгийн дагуу тогтоосон гэмт хэрэг үйлдсэний үр дүнд бий болсон, эсхүл дурдсан гэмт үйлдэлд оролцсоны үр дүнд бий болсон хөрөнгө гэдгийг мэдсээр байж нуун дарагдуулсан, жинхэнэ мөн чанар, эх үүсвэрийг халхавчилсан гэх мэт үйлдлүүд нь мөнгө угаах¹³³ төрлийн гэмт хэргийн заалтууд болно. Үүнийг конвенцийн 3.1.(c)iv) дэх хэсэгт заасан “...гэмт хэрэг үйлдэхэд оролцсон, үгсэн тохиролцсон...” этгээдүүдийг шийтгэхэд өөрийн эрх зүйн тогтолцоонд ямар ч хязгаарлалт байхаас үл хамааран аль нэг тал (b) дэд хэсэгт заасан мөнгө угаах гэмт хэргийг хуульчлах ёстой¹³⁴ гэж конвенцийн тайлбарт тусгажээ. Гэвч конвенцийн (b) дэд хэсэгт заасан энэхүү заалт нь хүнд гэмт хэрэг болох “мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисыг хууль бус эргэлт”-ээс үүдэлтэй хөрөнгө угаах үйлдлийг гэмт хэрэгт тооцохоор хязгаарладаг. Харин сүүлийн жилүүдэд мөнгө угаах гэмт хэргийг зөвхөн мансууруулах эм, сэтгэцэд

¹³³ Commentary on the United Nations Convention against illicit traffic in narcotic drugs and psychotropic substances, 1988, p.59, para 3.33,

https://www.unodc.org/documents/commissions/CND/Int_Drug_Control_Conventions/Commentaries-OfficialRecords/1988Convention/1988_COMMENTARY_en.pdf, [Сүүлд үзсэн: 2022.06.25].

¹³⁴ Мөн тэнд, p.63, para 3.43.

нөлөөлөх бодисын хувьд хязгаарлалгүй эрүүгийн бусад гэмт хэргийн хувьд өргөтгөх хандлага ажиглагдаж байна.¹³⁵

Практикт зарим улс орон конвенцийн 3.1.b) хэсэгт заасантай адил, төстэй хэлбэрээр дотоодын хууль тогтоомждоо тусгасан бол бусад улс орнууд өмнө нь байсан эрүүгийн гэмт хэргийн хамрах хүрээг өөрчлөх зэргээр уг гэмт хэргийг хуульдаа тусгадаг байна. Гэсэн ч тухайн үйлдлийг гэмт хэрэгт бүрэн тооцсон тохиолдолд аль ч аргыг хүлээн зөвшөөрдөг¹³⁶. Монгол Улсын хувьд мөнгө угаах гэмт хэргийг ЭХ-ийн 18.6 дугаар зүйлд хуульчилсан байх бөгөөд энэ гэмт хэргийн хамрах хүрээ нь конвенцийн 3.1.b) хэсэгт заасан гэмт хэргийн ойлголтод багтаж байна.

3. Конвенцийн холбогдох бусад зүйлд заасан гэмт хэргүүд

Конвенцийн 3.1.c) i) хэсэгт заасан гэмт хэргийн “мэдсэн байх” шинж нь “хүлээн авах үед” бүрдсэн байх ёстой. Бэлэглэсэн болон үнэ цэнийх нь хувьд барааг хүлээн авч, тухайн бараагаа үргэлжлүүлэн хэрэглэж байгаа бөгөөд хожим нь мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэг үйлдсэн гэж сэжиглэж, мэдсэн тохиолдолд дээрх зүйлд заасан гэмт хэрэг үйлдсэн гэж үзэхгүй.¹³⁷ Энэ нь ЭХ-ийн 18.6 дугаар зүйлд заасан мөнгө угаах гэмт хэргийн шинжийг хангаж байх тул ЭХ-д дээрх гэмт хэргийн төрлийг тусгасан байна гэж үзлээ.

Харин 3.1.c) ii)-т заасан “I хүснэгт, II хүснэгтэд заасан тоног төхөөрөмж, эд зүйлс болон бодисыг аливаа мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисыг хууль бусаар тарималжуулах, үйлдвэрлэхэд ашиглаж байгаа, эсхүл тийм зорилгоор ашиглахад зориулагдсан болохыг мэдсээр байж эзэмших,” гэмт хэргийг ЭХ-д тусгаагүй бөгөөд харин Зөрчлийн тухай хуулийн 6.4.2 дугаар зүйлд “...багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийг үйлдвэрлэх, бэлтгэх, боловсруулах, хадгалах...” гэж тусгажээ. Энэ нь гэмт хэрэгт ашиглахад зориулсан, эсхүл ашигладаг зэргээр тухайн багаж хэрэгслийн шинжийг тусгаагүй харин ямар ч багаж байж болохоор, эсхүл “Мансууруулах, тайвшруулах үйлчилгээтэй багаж, хэрэгсэл...” байхаар ойлгомжгүй болжээ. Иймд дээрх гэмт хэргийг ЭХ-д тусгаагүй бөгөөд Зөрчлийн тухай хуульд тусгахдаа ч ойлгомжгүй байдлаар тусгасан гэж үзэхэд хүргэж байна.

Конвенцийн 3.2 дугаар зүйлд заасны дагуу тал бүр Үндсэн хуулийнхаа заалтууд, эрх зүйн тогтолцооныхоо зарчмыг баримтлан 1961 оны конвенц, нэмэлт өөрчлөлт оруулсан 1961 оны конвенц, 1971 оны конвенцийг зөрчиж аливаа мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисыг **хувийн хэрэгцээнд зориулж санаатайгаар хадгалах, олж авах, тарималжуулахыг** дотоодын хуулийнхаа дагуу гэмт хэрэг гэж тогтооход шаардлагатай байж болох арга хэмжээ авна. Энд заасан “хувийн хэрэгцээнд зориулж санаатайгаар хадгалах, олж авах” үйлдлийг ЭХ-ийн 20.7.1-д “худалдаалах зорилгогүйгээр хууль бусаар хадгалсан, олж авсан” гэмт хэрэг хэмээн тусгажээ. Үүнээс үзэхэд конвенцийн уг зүйлд заасан “хувийн хэрэгцээнд зориулсан байх” нөхцөлийг “худалдаалах зорилгогүйгээр” гэдэгт хамааруулсан гэж үзэж болно. Учир нь хувийн хэрэгцээнд зориулан мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисыг хадгалах, олж авах,

¹³⁵ Мөн тэнд, p.66, para 3.53.

¹³⁶ Мөн тэнд, p.65, para 3.51.

¹³⁷ Commentary on the United Nations Convention against illicit traffic in narcotic drugs and psychotropic substances, 1988, p.73, para 3.68.

https://www.unodc.org/documents/commissions/CND/Int_Drug_Control_Conventions/Commentaries-OfficialRecords/1988Convention/1988_COMMENTARY_en.pdf, [Сүүлд үзсэн: 2022.06.25].

тарималжуулах үйлдлүүд нь конвенцийн 3.1-д заасан гэмт хэргийн төрлүүдтэй харьцуулахад ноцтой шинж нь бага тул энэ нь ялын хэмжээнд нөлөөлнө. Харин ЭХ-ийн холбогдох заалтаас үзэхэд “худалдаалах зорилгогүйгээр” хадгалсан, олж авсан гэмт хэрэгт “худалдаалах зорилготойгоор” хадгалсан, олж авсан гэмт хэргээс бага ял оногдуулж байх тул конвенцид заасан гэмт хэргийн шинжийг дээрх байдлаар тусгасан гэж үзэж байна. Харин тарималжуулах үйлдлийн хувьд, ЭХ-ийн 20.10.1 дүгээр зүйлд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын түүхий эдийг хууль бусаар тариалсан, ургуулсан үйлдлийг гэмт хэрэгт тооцжээ. Гэвч үүнд хувийн хэрэгцээнд зориулж санаатайгаар тарималжуулах гэмт хэргийг тусгаагүй байна.

4. Хамтран оролцогчдод хүлээлгэх хариуцлага

Хамтран оролцогчдод хариуцлага хүлээлгэх асуудлын хүрээнд конвенцийн 3.1.с) iii)-iv) дэх хэсгүүдэд заасан заалтыг тус тус авч үзье. Конвенцийн 3.1.с) iii)-т тусгагдсан “энэ зүйлийн дагуу тогтоосон аливаа гэмт хэргийг үйлдэх, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисыг хууль бусаар хэрэглэхэд олон нийтийг аливаа хэлбэрээр өдөөн хатгах, уриалах” үйлдлийг Монгол Улсын ЭХ-ийн 3.4-т заасан гэмт хэргийн хатгагчид хамааруулж болох юм.

Харин 3.1.с).iv)-д заасан гэмт хэрэгт хамтран оролцогчдыг тусгасан заалтыг авч үзвэл “аливаа гэмт хэргийг үйлдэхэд оролцсон, холбогдсон, үйлдэхээр үгсэн тохиролцсон, үйлдэхийг завдсан, түүнчлэн үйлдэх үед хамжсан, хатгасан, дэмжлэг үзүүлсэн эсхүл зөвлөгөө өгсөн” гэмт үйлдлүүдийг ЭХ-ийн гуравдугаар бүлэг буюу гэмт хэрэгт хамтран оролцогчдод ял оноох тухай зохицуулалтад хамруулсан байна. ЭХ-ийн 3.1.2-т гүйцэтгэгч, зохион байгуулагч, хатгагч, хамжигчийг гэмт хэрэгт хамтран оролцогчид тооцсон учир уг конвенцийн iv)-р зүйлийг бүрэн тусгасан байна хэмээн үзэв. Тодруулбал, конвенцид гэмт хэрэгт хамжсан болон зөвлөгөө өгсөн, дэмжлэг үзүүлсэн гэж тусад нь авч үзсэн байх ч Монгол Улс ЭХ-ийн 3.5 дугаар зүйлд гэмт хэрэг үйлдэхэд дэмжлэг үзүүлсэн хүнийг хамжигчид тооцож байх тул гэмт хэрэгт хамтран оролцогчдыг бүрэн хамруулсан гэж хэлж болох юм.

5. Гэмт хэргийн хүндрүүлэх нөхцөл

Конвенцийн 3.5-д заасан тодорхой нөхцөлүүдийг талууд тэдгээрийн шүүх болон хэргийн харьяалал тогтоосон эрх мэдэл бүхий байгууллагуудаас 1 дэх хэсэгт заасны дагуу тогтоосон гэмт хэргийг үйлдэхэд нөлөөлсөн хүндрүүлэх нөхцөл байдал гэж үзэх явдлыг хангана. Өөрөөр хэлбэл талуудын үүрэг бол тэдний шүүх, эсвэл бусад эрх бүхий байгууллага (жишээлбэл, зарим мужид хар тамхитай холбоотой гэмт хэргийг шийдвэрлэхэд ашигладаг тусгай шүүхүүд байдаг.) ял оноохдоо эдгээр нөхцөл байдлыг харгалзан үзэх боломжтой эсэхийг баталгаажуулах явдал юм.¹³⁸ Энэ заалт нь шүүхийн жишгийг хууль тогтоомжтой адил үздэг нийтлэг эрх зүйн бүлийн орнуудын хувьд заавал хуульчлахгүйгээр хэрэглэгдэх боломжтой. Харин Монгол Улсын хувьд эх газрын эрх зүйн бүлд хамаардаг тул энэхүү заалтыг хэрэгжүүлэхийн тулд зайлшгүй хуульчлах хэрэгтэй юм. Иймд 3.5-д заасан гэмт хэргийн хүндрүүлэх нөхцөлүүдийг тус бүрчлэн авч үзье.

¹³⁸ Commentary on the United Nations Convention against illicit traffic in narcotic drugs and psychotropic substances, 1988, p.90, para 3.115.
https://www.unodc.org/documents/commissions/CND/Int_Drug_Control_Conventions/Commentaries-OfficialRecords/1988Convention/1988_COMMENTARY_en.pdf, [Сүүлд үзсэн:2022.06.25].

а) дахь хэсэгт заасан гэмт этгээд өөрийн харьяалагддаг зохион байгуулалттай гэмт бүлгийн үйлдсэн гэмт хэрэгт оролцсон хэмээн заасныг ЭХ-ийн 3.8.3.-т “Зохион байгуулалттай гэмт бүлгийн гишүүнийг зохион байгуулалттай гэмт бүлэгт элссэн үйлдэлд ба өөрийнх нь үйлдсэн гэмт хэрэгт ял оногдуулна.” гэж ЭХ-ийн 20.7.4 дэх хэсэгт хүндрүүлэх бүрэлдэхүүн болгон мөн тусгасан байна.

Харин тус конвенцийн b) гэмт этгээд ОУ-ын чанартай бусад төрлийн зохион байгуулалттай гэмт үйл ажиллагаанд оролцсон; c) гэмт этгээд тухайн гэмт хэргийг үйлдсэний улмаас хууль бус бусад үйл ажиллагаанд оролцсон; d) гэмт этгээд хүч, эсхүл галт зэвсэг хэрэглэсэн; f) гэмт хэрэг үйлдэхэд насанд хүрээгүй хүмүүсийг татан оролцуулсан, эсхүл тэднийг ашигласан; g) гэмт хэргийг хорих ял эдлүүлэх газар, сургууль, олон нийтийн үйлчилгээний газар эсхүл тэдгээрийн ойр орчинд, эсхүл сурагч, оюутны сургалт, спорт, олон нийтийн үйл ажиллагаа явуулдаг газарт үйлдсэн; h) холбогдох талын дотоодын хуулиар зөвшөөрсөн хэмжээнд гадаад улсад болон эх орондоо урьд нь ял шийтгэгдсэн, ялангуяа ижил төрлийн гэмт хэрэгт ял шийтгэгдсэн хэмээн гэмт хэргийн хүндрүүлэх нөхцөл байдлыг конвенцид дэлгэрэнгүй тусгасан боловч ЭХ-д эдгээр зохицуулалтыг орхигдуулсан байна.

Мөн конвенцийн e) хэсэгт гэмт этгээд албан тушаалтан бөгөөд тухайн гэмт хэрэг нь түүний **албан тушаалтай холбоотой** байхаар заасан. Энэхүү холбоо нь ихэвчлэн албан тушаалын эрх мэдлийг урвуулан ашиглах, эсвэл нөлөөллийн хэлбэрээр явагдах боловч конвенцийн бичвэрт уг холбооны тодорхой хэлбэрийг заагаагүй болно.¹³⁹ Өөрөөр хэлбэл энэ нь гэмт этгээд албан тушаалтан бөгөөд тухайн гэмт хэрэгт түүний албан тушаалын чиг үүрэг **ямар нэгэн байдлаар** холбоотой байхаар өргөн хүрээнд хамруулж ойлгохоор тусгасан. Харин ЭХ-ийн 20.9 дүгээр зүйлд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг албан тушаалтан албаны чиг үүрэг, бүрэн эрх, нөлөөг урвуулан ашиглаж завшсан үйлдлээр хуульчилснаар тухайн гэмт хэргийн зөвхөн нэг шинжийг хуульчилсан гэж үзэхэд хүргэж байна. ЭХ-ийн тус заалт нь мансууруулах эм сэтгэцэд нөлөөт бодис, түүний хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэрэгт тусгай субъектийг эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан зохицуулалт хэдий ч хүрээг нь хязгаарласан заалт болжээ.

Үүний сацуу конвенцийн монгол орчуулгад конвенцийн үндсэн агуулгаас зөрөөтэй байдал үүссэн тохиолдлыг авч үзье. Холбогдох 1961, 1971 оны конвенцуудад “хүнд гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд хорих эсвэл эрх чөлөөг нь хасах бусад шийтгэл зэрэг зохих шийтгэлийг оногдуулна”¹⁴⁰ гэж заасан байдаг. Харин энэхүү 1988 оны конвенцийг хэлэлцэж байх үед талууд эдгээр заалтыг өмнөх бичвэрүүдээс илүү өргөн хүрээнд, мөн бэхжүүлж, тусгахаар шийдсэн нь конвенцийн 3.4 дэх заалт юм. Энэ зүйлийн (а) дэд хэсэгт 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэргийн “хүнд шинж чанарыг” зохих ёсоор тусгасан шийтгэл ногдуулах шаардлагатай байдаг бол хөнгөн шинжтэй тохиолдлуудын хувьд (с) дэд хэсэгт заасан бага хэмжээний шийтгэл оногдуулж болдог. Конвенцийн албан ёсны хувилбаруудад тухайлбал англи хувилбарт:

¹³⁹ Commentary on the United Nations Convention against illicit traffic in narcotic drugs and psychotropic substances, 1988, p92, para 3.120,

https://www.unodc.org/documents/commissions/CND/Int_Drug_Control_Conventions/Commentaries-OfficialRecords/1988Convention/1988_COMMENTARY_en.pdf, [Сүүлд үзсэн: 2022.06.25].

¹⁴⁰ 1961 Convention, art. 36, para. 1; and 1971 Convention, art. 22, para. 1, subpara. (a).

“Each Party shall make the commission of the offences established in accordance with paragraph 1 of this article liable to sanctions which take into account the grave nature of these offences, such as imprisonment or other forms of deprivation of liberty, pecuniary sanctions and confiscation”

гэж зааснаас үзэхэд энэхүү (а) дэд хэсгийн заалт нь 3.4 дэх бусад зохицуулалтуудаас ялгаатай бөгөөд энэ нь талуудад санал болгосон биш “...хариуцлага хүлээлгэнэ.” гэж үүрэг болгосон байдлаар тусгагдсан байна. Харин “Төрийн мэдээлэл” сэтгүүлд нийтлэгдсэн тус конвенцийг монгол хэл дээр орчуулсан хувилбарт “Тал бүр 1 дэх хэсгийн дагуу тогтоосон гэмт хэрэг үйлдсэн этгээдэд тухайн хэргийн ноцтой шинж байдлыг харгалзан хорих, эсхүл бусад хэлбэрээр эрх чөлөөг нь хасах, торгох болон хөрөнгө хураах ял **ногдуулахаар зааж болно.**” гэж тусгагдсан байгаа нь эдгээр ялыг оногдуулахаар заахгүй ч байх боломжтой нөхцөлийг бүрдүүлж байгаа тул конвенцоор хүлээсэн үүргээ бүрэн биелүүлэхэд саад учруулж байна гэж үзэв.

В. Дүгнэлт

Конвенцид 3.1.а).i)-т заасан “үйлдвэрлэх” болон “экспортлох, импортлох” гэмт хэргүүдийг ЭХ-д гэмт хэрэг болгон заагаагүй бөгөөд харин зөрчилд тооцон хуульчилсан байна. 3.1.а).ii)-т заасан “... мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисыг үйлдвэрлэх зорилгоор опиумын намуу, кока бут, каннабис ургамлыг тарималжуулах” гэмт хэргийг өргөжүүлж тусгажээ. Харин 3.1.а).iii)-т заасан гэмт хэргийн хувьд ЭХ-ийн 20.7.1 болон 20.7.2 дугаар зүйлд конвенцийн 3.1.а).i)-т заасан зорилгыг агуулсан байж болох ч мөн зорилгоор “худалдаж авах” үйлдэл ЭХ-д тусгагдаагүй байна.

Конвенцийн 3.1.а).iv)-т заасан гэмт хэргийг хуульд тусгахдаа “түгээх” үйлдлийг мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хувьд мөн үгчлэн хэрэглэж болохоор байтал тийн хуульчлаагүй байна. Харин “мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисыг тарималжуулах, үйлдвэрлэх эсхүл бэлтгэхэд зориулагдсаныг мэдсээр байж” гэсэн зорилгыг мөн тусгаагүй ч, үүнийг ЭХ-д заасан “худалдаалах зорилго”-д хамруулж үзэж болно. Түүнчлэн конвенцийн, дээр дурдсан зүйлд тоног **төхөөрөмж, эд зүйлсийг** бэлтгэх, тээвэрлэх, түгээх үйлдлүүдийг ЭХ-д тусгаагүй байна.

3.1.а)v) дахь хэсгийн хүрээнд “удирдсан” гэх үйлдлийг “зохион байгуулсан” үйлдлээс ялгаж тусгаагүй харин гэмт хэргийг зохион байгуулсан үйлдэл дотроо удирдах үйлдлийг багтааж хуульчилсан байна. Харин конвенцийн 3.1.а)-гийн i-iv-т заасан “санхүүжүүлэх” үйлдлийг тусгаагүйгээрээ конвенцид заасан гэмт хэргийг бүрэн бус тусгасан байна.

Монгол Улс мөнгө угаах гэмт хэргийг ЭХ-ийн 18.6 дугаар зүйлд хуульчилснаар конвенцийн 3.1.b) болон 3.1.c) i) хэсэгт заасан гэмт хэргийн ойлголтуудыг хамруулж хуульчилсан гэж ойлгож болохоор байна. Харин 3.1.c) ii)-т заасан гэмт хэргийг ЭХ-д биш Зөрчлийн тухай хуульд хуульчилсан байх ч 3.1.c).iii болон 3.1.c).iv дэх хэсгүүдэд заасныг гэмт хэрэгт хамтран оролцогчдын хувьд ЭХ-д бүрэн тусгасан байна гэж үзлээ.

Харин конвенцийн 3.2 дугаар зүйлд заасан “хувийн хэрэгцээнд зориулсан байх” нөхцөлийг “худалдаалах зорилгогүйгээр” гэдэгт хамааруулсан гэж үзвэл конвенцид заасан гэмт хэргийн шинжийг хангасан байна. Гэвч конвенцид тусгасан “тарималжуулах” үйлдлийн хувьд ЭХ-ийн 20.10.1 дүгээр зүйлд “Мансууруулах эм,

сэтгэцэд нөлөөт бодисын түүхий эдийг хууль бусаар тариалсан, ургуулсан"-ыг гэмт хэрэгт тооцсон боловч үүнд хувийн хэрэгцээнд зориулж санаатайгаар тарималжуулах гэмт хэргийг тусгаагүй байна.

Хүндрүүлэх бүрэлдэхүүний хувьд Монгол Улс ЭХ-даа мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг конвенцийн 3.5 дугаар зүйлийн а хэсгийг бүрэн тусгасан ч мөн зүйлийн b,c,d,f,g,h хэсэгт заасан гэмт хэргийн нөхцөлүүдийг тусгаагүй бөгөөд харин 3.5.e) буюу өргөн хүрээнд хамруулан ойлгох заалтыг ЭХ-д хамрах хүрээг нь танаж, зөвхөн нэг шинжээр нь хуульчилсан байна. Мөн конвенцийн 3.4.a) хэсэг дэх үүрэг болгосон заалтыг "ял **ногдуулахаар зааж болно.**" гэж талуудад санал болгож буй мэтээр орчуулсан нь конвенцийн холбогдох хэм хэмжээг Монгол Улсад хэрэглэх тохиолдолд уг агуулгаас нь өөрөөр ойлгож хэрэглэх эрсдэлийг үүсгэхээр байна.

Мансууруулах эмийн тухай нэгдсэн конвенц /1961/, Сэтгэцэд нөлөөлөх бодисын тухай конвенц /1971/ болон Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг конвенц /1988/ нь харилцан уялдаатай бөгөөд сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг хянах эрх зүйн орчин, механизмыг бүрдүүлсэн ОУ-ын үндсэн гэрээ хэлэлцээрүүд юм. Мансууруулах эмийн тухай нэгдсэн конвенц болон Сэтгэцэд нөлөөлөх бодисын тухай конвенцийн гол зорилго нь мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодисыг анагаах ухаан болон эрдэм шинжилгээний зорилгоор хэрэглэхийг хорихгүйгээр, харин тус бодисуудтай холбоотой хууль бус үйлдлүүдийг таслан зогсоох болон урьдчилан сэргийлэхэд чиглэсэн болно. Харин Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг конвенц нь өмнөх хоёр конвенцийн нэмэлт хэрэгсэл юм.

Ерөнхий дүгнэлт

Монгол Улсын Үндсэн хуульд заасан, ОУ-ын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлэх зарчмын дагуу ОУ-ын эрх зүйг дотоодын эрх зүйд нутагшуулах, ОУ-ын эрх зүйн хэм хэмжээг амьдралд нэвтрүүлэх, хэрэгжүүлэх ажлыг орхигдуулах ёсгүй. Үүний нэг чиглэл нь Монгол Улсын ОУ-ын гэрээнд дотоодын хууль тогтоомжийг нийцүүлэх ажиллагаа юм.

Монгол Улсын хувьд ОУ-ын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчлэх ба гэрээнээс үүсэх үүргийг ёсчлон биелүүлэх талаар Үндсэн хуульд заасны дагуу ихэнх хуульд "Монгол Улсын ОУ-ын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол ОУ-ын гэрээний заалтыг дагаж мөрдөнө" гэсэн заалт бий. Гэвч зарим төрлийн ОУ-ын гэрээний хувьд тухайн гэрээг соёрхон батлах тухай хууль батлахдаа холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, эсхүл тухайн харилцааг зохицуулсан хууль байхгүй бол шинээр батлах шаардлага тулгардаг. Энэ байдал хүний эрхийн холбогдолтой, эрүүгийн гэмт хэргийн эсрэг ОУ-ын гэрээний төрөлд илүүтэй хөндөгддөг. Өөрөөр хэлбэл, Монгол Улсын ОУ-ын гэрээнд гэмт хэрэг гэж заасан үйлдлүүдийг ЭХ-даа тусгасан байх үүрэгтэй.

Энэхүү судалгаагаар, Монгол Улсын ОУ-ын гэрээнд заасан зарим төрлийн гэмт хэргийн ойлголт, үндсэн шинж, эрүүгийн хариуцлагатай холбоотой хэм хэмжээг ЭХ-д

тусгасан байдлыг судалж, нийцлийг дүгнэн, зөрчлийг тодруулж, ЭХ-ийн холбогдох зохицуулалтыг боловсронгуй болгоход чиглэсэн санал, зөвлөмж дэвшүүлэв.

Хүчээр алга болгохоос бүх хүнийг хамгаалах тухай ОУ-ын конвенц, Агаарын хөлгийн бүхээгт үйлдсэн гэмт хэрэг болон тодорхой бусад үйлдлийн тухай Токиогийн конвенц, Агаарын хөлгийг хууль бусаар булаан авах үйлдлийг хориглох тухай Гаагийн конвенц, Иргэний нисэхийн аюулгүй байдлын эсрэг хууль бус үйлдлийг хориглох тухай Монреалийн конвенц болон тус конвенцийн нэмэлт протокол, Мансууруулах эмийн тухай нэгдсэн конвенц, Сэтгэцэд нөлөөлөх бодисын тухай конвенц, Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг НҮБ-ын конвенцийн холбогдох хэм хэмжээг ЭХ-д тусгасан байдлыг харьцуулж, нийцлийг дүгнэв.

Ингэхдээ, энэхүү судалгааны хүрээнд боловсруулж ашигласан шалгуур үзүүлэлтээр, судалгаанд хамрагдсан 8 ОУ-ын гэрээ ба ЭХ-ийн нийцлийг тайлангийн бүлэг тус бүрийн төгсгөлд хэсгийн дүгнэлт хийснийг үзнэ үү.

Ерөнхийд нь дүгнэвэл:

Судалгаанд хамрагдсан Монгол Улсын ОУ-ын гэрээгээр зохицуулсан, хүчээр алга болгохоос бүх хүнийг хамгаалах; иргэний нисэхийн аюулгүй байдлыг хангах; мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх чиглэлийн эсрэг гэмт хэргийн төрлүүдийг ЭХ-д ерөнхийдөө тусгасан байна. Ингэхдээ гэмт хэрэгт хамтран оролцох, хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх, шийтгэхээс бусад арга хэмжээ авах, урамшууллын аргыг ашигласан зохицуулалт тусгасан зэрэг сайн талыг дурдах нь зүйтэй. Гэвч судалгааны дүнд, ОУ-ын гэрээ ба ЭХ-ийн нийцлийн хувьд хангалтгүй дараах нийтлэг тал байгааг тодруулсан.

Монгол Улсын ОУ-ын гэрээний хэм хэмжээг ЭХ-д тусгасан (тусгасан:бүрэн, бүрэн бус, өргөжүүлсэн, зөрчилтэй, эсхүл огт тусгаагүй гэх мэт) байдал жигд бус, хангалттай хэмжээнд гэж үнэлэгдсэнгүй. Тухайлбал, ОУ-ын гэрээнд гэмт хэрэгт тооцохоор тоочиж заасан зарим гэмт үйлдлийг хооронд нь нэгтгэх байдлаар орхигдуулсан хандлага мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлттэй холбоотой ОУ-ын гэрээнүүдэд илүүтэй ажиглагдав. Мансууруулах эмийн тухай нэгдсэн конвенцид гэмт хэрэгт тооцохоор нэрлэж тоочсон нийт үйлдлээс “үйлдвэрлэх”, “санал болгох, худалдахаар санал болгох”, “түгээх”, “аливаа нөхцөлөөр хүргүүлэх”, “зуучлах”, “дамжин өнгөрүүлж илгээх”, “импортлох болон экспортлох” зэргийг ЭХ-д хуульчлаагүй.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг НҮБ-ын конвенцийн 3.1.а).i)-т заасан гэмт хэргийн “түгээх” үйлдлийг ЭХ-д үгчлэн тусгаагүй. Үүнийг ЭХ-ийн 20.7.1, болон 20.7.2 дугаар зүйлд тус тус заасан “бусдад өгсөн”, “илгээсэн” зэрэг үйлдлүүдээр илэрхийлсэн гэж үзэж болох юм. Гэхдээ ЭХ-ийн 20.12, 20.14 дүгээр зүйлд заасан зэрэг бусад төрлийн гэмт хэргүүдэд “түгээх” үйлдлийг үгчилж хуульчилсан практик байгаа тул мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хувьд мөн “түгээх” үйлдлийг тусгах боломжтой гэж үзэж байна. Мөн ЭХ-д конвенцийн тус зүйлд заасан “бэлтгэх” болон “бэлдэх” үйлдлүүдийн ялгааг гаргаж хуульчлаагүй зөвхөн бэлтгэх үйлдлийг тусгасан байгааг дурдаж болно.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодис, тэдгээрийн хууль бус эргэлттэй холбоотой ОУ-ын гэрээ ба дотоодын хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар судалсан ажлын үр дүн нэлээд байна. Энэ нь ийм төрлийн гэмт хэрэг манай улсад сүүлийн үед нэлээд гарч, гадаад улсад ч манай улсын иргэд ийм төрлийн гэмт хэрэгт холбогдох нь ихэссэнтэй холбоотой байх талтай.

Монгол Улсын ОУ-ын гэрээнд заасан гэмт хэргийн тодорхойлолт, шинж, эрүүгийн хариуцлагатай холбоотой хэм хэмжээнд ЭХ-ийг нийцүүлсэн байдал жигд бус байна. Тухайлбал, зарим гэмт хэргийг тодорхойлогч шинжүүдийг дутуу тусгасан. Жишээлбэл, Агаарын хөлөг авч зугтаах гэмт хэргийг ЭХ-д тусгасан боловч хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх, эсхүл бусад хэлбэрээр айлган сүрдүүлсэн байх зэрэг шинжийг тодорхойлоогүй бөгөөд гэмт хэргийн “нислэг үйлдэж буй агаарын хөлгийн бүхээгт үйлдэгдсэн байх” шинжийг гэмт хэргийн үйлдэл болгон тусгасан нь тухайн гэмт хэргийн шинжийг бүрэн тусгаж чадаагүй бөгөөд зөрчилтэй тусгасанд тооцогдоно.

Түүнчлэн Агаарын хөлөг, нисэхийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэгтэй холбоотой конвенцуудаар нийтлэг хамгаалах эрх ашиг нь агаарын хөлгийн буюу нислэгийн аюулгүй байдал байдаг. Харин Монгол Улс энэхүү онцлогийг холбогдох гэмт хэргүүдийн хувьд авч үзээгүй, хуульчлан тусгаагүй байгаа нь дутагдалтай юм. Ялангуяа нисэхийн аюулгүй байдалтай холбоотой конвенцид хүнд гэмт хэрэгт тооцсон гэмт хэргийн төрлүүдийг ЭХ-д хөнгөн гэмт хэрэгт тооцогдохоор хуульчлагдсан. Жишээлбэл, ЭХ-д заасан гэмт хэрэгт агаарын хөлгийг устгасан, гэмтээсэн байх шинжийг тусгасан байх боловч агаарын хөлгийн “нислэгийн үе”-д болон “ашиглалтад байх” үед үйлдэгдсэн байх шинжийг орхигдуулсан байна.

Эдгээрээс үзэхэд, ЭХ-д конвенцид заасан гэмт хэрэгтэй холбоотой хэм хэмжээг оновчгүй тусгаснаас гадна оногдуулах ялын хэмжээ нь ч мөн адил тохирохгүй буюу конвенцийн дагуу хүнд гэмт хэрэгт тооцсон гэмт хэрэгт ЭХ-аар хөнгөн гэмт хэрэгт тооцогдох ял оногдуулсан, зарим гэмт хэрэгт бүр хорих ял ч оноогоогүй байна. Эдгээр гэмт хэрэг нь террорист үйлдлүүдийн нэг хэлбэр учраас конвенцид зааснаар гэмт хэргийн төрлийг тодорхойлж, ялын хэмжээг чангатгах нь зүйтэй. Ингэснээр холбогдох гэмт хэргүүдийг үйлдэхээр завдсан болон хамтран оролцсон этгээдүүдэд ч мөн адил хариуцлага тооцож, ОУ-ын гэрээ ба ЭХ-ийн нийцлийг хангах боломж бүрдэнэ.

Ер нь нисэхийн аюулгүй байдалтай холбоотой ОУ-ын гэрээний судлагдсан байдал хомс байгаа нь тухайн харилцаатай холбоотой гэмт хэрэг манай улсын хэмжээнд гараагүй, ялангуяа шүүхийн практикт гараагүй тохиолдол учраас энэ талын судалгаа, эрх зүйн зохицуулалтын хөгжил сул байгаа болов уу. Гэвч ОУ-ын гэрээ ба дотоодын хууль тогтоомжийн нийцлийг сайжруулах замаар тухайн төрлийн гэмт хэргийн нийгэмд аюултай шинжийг харгалзан сайтар хуульчлах нь зүйтэй.

Мөн конвенцид заасан гэмт хэргийн зарим хамтран оролцогчдод хариуцлага хүлээлгэлгүй орхигдуулсан. Тухайлбал, Хүчээр алга болгохоос бүх хүнийг хамгаалах тухай ОУ-ын конвенцийн дагуу оролцогч улс бүр энэ төрлийн гэмт хэрэг үйлдсэн этгээдүүдэд эрүүгийн хариуцлага оногдуулах зорилгоор шаардлагатай арга хэмжээ авах ёстой. Харин эрх бүхий субъектийн удирдлага, харьяан дор байдаг этгээд хүнийг хүчээр алга болгох гэмт хэрэг үйлдсэнийг тухайн эрх бүхий субъект мэдсэн ч нуун далдалсныг ЭХ-д гэмт хэрэгт хамтран оролцсон этгээдэд тооцоогүй тул гэмт этгээд шийтгүүлэхгүй өнгөрөхөөр байна.

Монгол Улс НҮБ-ийн Хүчээр алга болгохоос бүх хүнийг хамгаалах асуудал эрхэлсэн хорооноос өгсөн зөвлөмжийн дагуу, ЭХ-ийн 13.4 дүгээр зүйлд заасан Хүнийг хүчээр алга болгох гэмт хэргийн зохицуулалтад өөрчлөлт оруулахаар ЭХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгасан боловч тухайн конвенцид заасан гэмт хэргийн шинж, хүлээлгэх эрүүгийн хариуцлагын хүрээнд бүрнээ нийцүүлэх нөхцөлийг бүрдүүлээгүй хэвээр байгааг анхаарах шаардлагатай. Энэ нь хууль тогтоомжийн төслийг боловсруулахдаа Монгол Улсын ОУ-ын гэрээнд нийцүүлэхтэй холбоотой Хууль тогтоомжийн тухай хуульд заасан арга зүйн шаардлагыг хангах байдал ерөнхийдөө хангалтгүй хэвээр байгаагийн нэг илрэл юм.

Энэхүү судалгааны зорилго нь Монгол Улсын ОУ-ын гэрээ ба ЭХ-ийн нийцлийг тодруулж, ЭХ-ийг боловсронгуй болгоход зорьсон хэдий ч ЭХ-аас бусад холбогдох хууль тогтоомжийн уялдаа холбоо, нийцэл нь зөрчилтэй тохиолдлууд мөн ажиглагдсаныг дурдах нь зүйтэй. Тухайлбал, Иргэний нисэхийн ерөнхий газраас гаргасан Иргэний нисэхийн дүрмийн 2020 оны өөрчлөлт орсон нэр томъёоны тайлбар дахь Нислэгийн аюулгүй байдал / Flight safety-ын талаар тайлбарласан тайлбар нь Иргэний нисэхийн тухай хуульд “нисэхийн аюулгүй ажиллагаа” гэдгийг илэрхийлж харин “нисэхийн аюулгүй байдал” гэдэгт нисэхийг хөндлөнгийн хууль бус үйлдлээс хамгаалахтай холбогдсон цогцолбор арга хэмжээг хэлэхээр заасан. Харин дээрх хуульд заасан “нисэхийн аюулгүй байдал” гэдэг нь “нисэхийн аюулгүй хамгаалалт” (air security/ aviation security)-ыг илэрхийлэх ойлголт бөгөөд нисэхийн аюулгүй байдал (air safety/ aviation safety)-аас агуулгын хувьд ялгаатай юм.Иймд энэ чиглэлээр гүнзгийрүүлэн судалж, дотоодын хууль тогтоомж хоорондын нийцлийг мөн хангах хэрэгцээ, шаардлага байсаар байна.

ЭХ-ийн холбогдох заалт хэл зүйн болон найруулгын шаардлага (нэр томъёо, үг хэллэг) хангаж Монгол Улсын ОУ-ын гэрээтэй уялдсан эсэх шалгуур үзүүлэлтийн дагуу дүн шинжилгээ хийхэд, “Төрийн мэдээлэл” сэтгүүлд нийтлэгдсэн болон эрх зүйн мэдээллийн цахим санд байршсан Монгол Улсын ОУ-ын гэрээний орчуулга нь конвенцийн англи хэл дээрх агуулгаас зөрүүтэй(“... хорих, эсхүл бусад хэлбэрээр эрх чөлөөг нь хасах, торгох болон хөрөнгө хураах ял оногдуулна.” гэсэн агуулгыг “... хорих, эсхүл бусад хэлбэрээр эрх чөлөөг нь хасах, торгох болон хөрөнгө хураах ял ногдуулахаар зааж болно.” гэж), эсхүл нэг нэр томъёо, үг хэллэгийг өөр өөрөөр орчуулж хэрэглэх(“destroy” гэсэн англи үгийг конвенцийн орчуулгад агаарын хөлгийг бүр мөсөн эвдсэн гэж, харин тус конвенцийн нэмэлт протоколын орчуулгад агаарын хөлгийг эвдсэн гэж өөр өөр орчуулсан), тэр байтугай монгол хэл дээр нэг үгийг өөр өөр хэлбэрээр бичсэн байдал(конвенц гэдэг үгийг хоёр өөр янзаар бичсэн)илэрсэн. Ингэснээр ОУ-ын гэрээний хэрэглээ хязгаарлагдаж, цаашлаад шүүхийн практикт хүндрэл, бэрхшээл үүсгэж болзошгүй юм.

Утга, агуулгын хувьд зөрчилтэй байдал судалгааны дүнд мөн илэрч байв. Тухайлбал, Иргэний нисэхийн аюулгүй байдлын эсрэг хууль бус үйлдлийг хориглох тухай Монреалийн конвенцийн 1 дүгээр зүйлд заасан гэмт хэргийг ЭХ-д тусгахдаа “хүчирхийлсэн үйлдэл”-ийг “зүй бусаар харилцсан” гэж өргөн агуулгаар тусгасан нь зөрчил үүсгэжээ. Мөн конвенцид тусгасан агаарын хөлгийн аюулгүй байдалд халдсан байх шинжийг өөр үйлдлээр илэрхийлснээр конвенцид заасан гэмт хэргийн агуулгаас зөрүүтэй болсон.

Иймд ЭХ-ийн холбогдох зохицуулалт хэл зүйн болон найруулгын шаардлага (нэр томьёо, үг хэллэг) -ын хувьд ОУ-ын гэрээтэй уялдсан байдал харилцан адилгүй гэж дүгнэхэд хүрэв. Энэ нь тухайн ОУ-ын гэрээний монгол хэл дээрх орчуулгын алдаа, дутагдлаас үүссэн байдал анзаарагдсан. Конвенцид заасан зарим нэр томьёог оновчгүй орчуулах, үг хэллэгийг алдаатай буулгасан тохиолдлууд ОУ-ын гэрээнүүдэд нийтлэг ажиглагдаж байгааг судалгааны холбогдох хэсгүүдээс үзэх боломжтой.

Судалгаанд хамрагдсан 8 гэрээний, судлахаар сонгосон хүрээнд холбогдох 46 хэм хэмжээг ЭХ-д тусгасан байдлыг судалж, дүн шинжилгээ хийлээ.¹⁴¹ Нийцлийн хувьд тоон үзүүлэлтээр авч үзвэл:

- бүрэн тусгасан 14
- бүрэн бус тусгасан 15
- өргөжүүлж тусгасан 3
- зөрчилтэй тусгасан 5
- огт тусгаагүй 19 байна¹⁴².

Монгол Улсын ОУ-ын гэрээнд заасан гэмт хэргийг ЭХ-д тусгасан (огт тусгаагүй, бүрэн, бүрэн бус, өргөжүүлсэн, огт тусгаагүй гэх мэт) байдлыг хувьчлан авч үзвэл:

Судалгаанд хамрагдсан 8 гэрээний харьцуулан судлагдсан 46 хэм хэмжээний 14 буюу 30.4 % нь бүрэн тусгагдсан; 15 буюу 32.6 % нь бүрэн бус тусгагдсан, 5 буюу 10.9 % нь зөрчилтэй тусгасан, 3 буюу 6.5% нь өргөжүүлж тусгасан байдалтай; 19 буюу 41.3% нь ЭХ-д огт тусгагдаагүй байна. Энэ нь Монгол Улсын ОУ-ын гэрээ ба ЭХ-ийн нийцэл хангалтгүй байгааг илэрхийлнэ.

Хууль тогтоомжийн тухай хууль, түүний хүрээнд батлагдсан аргачлалуудын дагуу дотоодын хууль тогтоомж боловсруулахдаа Үндсэн хуульд нийцэж буй эсэхийг нягтлахаас гадна Монгол Улсын ОУ-ын гэрээ болон бусад хууль тогтоомжтой нийцэж буйг судалж тодруулах ёстой. Гэтэл судалгаанд хамрагдсан, Монгол Улсын ОУ-ын гэрээнд заасан хэм хэмжээ ба ЭХ-ийн нийцэл хангалттай бус байна. Энэ нь Хууль тогтоомжийн тухай хууль батлагдаж хэрэгжихээс өмнө 2015 оны ЭХ батлагдсантай холбоотой байх магадлалтай. Иймээс дээрх үүргээ бүрэн хэрэгжүүлэх зорилгын дор ЭХ-ийг олон улсын гэрээнд нийцүүлж боловсронгуй болгох шаардлагатай. Ингэснээр зөрчилдөөнгүй болохын зэрэгцээ гэрээгээр хүлээсэн үүргээ үр дүнтэй биелүүлэх эрх зүйн үндэс бүрдэнэ.

Санал, зөвлөмж

Судалгааны үр дүнд, ЭХ-ийн холбогдох зохицуулалтыг Монгол Улсын ОУ-ын гэрээнд нийцүүлэхэд чиглэсэн саналуудаас 30 саналыг түүвэрлэж, 1 ерөнхий зөвлөмж дэвшүүлэв.

Санал:

¹⁴¹ Үүнийг Хавсралт 2 хүснэгтээс дэлгэрүүлж үзнэ үү.

¹⁴² Зарим хэм хэмжээний хувьд тоон үзүүлэлт давхардсан болно.

1) Хүчээр алга болгохоос бүх хүнийг хамгаалах тухай ОУ-ын конвенцийн хүрээнд:

- a. Хүнийг хүчээр алга болгох гэмт үйлдэл нь зөвхөн “хууль бусаар” эрх чөлөөг нь хассан тохиолдлуудаар хязгаарлагдахаар ЭХ-д заасныг өөрчилж, “өөр бусад хэлбэрээр” эрх хассан үйлдлүүдийг хамруулж, конвенцид нийцүүлэх
- b. ЭХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд заасан үндэсний аюулгүй байдлыг хангах тусгай чиг үүрэг бүхий байгууллагын удирдах болон гүйцэтгэх албан тушаалтан, прокурор, шүүгчээс гадна төрийн шууд болон шууд бус дэмжлэг авсан этгээдүүдийг, хүнийг хүчээр алга болгох гэмт хэргийг хамтран гүйцэтгэгч субъектэд нэмэх;
- c. ЭХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 29.12 дугаар зүйлээс 13.17 болон 13.9 дүгээр зүйлд заасан гэмт хэргийн заагийг субъектийн хувьд гаргах;
- d. Иргэний хуульд “оршин суугаа газар” гэж хуулийн дагуу иргэн харьяаллаа бүртгүүлсэн газрыг тодорхойлсон бол конвенцийн “whereabouts” үгийг “оршин суугаа газар” гэсэн үгээр орчуулсныг тухайн хүний “байгаа газар” гэсэн агуулгаар өөрчлөх;
- e. Конвенцид заасан гэмт хэргийн “хүнийг хуулийн хамгаалалт эдэлж чадахааргүй байдалд хүргэхүйц байх” гэсэн шинжийг нэмж тусгах;
- f. Конвенц бусдын хууль ёсны эрх, ашиг сонирхолд хохирол, хор уршиг учруулсан байхыг заавал шаардаагүй бөгөөд энэ нь гэмт хэргийн агуулгыг хумьж байгаа тул энэ шинжийг ЭХ-д тодорхойлсон хүнийг хүчээр алга болгох гэмт хэргийн шинжээс хасах;
- g. Үндсэн гэмт хэрэгт ногдуулах ялыг нэмэгдүүлж, хөнгөн гэмт хэргүүдээс ялгамжтай зохицуулах;
- h. Гэмт хэрэгт хамтран оролцогч, эрүүгийн хариуцлага хүлээх субъектүүдийг өргөжүүлэх нь зүйтэй гэсэн саналууд багтаж байна.

2) Агаарын хөлгийн бүхээгт үйлдсэн гэмт хэрэг болон тодорхой бусад үйлдлийн тухай конвенцийн хүрээнд:

- Тухайлсан саналгүй болно.

3) Агаарын хөлгийг хууль бусаар булаан авах үйлдлийг хориглох тухай конвенцийн хүрээнд:

- a. Хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх, эсхүл бусад хэлбэрээр айлган сүрдүүлсэн байх шинжийг ЭХ-ийн 27.8 дугаар зүйл болох Агаарын хөлгийг авч зугтаах зорилгоор эзлэн авсан, нислэг үйлдсэн гэмт хэрэгт нэмж тусгах;
- b. Энэхүү конвенц зөвхөн иргэний агаарын хөлөгт хамаарах бөгөөд цэрэг, гааль, цагдаагийн үйлчилгээнд ашигладаг агаарын хөлөгт хамаарахгүй тухай тайлбарыг ЭХ-д нэмж тусгах;
- c. ЭХ-ийн 27.4 дүгээр зүйлд заасны дагуу, агаарын хөлгийн нислэг үйлдэж байх шинжийг ЭХ-д нэмж тусгах, ингэхдээ ОУ-ын гэрээнд заасан гэмт хэргийн уг шинжийг агуулсан төрөл тус бүрээр нь нэмэх;
- d. ЭХ-ийн 27.8 дугаар зүйлд заасан “агаарын хөлөг авч зугтаах зорилго”-ыг хасаж, гэмт хэргийг нарийвчлан тодорхойлж, бусад төрлийн гэмт хэргээс ялгамжтай зохицуулах шаардлагатай гэсэн саналууд багтаж байна.

4) Иргэний нисэхийн аюулгүй байдлын эсрэг хууль бус үйлдлийг хориглох тухай Монреалийн конвенцийн хүрээнд:

- a. Конвенцид заасан хүчирхийлсэн үйлдлийг агуулгаар нь тодотгон тусгаж, ЭХ-ийн 27.4.2 дахь хэсэгт заасан “зүй бусаар харилцсан” үйлдлийн оронд хуульчлах;
- b. Монгол хэл рүү хөрвүүлж хуульчлахдаа хүч хэрэглэсэн болон хүчирхийлсэн үйлдлүүдийг ялгаж буулгах нь зүйтэй.
- c. Монгол Улсын ЭХ-д “агаарын хөлгийн аюулгүй байдал”-д аюул учруулах ойлголтыг конвенцид заасан гэмт хэрэг бүрээр нэмж, аюулгүй ажиллагаа, аюулгүй байдал, аюулгүй хамгаалалт зэрэг ойлголтуудыг цэгцлэх;
- d. Хуулийн дотоод уялдаа холбоог хангаж 27.4.2 болон 27.1 дүгээр зүйлд заасан хүний эрүүл мэнд, амь нас, бусдын эд хөрөнгөд хохирол учрах эсхүл хүний эрүүл мэнд, амь насанд аюул учир ч, эд хөрөнгөд хохирол учрах ойлголтуудын хэрэглээг нэгтгэж хуулийн нэг мөр байдлыг сахих нь зүйтэй.
- e. Цэрэг, гааль, цагдаагийн үйлчилгээнд ашигладаг агаарын хөлгөөс ялгаж, ашиглалтад байгаа болон нислэг үйлдэж байгаа агаарын хөлгийг холбогдох гэмт хэргийн тайлбарт тусгах;
- f. ЭХ-ийн заалтуудыг өөрчлөн найруулж конвенцид тодорхойлсон гэмт хэргийн агуулгатай бүрнээ нийцүүлэх, Монреалийн конвенцид заасан гэмт хэргийн ноцтой шинжийг харгалзаж ялын хэмжээг чангатгах.

5) Монреалийн конвенцийн Нэмэлт протоколын хүрээнд:

- Протоколд тусгагдсан гэмт хэргүүдийг ЭХ-ийн холбогдох бүлэгт тухайлан оруулах.

6) Мансууруулах эмийн тухай нэгдсэн конвенцийн хүрээнд:

- a. Мансууруулах эмийн тухай нэгдсэн конвенцид заасны дагуу гэмт хэрэгт тооцогдох зарим үйлдлийг ЭХ-д нэгтгэх байдлаар тусгасан байгааг анхаарч, зарим зайлшгүй тусгах шаардлагатай үйлдлийг ЭХ-д гэмт хэрэгт нэг бүрчлэн тооцож хуульчлах;
- b. Тус конвенцид заасны дагуу гэмт хэрэгт тооцогдох үйлдлийг Зөрчлийн тухай хуульд тусгаж зөрчилд тооцож буй байдлыг нялталж, шийдвэрлэх.

7) Сэтгэцэд нөлөөлөх бодисын тухай конвенцийн хүрээнд:

- a. Тус конвенцид гэмт хэрэгт тооцохоор заасан “санхүүгийн үйл ажиллагаа явуулах” үйлдлийг ЭХ-д тусгах шаардлагатай эсэхийг судалж тодруулах;
- b. Тус конвенцийн 22 дугаар зүйлийн 3-т “ 1, 2 дахь хэсэгт дурдсан гэмт хэргийг үйлдэхэд ашигласан, эсхүл зориулагдсан сэтгэцэд нөлөөлөх аливаа бодис, эсхүл өөр бодис, түүнчлэн аливаа тоног төхөөрөмжийг түр хураах буюу бүрмөсөн хураана.” гэж заасныг үндэслэн холбогдох гэмт хэрэгт хөрөнгө хураах ялыг хамтад нь хэрэглэхээр ЭХ-д тусгах.

8) Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг НҮБ-ын конвенцийн хүрээнд:

- a. Конвенцийн 3.1.a.i) дэх хэсгийн дагуу “үйлдвэрлэх” болон “экспортлох, импортлох” гэмт хэргүүдийг ЭХ-д хуульчлах;

- b. 3.1.а).iii)-т заасан “худалдаж авах”, мөн 3.1.а).iv) дэх хэсэгт дурдсан “түгээх” болон “тоног төхөөрөмж, эд зүйлсийг бэлтгэх, тээвэрлэх, түгээх” үйлдлүүдийг ЭХ-д тусгах;
- c. 3.1.а)v) дахь хэсгийн хүрээнд “удирдсан” гэх үйлдлийг “зохион байгуулсан” үйлдлээс ялгаж хуульчлах, мөн “санхүүжүүлэх” гэмт хэргийг нэмж тусгах;
- d. 3.2 дугаар зүйлд заасны дагуу хувийн хэрэгцээнд зориулж санаатайгаар тарималжуулах үйлдлийг гэмт хэрэгт тооцох;
- e. 3.5 дугаар зүйлийн b,c,d,f,g,h хэсэгт заасан гэмт хэргийн төрлүүдийг ЭХ-д хүндрүүлэх бүрэлдэхүүнтэй тусгах хэрэгцээ, шаардлагатай бөгөөд гэмт хэргүүдийг ЭХ-д тусгахдаа конвенцид бүрэн нийцүүлж тусгах;
- f. 3.5.e хэсэгт заасны дагуу тусгай субъектийн үйлдсэн холбогдох гэмт хэргийн хүрээг өргөжүүлж хуульчлах;
- g. Конвенцийн 3.4 дэх хэсгийн орчуулгад “ял ногдуулахаар зааж болно” гэснийг “ял оногдуулна” гэж өөрчлөн найруулах замаар конвенцийн агуулгад нийцүүлэх.

Зөвлөмж

Цаашид хууль тогтоомжийг ОУ-ын гэрээнд нийцүүлэх аргачилсан удирдамж, аргачлал боловсруулж мөрдүүлэх; ОУ-ын гэрээ ба үндэсний хууль тогтоомжийн нийцлийн судалгаа хийсний үндсэн дээр үр дүнг хэлэлцэж зөвлөлдөх, шийдвэрлэхтэй холбоотой механизмыг бүрдүүлэх; Хууль тогтоомжийн тухай хууль ба тус хуулийн дагуу батлагдах аргачлалуудын хүрээнд үндэсний хууль тогтоомжийг ОУ-ын гэрээнд нийцүүлэх чиглэлийн судалгаа, тооцоог хийх арга зүй, хүний нөөцийн чадавх, хүртээмж, төсөв санхүүгийн асуудлыг хангалттай шийдвэрлэх; ОУ-ын гэрээ ба үндэсний хууль тогтоомжийн нийцлийг хангах асуудлыг ажил үүрэгт тухайлан тусгах гэсэн саналуудыг ажил хэрэг болгож, ОУ-ын гэрээнд үндэсний хууль тогтоомжийг нийцүүлэх¹⁴³ ажлыг шинэ шатанд гаргах нь зүйтэй.

Түүнчлэн Монгол Улсын ОУ-ын гэрээний албан ёсны орчуулгыг нягталж сайжруулах хэрэгцээ хангагдаагүй хэвээр байгааг анхаарах шаардлагатай. Орчуулгын чанарыг сайжруулснаар үндэсний хууль тогтоомжийг тухайн ОУ-ын гэрээнд нийцүүлэхээс гадна ОУ-ын гэрээг шүүхэд хэрэглэх зэрэг бусад холбогдох харилцаанд эерэг нөлөө үзүүлнэ.

¹⁴³ ХЗҮХ, Эрх зүйн шинэтгэлийн бодлогын баримт бичиг боловсруулахад дэмжлэг үзүүлэх нь судалгааны Хавсралт тайлан 1, 2016, 309 дэх тал.

Ном зүй

Олон улсын гэрээ

1. Rome Statute of the International Criminal Court, 17 July 1998, in force on 1 July 2002, United Nations, Treaty Series, vol. 2187, No. 38544,
2. International Convention for the Protection of All Persons from Enforced Disappearance adopted 23 December 2010 by General Assembly of the United Nations in its resolution 47/133
3. Convention on Offences and Certain Other Acts Committed on Board Aircraft 1963, ('Tokyo Convention')
4. Convention for the Suppression of Unlawful Seizure of Aircraft 1970, ('Hague convention')
5. Convention for The Suppression Of Unlawful Acts Against The Safety Of Civil Aviation 1971, ('Montreal Convention')
6. Protocol for the suppression of unlawful acts of violence at airports serving international civil aviation 1988, ('Montreal Protocol')
7. International Convention for the Suppression of Act of Nuclear Terrorism, 2005
8. International Convention for the Suppression of Terrorist Bombings, 1997
9. Convention for the Suppression of Unlawful Acts against the Safety of Maritime Navigation, 2005
10. The Convention on Narcotic Drugs, 1961
11. Convention on Psychotropic Substances, 1971
12. United Nations Convention Against Illicit Traffic in Narcotic Drugs and Psychotropic Substances, 1988

Хууль тогтоомж

1. Монгол Улсын Үндсэн хууль, 1992 он
2. Эрүүгийн хууль, 2002 он
3. Эрүүгийн хууль, 2015 он
4. Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн танилцуулга, 2022 он
5. Иргэний нисэхийн тухай хууль, 1999 он
6. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль, 2002 он
7. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль, 2015 он
8. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, 2015 он
9. Улсын Дээд Шүүхийн Монгол Улсын олон улсын гэрээ болон олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг шүүхийн практикт хэрэглэх тухай тогтоол, 2008 оны 2 дугаар сарын 28, №09
10. Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дугаар тогтоолын хавсралт

11. Иргэний нисэхийн аюулгүй байдлын журам, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 136 дугаар тогтоолын хавсралт
12. Иргэний нисэхийн дүрмийн нэр томъёоны тайлбар, 2020 он
13. U.S. Code, Title 49, SUBTITLE VII, PART A, subpart iv, CHAPTER 465
14. German Criminal Code in the version published on 13 November 1998 (Federal Law Gazette I, p. 3322), as last amended by Article 2 of the Act of 19 June 2019 (Federal Law Gazette I, p. 844)
15. The Suppression of Unlawful Acts Against Safety Of Civil Aviation Act, 1982, Act No. 66 Of 1982 (India)
16. Aviation Crimes Act 1972, Public Act 1972 No 137, Version as at 28 October 2021 (New Zealand)

Дотоод эх сурвалж

Ном, сурах бичиг

1. Монгол Улсын дээд шүүх, Ханнс-Зайделийн сангийн Монгол дахь төлөөлөгчийн газар, *Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар*, УБ, 2013.
2. С. Нарангэрэл, *Эрх зүйн эх толь бичиг*, УБ, 2007.
3. ХЗДХЯ, Эрүүгийн хуулийн шинэчлэсэн найруулга (*Сурагч багш нарт зориулсан гарын авлага*), УБ, 2017.
4. Т. Золбоо, *Сургалтын Эрүүгийн хууль, Эрүү, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль /шинэчилсэн найруулга/* УБ, 2020.
5. С. Гантулга, Б. Энхболд, Эрүүгийн эрх зүйн тусгай анги (сурах бичиг), УБ, 2018.

Судалгааны өгүүлэл, эмхэтгэл

1. ХЗҮХ, *Судалгааны тайлангийн эмхэтгэл (2003-2009)* I боть, УБ, 2012.
2. ХЗҮХ, *Судалгааны тайлангийн эмхэтгэл (2014-2015)* IV боть, УБ, 2017.
3. ХЗҮХ, *Судалгааны тайлангийн эмхэтгэл (2016-2017)* V боть, УБ, 2018.
4. *Олон улсын эрх зүй: Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын хамтын ажиллагаа эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл*, УБ, 2015 .
5. *Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэхэд тулгамдаж буй асуудал*, олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл, УБ, 2012.
6. *Олон улсын терроризм ба Монгол Улс*, Онол практикийн бага хурлын эмхэтгэл, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тамгын газар, УБ, 2004.
7. ХЗҮХ, “Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрийн хяналт, шинжилгээ, үнэлгээний тайлан”, УБ, 2008.
8. Б.Энх-Амгалан, “Олон улсын гэрээнд нэгдэн ороход судалгаатай хандах асуудал”, *Хууль дээдлэх ёс сэтгүүл*, №3 УБ, 2010.
9. ХЗҮХ, Мансууруулах эмийн ба сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлттэй тэнцэх талаар олон улсын стандарт бодлогын судалгаа, УБ, 2015.
10. ХЗҮХ, “Эрх зүйн шинэтгэлийн бодлогын баримт бичиг боловсруулахад дэмжлэг үзүүлэх нь” судалгааны Хавсралт тайлан 1, УБ, 2016.
11. *Хар тамхины гэмт явдал шалтгаан, нөхцөл, урьдчилан сэргийлэх арга зам* эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл УБ, 2018.
12. Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн танилцуулга, УБ, 2022.

13. Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал, УБ, 2022.
14. Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээний тайлан, УБ, 2022 .

Гадаад эх сурвалж

Судалгааны өгүүлэл, эмхэтгэл

1. A/HRC/16/48/Add.3, Report of the Working Group on Enforced or Involuntary Disappearances, 2010.
2. A/HRC/7/2/Add.2
3. A/HRC/7/2, para. 26, General comment on the definition of enforced disappearance.
4. Concluding observations on the report submitted by Mongolia under article 29 (1) of the Convention : Committee on Enforced Disappearances, UN. Committee on Enforced Disappearances (20th sess. : 2021 : virtual)
5. WGEID, Best Practices on Enforced Disappearances in Domestic Criminal Legislation, supra note 5
6. Common wealth, Chapter Two, Convention on offences and certain other acts committed on board aircraft 1963, ('Tokyo Convention')
7. Common wealth, Chapter Three, convention for the suppression of unlawful seizure of aircraft 1970 ('hague convention')
8. Common wealth, Chapter Four, Convention For The Suppression Of Unlawful Acts Against The Safety Of Civil Aviation 1971 ('Montreal Convention'),
9. Common wealth, Chapter Five, Protocol for the suppression of unlawful acts of violence at airports serving international civil aviation 1988 ('Montreal Protocol'),
10. International Civil Aviation Organization, Special Sub-Committee on The Preparation of One or More Instruments Addressing New and Emerging Threats Montréal, 3–6 July 2007, Report
11. Jung, Sung Yool, A Legal Analysis of Aviation Security under the International Legal Regime, (2005), A thesis submitted to McGill University in partial fulfillment of the requirements of the degree of Master of Laws (LL.M.)
12. Vijay Kumar Singh, Trends in Safety and Security Regulations of Civil Aviation (Paper Presented at the Seventh International Conference on "Legal Regime of Sea, Antarctica, Air and Space" organized by Indian Society of International Law, New Delhi from 15-17 January 2010)
13. Sayef Amin, Tokyo Convention: Offence, Jurisdiction (Include cases), Air And Aviation Law, Southeast University Department of Law & Justice LLM Final) - Program. Course Title: International Air and Aviation Law Course Code: LMF 3223, Section: A LLM (Final) – Program Date of Submission: 27/08/2013
14. International Conference on Air Law, Montreal, September 1971, Vol II, Documents CUI Doc No 4, Second Meeting Commission of the Whole, Thursday 9 September 1971, ICAO Doc 9081-LC/170-1.
15. Williams R. 1976. Keywords. A vocabulary of culture and society, Oxford: Oxford Univ. Press
16. Bufacchi, Vittorio. (2005). Two Concepts of Violence. Political Studies Review. 3.

17. Thomas, C. S., and M. J. Kirby. "The Convention for the Suppression of Unlawful Acts against the Safety of Civil Aviation." *The International and Comparative Law Quarterly*, vol. 22, no. 1, 1973
18. Legal Committee Working Draft No. 782
19. Abraham Abramovsky, "Multilateral Conventions for the Suppression of Unlawful Seizure and Interference with Aircraft, Part II: The Montreal Convention" (1975) 14 *Colum. J. Transnat'l L.* 268 at 295.
20. Mc Whinney, Edward, *Aerial Piracy and International Terrorism, The illegal Diversion of Aircraft and International Law*, 2nd ed. (Dordrecht, the Netherlands; Boston:Martinus Nijhoff, 1987).
21. Shubber, Sami. "Aircraft Hijacking under the Hague Convention 1970: A New Regime?" *The International and Comparative Law Quarterly*, vol. 22, no. 4, [Cambridge University Press, British Institute of International and Comparative Law], 1973
22. Rafat, Amir. "Control Of Aircraft Hijacking: The Law Of International Civil Aviation." *World Affairs*, vol. 134, no. 2, World Affairs Institute, 1971
23. Legal committee, 17th session
24. R.H. Mankiewicz, comments on The 1970 Hague Convention, Symposium on Hijacking (1971) 37 *J.A.L.C* 199.

Цахим эх сурвалж

1. International commission of Jurists, No More "Missing Persons": The Criminalization of Enforced Disappearance in South Asia, August 2017, <https://www.icj.org/wp-content/uploads/2017/08/South-Asia-Enforced-Disappearance-Publications-Reports-Thematic-Reports-2017-ENG.pdf>
2. Parliamentary assembly, Council of Europe, AS/Jur (2011) 45, 4 November 2011, ajdoc45 2011, Committee on Legal Affairs and Human Rights, The International Convention for the Protection of all Persons from Enforced Disappearances, Report Rapporteur: Mr Christos Pourgourides, Cyprus, Group of the European People's Party, <http://assembly.coe.int/committeedocs/2011/ajdoc45.pdf>
3. Чингэлтэй дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол, 2022.03.11, дугаар: 2022/ШЦТ/227, https://shuukh.mn/single_case/64666?daterange=2000-01-01%20-%202022-04-17&id=1&court_cat=2&bb=1
4. <https://www.jstor.org/stable/758272?read-now=1&refreqid=excelsior%3Af48075e01ba309d928fc79bfa5d94ed6&seq=2>
5. <https://mcaa.gov.mn/wp-content/uploads/2021/09/AC01-0-Annex-interpretation-summary-01.Apr .2022.pdf>
6. <https://mcaa.gov.mn/wp-content/uploads/2018/03/AC-01-1-R.1.6.pdf>
7. <https://legislative.gov.in/sites/default/files/A1982-66.pdf>
8. <https://www.cairn.info/revue-inflexions-2016-1-page-205.htm>
9. https://www.aviation.govt.nz/assets/rules/consolidations/Part_001_Consolidation.pdf
10. <https://digitallibrary.un.org/>

11. <https://deliverypdf.ssrn.com/delivery.php?ID=508086097113083111073007081070084113049050018065023030127118006097116125127096115089060053008103037029119007123085118031084101061041040055013065092064071071085010069017010086007110110003108006122090007070106122116067092103120027077077072029126094086094&EXT=pdf&INDEX=TRUE>
12. <https://www.unodc.org/e4j/zh/terrorism/module-4/key-issues/criminal-justice-responses.html>
13. https://www.cambridge.org/core/search?q=suppression+of+unlawful+acts&_csrf=kzDnu7an-zHqF2-5aeqCPwZMg6Do9SnuWXvs
14. https://www.jstor.org/stable/758272?searchText=convention+for+safety+of+civil+aircraft&searchUri=%2Faction%2FdoBasicSearch%3FQuery%3Dconvention%2Bfor%2Bsafety%2Bof%2Bcivil%2Baircraft%26so%3Drel&ab_segments=0%2F5YC-6294%2Fcontrol&refreqid=fastly-default%3Ae8ba15450f6117dba1b1b4ef43af53e1&seq=7
15. https://www.icao.int/secretariat/legal/LC34_Docs/LC_SC-NET_Report_en.pdf
16. <https://www.scrip.org/journal/paperinformation.aspx?paperid=88515>
17. <https://www.annualreviews.org/doi/pdf/10.1146/annurev.an.23.100194.00054>
18. <https://scholar.smu.edu/cgi/viewcontent.cgi?article=1588&context=jalc>
19. <https://www.icao.int/Meetings/LC36/Working%20Papers/LC%2036%20-%20WP%202-4.en.pdf>
20. https://brill.com/view/book/edcoll/9789004345140/B9789004345140_018.xml
21. <http://www.ghlaw.gr/docs/beijingconandprotocols.pdf>
22. <http://www.parliament.go.ke/sites/default/files/2019-06/MONTREAL%20PROTOCOL%20REPORT%204.6.2019.pdf>
23. <https://qmro.qmul.ac.uk/xmlui/bitstream/handle/123456789/64713/Bernard%20Taking%20Air%20Passenger%20Rights%20Seriously:%20the%20Case%20Against%20the%20Exclusivity%20of%20the%20Montreal%20Convention%202020%20Accepted.pdf?sequence=2>
24. https://central.bac-lac.gc.ca/.item?id=TC-QMM-82661&op=pdf&app=Library&oclc_number=894086808
25. https://legal.un.org/ilc/documentation/english/reports/a_47_10.pdf

Хавсралт

Д/д	ОУ-ын гэрээ	Хэм хэмжээ	ЭХ-д тусгагдсан				Огт тусгаагүй	Хэл зүй, найруулгын шаардлага хангасан эсэх (Нэр томьёо, үг хэллэг)	
			Бүрэн	Бүрэн бус	Өргөжүүлсэн	Зөрчилтэй			
1.	Хүчээр алга болгохоос бүх хүнийг хамгаалах тухай ОУ-ын конвенц	2 дугаар зүйл Энэхүү конвенцийн зорилгод “хүчээр алга болгох” гэдэг нь алга болсон аливаа хүний эрх чөлөөг хассан явдлыг хүлээн зөвшөөрөхөөс татгалзсан буюу түүний хувь заяаны талаарх мэдээлэл, эсхүл оршин суугаа газрыг нуусны улмаас тухайн хүнийг хуулийн хамгаалалт эдэлж чадахааргүй байдалд хүргэхүйцээр төрийн төлөөлөгчид буюу төрөөс эрх олгогдсон, дэмжлэг буюу зөвшөөрөл авсан этгээдүүд, эсхүл бүлэг этгээдийн тухайн хүнийг баривчлах, саатуулах, хулгайлах, эсхүл бусад хэлбэрээр эрх чөлөөг нь хасахыг хэлнэ.		+				“whereabouts” нэр томьёог тухайн хүний байгаа газар гэсэн агуулгаар өөрчлөн буулгах нь зүйтэй. “Конвенц” гэдэг үгийг “Төрийн мэдээлэл” сэтгүүлд 2 янз бичсэнийг залруулах шаардлагатай.	
		6 дугаар зүйл Оролцогч улс бүр наад зах нь дараах этгээдэд эрүүгийн хариуцлага ногдуулах зорилгоор шаардлагатай арга хэмжээ авна: (а) хүчээр алга болгох үйлдлийг гүйцэтгэсэн, түүнийг гүйцэтгэхийг тушаасан, турхирсан буюу өдөөсөн, гүйцэтгэхийг сэдсэн, түүнд оролцсон буюу хамтарч гүйцэтгэсэн аливаа этгээд;	+						
		(b) дарга нь, хэрэв: i) түүний хяналт, удирдлаган дор бодитойгоор харьяаллагддаг ажилтан нь хүчээр алга болгох гэмт хэрэг үйлдсэн, эсхүл үйлдэхээр завдсан гэдгийг мэдэж байсан, эсхүл энэ талаарх тодорхой мэдээллийг санаатайгаар үл тоомсорлосон бол;						+	
		ii) хүчээр алга болгох гэмт хэрэгтэй холбоотой үйл ажиллагааны хувьд						+	

		бодит хариуцлага хүлээж байсан, эсхүл бодит хяналт тавьж байсан бол;						
		iii) хүчээр алга болгох үйлдлийг өөрийн эрх мэдлийн хүрээнд таслан зогсоох буюу түүнээс урьдчилан сэргийлэх, эсхүл мөрдөн байцаалт буюу эрүүгийн мөрдөн мөшгөлт хийлгэхээр уг асуудлыг эрх бүхий байгууллагад шилжүүлэх талаар бүхий л шаардлагатай болон боломжит арга хэмжээ аваагүй бол хамаарна.					+	
		7 дугаар зүйл 1. Оролцогч улс бүр, хүчээр алга болгох гэмт хэргийн онц ноцтой шинжийг харгалзан зохих шийтгэл ногдуулах					+	
2.	Агаарын хөлгийн бүхээгт үйлдсэн гэмт хэрэг болон тодорхой бусад үйлдлийн тухай конвенц	1 дүгээр зүйл (a) ЭХ-ийг зөрчсөн гэмт хэрэг;	+					
		(b) гэмт хэрэг мөн эсэхээс үл шалтгаалан агаарын хөлөг, түүний дотор байгаа хүмүүс, эд хөрөнгө, түүнчлэн агаарын хөлгийн дотоод сахилга, дэг журамд аюул учруулсан хийгээд учруулж болзошгүй үйлдэл.		+				
3.	Агаарын хөлгийг хууль бусаар булаан авах үйлдлийг хориглох тухай конвенц	1 дүгээр зүйл (a) хууль бусаар хүч хэрэглэх буюу хүч хэрэглэхээр заналхийлсэн, эсхүл айлган сүрдүүлэх бусад хэлбэрээр агаарын хөлгийг булаан авсан, эсхүл хяналтаа тогтоосон, эсхүл ийм үйлдэл хийхийг завдсан, эсхүл		+	Субъектийн хувьд өргөжүүлсэн.		+	
		(b) ийм үйлдлийг үйлдсэн, эсхүл үйлдэхийг завдсан этгээдтэй хамтран оролцсон аливаа этгээдийг гэмт хэрэг үйлдсэн гэж үзнэ.	+					
		2 дугаар зүйл Хэлэлцэн тохирогч улс бүр дурдсан гэмт хэрэгт хүнд ял оногдуулах үүрэг хүлээнэ.	+					

4.	Иргэний нисэхийн аюулгүй байдлын эсрэг хууль бус үйлдлийг хориглох тухай Монреалийн конвенц	(a) нислэг үйлдэж буй агаарын хөлгийн бүхээгт яваа хүний эсрэг хүч хэрэглэсэн бөгөөд энэ нь агаарын тухайн хөлгийн аюулгүй байдалд аюул учруулахаар байвал;		+	Зүй бусаар харилцсан гэдэг нь хэтэрхий өргөн агуулгатай байна.	+	Use of force, use of violence нэр томъёог конвенц болон хуульд “хүч хэрэглэх” болон “хүчирхийлэх” зэргээр ялгамжтай оруулах; ЭХ-ийн 1 бүлгийн гэмт хэргүүд болох 27.4.2 болон 27.1.1 дүгээр зүйлд хүний эрүүл мэнд, амь насанд хохирол учрах, аюул учрах зэргээр ялгаатай илэрхийлсэн.		
		(b) нислэг хийх боломжгүй болгох буюу нислэгийн үед аюул учруулахуйц байдлаар ашиглалтад байгаа агаарын хөлгийг бүр мөсөн эвдсэн, эсхүл түүнд гэмтэл учруулсан;		+		+		“Destroy” гэдэг үгийг Конвенцийн орчуулгад “бүрмөсөн эвдсэн” гэж хүч нэмэгдүүлсэн үгээр орчуулсан нь оновчгүй юм.	
		(c) ашиглалтад байгаа агаарын хөлгийг эвдэх, эсхүл түүнийг бүрмөсөн эвдэх буюу нислэг үйлдэх боломжгүй болохуйц хохирол учруулахаар гэмтээх чадалтай төхөөрөмж, бодисыг ямар нэг аргаар байрлуулах буюу байрлуулахад чиглэсэн үйл ажиллагаа явуулсан;						+	
		(d) агаарын навигацын тоног төхөөрөмжийг эвдсэн, гэмтээсэн, эсхүл түүний ашиглалтад саад учруулсан бөгөөд аливаа иймэрхүү үйл ажиллагаа нь агаарын хөлгийн нислэгийн аюулгүй байдалд аюул учруулсан;		+					Нисэхийн аюулгүй байдал “air safety” гэх нэр томъёог “air security”-ээс ялгаж аюулгүй ажиллагаа, аюулгүй байдал, аюулгүй хамгаалалт зэрэг ойлголтуудыг цэгцлэх; ¹⁴⁴
		(e) худал гэдгийг нь мэдсээр байж агаарын хөлгийн нислэгт аюул учруулж болохуйц мэдээлэл өгснийг тус тус гэмт хэрэг үйлдсэн гэж үзнэ.	+					+	
		2. Хэрэв аливаа этгээд дараах үйлдлийг гүйцэтгэсэн бол түүнийг гэмт хэрэг үйлдсэн гэж бас үзнэ: (a) энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэргийг үйлдэхээр завдсан;	+						

¹⁴⁴ Конвенцид заасан гэмт хэрэгт нийтлэг хамаарна.

		(b) ийм гэмт хэрэг үйлдсэн буюу үйлдэхийг завдаж байгаа этгээдийн үйлдэлд хамтран оролцсон.	+					
		3 дугаар зүйл Хэлэлцэн тохирогч улс бүр энэхүү конвенцийн 1 дүгээр зүйлд дурдсан гэмт хэрэгт хүнд ял оногдуулах үүрэг хүлээнэ.					+	
		4 дүгээр зүйл 1. Энэхүү конвенц нь цэрэг, гааль, цагдаагийн албанд ашигладаг агаарын хөлгийн хувьд хэрэглэхгүй.					+	
5.	Иргэний нисэхийн аюулгүй байдлын эсрэг хууль бус үйлдлийг хориглох тухай монреаль хотноо 1971 оны 9 дүгээр сарын 23-ны өдөр үйлдсэн конвенцийн ОУ-ын иргэний нисэхэд үйлчилдэг нисэх буудал дахь хүчирхийлсэн хууль бус үйлдлийг хориглох тухай нэмэлт протокол	2 дугаар зүйл (a) ОУ-ын иргэний нисэхэд үйлчилдэг нисэх буудал дахь хүний эсрэг хүчирхийлсэн үйлдэл үйлдсэн бөгөөд энэ нь түүнд хүнд гэмтэл учруулсан, амь насыг нь хохироосон, эсхүл хүнд гэмтэл учруулж буюу амь насыг нь хохироож болзошгүй байдалд хүргэсэн бол; эсхүл					+	Конвенцийн орчуулгад агаарын хөлгийг <u>бүр мөсөн эвдсэн</u> гэж, харин протоколын орчуулгад агаарын хөлгийг <u>эвдсэн</u> гэж орчуулсан байна. Мөн <i>damages</i> гэсэн үгийг агаарын хөлгийг “гэмтээсэн” эсхүл “хохирол учруулсан” гэж өөр өөрөөр орчуулсан.
		(b) ОУ-ын иргэний нисэхэд үйлчилдэг нисэх буудлын төхөөрөмж буюу уг нисэх буудал дахь ашиглалтад бус байгаа агаарын хөлгийг устгасан буюу ноцтой гэмтэл учруулсан, эсхүл нисэх буудлын ажиллагааг тасалдуулсан.					+	

6.	Мансууруулах эмийн тухай нэгдсэн конвенц	1. а) Тал бүр энэхүү конвенцийн заалтуудыг зөрчиж мансууруулах эм тарималжуулах, үйлдвэрлэх, бэлтгэх, гаргаж авах, бэлдэх, эзэмших, санал болгох, худалдахаар санал болгох, түгээх, худалдан авах, худалдах, аливаа нөхцөлөөр хүргүүлэх, зуучлах, илгээх, дамжин өнгөрүүлэн илгээх, тээвэрлэх, импортлох болон экспортлох, түүнчлэн тухайн талын үзэж байгаагаар энэхүү конвенцид харш байж болох аливаа бусад үйлдлийг санаатайгаар үйлдсэн бол шийтгэвэл зохих гэмт хэрэг гэж үзэх, мөн ноцтой гэмт хэрэгт тохирох шийтгэл, тухайлбал хорих буюу эрх чөлөөг нь хасах бусад шийтгэл хүлээлгэх явдлыг хангах арга хэмжээг өөрийн үндсэн хуулийн хязгаарлалтыг харгалзан авна.	+	+			+		
		2. Аль нэг талын үндсэн хуулийн хязгаарлалт, эрх зүйн тогтолцоо, дотоодын хуулийг харгалзан: а) i) 1 дэх хэсэгт жагсаасан гэмт хэрэг бүрийг хэд хэдэн оронд үйлдсэн бол тусдаа гэмт хэрэг гэж үзнэ;						+	
		ii) тэдгээр гэмт хэргийн аль нэгийг үйлдэхэд санаатайгаар хамтран оролцох, үйлдэхээр үгсэн тохиролцох, завдах, түүнчлэн энэ зүйлд дурдсан гэмт хэрэгт холбогдуулан бэлтгэх үйлдэл хийх болон санхүүгийн үйл ажиллагаа явуулах нь 1 дэх хэсэгт заасны дагуу шийтгэвэл зохих гэмт хэрэг болно;		+					
7.	Сэтгэцэд нөлөөлөх бодисын конвенц тухай	22 дугаар зүйл 1. а) Тал бүр энэхүү конвенцийн дагуу хүлээх үүргээ биелүүлэх үүднээс батласан хууль буюу журамд харш, санаатайгаар үйлдсэн аливаа үйлдлийг шийтгэвэл зохих гэмт хэрэг гэж үзэх бөгөөд ноцтой гэмт хэрэгт тохирох шийтгэл, тухайлбал хорих буюу эрх чөлөөг нь хасах бусад шийтгэл хүлээлгэх явдлыг өөрийн үндсэн хуулийн хязгаарлалтыг харгалзан хангана.		+			+		
		2. ii) тэдгээр гэмт хэргийн аль нэгийг үйлдэхэд санаатайгаар хамтран оролцох, үйлдэхээр үгсэн тохиролцох, завдах, түүнчлэн энэ зүйлд дурдсан гэмт хэрэгт холбогдуулан бэлтгэх үйлдэл хийх болон санхүүгийн үйл ажиллагаа явуулах нь 1 дэх хэсэгт заасны дагуу шийтгэвэл зохих гэмт хэрэг болно;		+					
8.	Мансууруулах эм,	3 дугаар зүйл	+				+	Конвенцийн орчуулгад 3.4 дэх	

сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг нэгдсэн үндэстний байгууллагын конвенц	1. Тал бүр санаатайгаар үйлдэгдсэн дараах үйлдлийг дотоодынхоо хуулийн дагуу эрүүгийн гэмт хэрэг гэж тогтоох арга хэмжээ авна: а) i) 1961 оны конвенц, нэмэлт өөрчлөлт оруулсан уг конвенц болон 1971 оны конвенцийн заалтыг зөрчиж аливаа мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисыг үйлдвэрлэх, бэлтгэх, гаргаж авах, бэлдэх, санал болгох, худалдахаар санал болгох, түгээх, худалдах, ямар ч нөхцөлөөр хамаагүй хүргэх, зуучлах, илгээх, дамжуулан өнгөрүүлж илгээх, тээвэрлэх, экспортлох, импортлох;						хэсэг дэх “ял ногдуулахаар зааж болно” гэж үндсэн агуулгаас өөрөөр орчуулсан.	
	ii) 1961 оны конвенц, нэмэлт, өөрчлөлт оруулсан уг конвенцийн заалтыг зөрчиж мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисыг үйлдвэрлэх зорилгоор опиумын намуу, кока бут, каннабис ургамлыг тарималжуулах;			+				
	iii) (i) дэд хэсэгт заасан аливаа үйл ажиллагааг явуулах зорилгоор мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисыг хадгалах, худалдан авах;		+					
	iv) мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисыг тарималжуулах, үйлдвэрлэх эсхүл бэлтгэхэд зориулагдсаныг мэдсээр байж I хүснэгт, II хүснэгтэд заасан тоног төхөөрөмж, эд зүйлс, бодисыг бэлтгэх, тээвэрлэх, түгээх;		+					
	v) (i), (ii), (iii), (iv) дэд хэсэгт тодорхойлсон гэмт хэргийг удирдах, санхүүжүүлэх,		+					
	(b) i) аливаа гэмт хэрэг болон энэ хэсгийн (a) дэд хэсгийн дагуу тогтоосон гэмт хэрэг үйлдсэний үр дүнд бий болсон, эсхүл дурдсан гэмт үйлдэлд оролцсоны үр дүнд бий болсон хөрөнгө гэдгийг мэдсээр байж хөрөнгийн хууль бус эх үүсвэрийг халхавчлах, нуун дарагдуулах болон гэмт хэрэг үйлдсэн аливаа этгээдэд гэмт үйлдлийнхээ эрх зүйн үр дагавраас зайлсхийхэд нь туслах зорилгоор уг хөрөнгийг хувиргах, шилжүүлэх;	+						
	(c) Үндэсний хууль тогтоомжийнхоо заалтууд, эрх зүйн тогтолцооныхоо гол зарчмуудыг баримтлан: i) энэ хэсгийн (a) дэд хэсгийн дагуу тогтоосон гэмт хэрэг болон гэмт хэргүүд, эсхүл тухайн гэмт хэрэг болон гэмт хэргүүдэд оролцсон үйлдлийн улмаас бий болсон хөрөнгийг хүлээж авахдаа энэ тухай мэдсээр байж олж авсан, эзэмшсэн,	+						

	хэрэглэсэн;						
	ii) I хүснэгт, II хүснэгтэд заасан тоног төхөөрөмж, эд зүйлс болон бодисыг аливаа мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисыг хууль бусаар тарималжуулах, үйлдвэрлэхэд ашиглаж байгаа, эсхүл тийм зорилгоор ашиглахад зориулагдсан болохыг мэдсээр байж эзэмших;						+
	iii) энэ зүйлийн дагуу тогтоосон аливаа гэмт хэргийг үйлдэх, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисыг хууль бусаар хэрэглэхэд олон нийтийг аливаа хэлбэрээр өдөөн хатгах, уриалах;	+					
	iv) энэ зүйлээр тогтоосон аливаа гэмт хэргийг үйлдэхэд оролцсон, холбогдсон, үйлдэхээр үгсэн тохиролцсон, үйлдэхийг завдсан, түүнчлэн үйлдэх үед хамжсан, хатгасан, дэмжлэг үзүүлсэн эсхүл зөвлөгөө өгсөн.	+					
	2. Тал бүр Үндсэн хуулийнхаа заалтууд, эрх зүйн тогтолцооныхоо зарчмыг баримтлан 1961 оны конвенц, нэмэлт өөрчлөлт оруулсан 1961 оны конвенц, 1971 оны конвенцийг зөрчиж аливаа мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисыг хувийн хэрэгцээнд зориулж санаатайгаар хадгалах, олж авах, тарималжуулахыг дотоодын хуулийнхаа дагуу гэмт хэрэг гэж тогтооход шаардлагатай байж болох арга хэмжээ авна.		+				
	5. Талууд дараах нөхцөл байдлыг тэдгээрийн шүүх болон хэргийн харьяалал тогтоосон эрх мэдэл бүхий байгууллагуудаас 1 дэх хэсэгт заасны дагуу тогтоосон гэмт хэргийг үйлдэхэд нөлөөлсөн хүндрүүлэх нөхцөл байдал гэж үзэх явдлыг хангана:	+					
	а) гэмт этгээд өөрийн харьяалагддаг зохион байгуулалттай гэмт бүлгийн үйлдсэн гэмт хэрэгт оролцсон;						
	б) гэмт этгээд ОУ-ын чанартай бусад төрлийн зохион байгуулалттай гэмт үйл ажиллагаанд оролцсон;						+
	с) гэмт этгээд тухайн гэмт хэргийг үйлдсэний улмаас хууль бус бусад үйл ажиллагаанд оролцсон;						+
	д) гэмт этгээд хүч, эсхүл галт зэвсэг хэрэглэсэн;						+
	е) гэмт этгээд албан тушаалтан бөгөөд тухайн гэмт хэрэг нь түүний албан тушаалтай холбоотой;		+				

		f) гэмт хэрэг үйлдэхэд насанд хүрээгүй хүмүүсийг татан оролцуулсан, эсхүл тэднийг ашигласан;					+	
		g) гэмт хэргийг хорих ял эдлүүлэх газар, сургууль, олон нийтийн үйлчилгээний газар эсхүл тэдгээрийн ойр орчинд, эсхүл сурагч, оюутны сургалт, спорт, олон нийтийн үйл ажиллагаа явуулдаг газарт үйлдсэн;					+	
		h) холбогдох талын дотоодын хуулиар зөвшөөрсөн хэмжээнд гадаад улсад болон эх орондоо урьд нь ял шийтгэгдсэн, ялангуяа ижил төрлийн гэмт хэрэгт ял шийтгэгдсэн.					+	